

Harvest
701 North First Street
Phoenix, Arizona 85004 U.S.A.
Утас: (480) 968-2600
www.harvestfoundation.org

Бичээсийг АРИУН БИБЛИ-с авж ашиглав.
Зохиогчийн эрх © 1973, 1978, 1984 олон улсын Библийн нийгэмлэгт хамаарна. Зохих зөвшөөрлийн дагуу ашиглав.

СУУРЬ ҮНДЭС
Зохиогчийн эрх © 1993 Харвестэд хамаарна.
2021 оны 8-р сард шинэчлэгдсэн хувилбар
Зохиогчийн эрх хамгаалагдсан. Ашиг олохоор борлуулж үл болно.
Албан бичгээр зөвшөөрөгдсөн тохиолдолд хувилан олшруулж болно.

Зохиогчийн зөвшөөрлөөр “Ариун Үндэс” чуулган эрхлэн гаргав.

Орчуулан хянасан Содномцэрэн

Сүүрь үндэс

Хоёрдугаар ном:
Бурханы дүр төрх



Христийн үйлилэлд амьдралаа зориулж явaa ахан дүүст
зориулсан дагалдаж бэлтгэх цогц сургалт

Харвэстын багийнхны бүтээл:

СУУРЬ ҮНДЭС Цогц бүрэн Дагалдагч бэлтгэл

Нэгдүгээр ном: Хаан Есүс

Хоёрдугаар ном: Бурханы дүр төрх

Гуравдугаар ном: Чуулган

Есүс Хотын Захирагч байсан бол:

Нутгийн чуулган ба хувьсан өөрчлөлт

Олон улсын хэвлэл

товчилсон хувилбар

***Хүсэл тань тэнгэрт шигээ газар дээр биелэх болтугай
(12-ангитай видео хичээл, дасгал ажлын дэвтэрийн хамт)***

Орон нутгийн хөгжилд чадавхжуулах нь

Хамтын ажиллагаанд суралцах

Удирдлагазүй

Төслийн менежмент

Цонх адил чуулган (video)

Цогц үйлчлэлийн сургалт

Нийгмийн асуудалд Христитгэгчдийн оролцоо

Библийн дагуух цогц үйлчлэл

Зарцын зүрх сэтгэл

Бурханы хаанчлал

Хаанчлалын математик

Чуулган цонх болох нь

Үр төслүүд

Хайрын сахилга бат

Карантагийн Хараа(video)

СУУРЬ ҮНДЭС ХОЁРДУГААР НОМ

Бурханы дүр төрх

Христийн үйлчлэлд амьдралаа зориулж яваа ахан дүүст зориулсан
дагалдагч бэлтгэх цогц сургалт

Хаанчлалыг тэлэх ажлын тусын тулд албан ёсны зөвшөөрөлгүйгээр
хувилж, иш татан ашиглаж болно.

Ашгийн төлөө зарж борлуулахыг хориглоно.
Бичгийн зөвшөөрлийн дагуу орчуулж, өөрчилж болно.

Библийн ишлэлүүдийг АРИУН БИБЛИЭС авав.
Зохиогчийн Эрх © 1973, 1978, 1984 Олон Улсын Библийн Нийгэмлэг.
Зөвшөөрлийн дагуу ашиглав.
Бүрнээрээ тавигдсан магтуу нь нийтийн эзэмшил болно.

СУУРЬ ҮНДЭС

Христиин үйлчлэлд амьдралаа зориулж яваа ахан дүүст зориулсан
дагалдгач бэлтгэх цогц сургалт

Хоёрдугаар боть: Бурханы дүр төрх
Зохиогчийн эрх © 2005 Ургац байгууллага
Энэтхэгт хэвлэв

Зохиогч: Робин Стийн
Талбарын туршигчид: Дэлхий Даяарх Ургацын Ажилчид
Хавтас болон дасгал ажлын дэвтрийн загварыг: Брайн Гаммил
Эрхлэгч: Карла Тэш
Хавсралт зургуудыг: Робин Стийн, Бабеть Вүүд

Энэхүү номын талаар болон бусад
материалуудын талаар лавлах бол:
Harvest
Шуудангийн хайрцаг 2670
Phoenix, AriZona 85002-2670 USA
Утас: (602) 258-1083

Ургацын хичээлийн материалуудыг англи болон
бусад хэл дээр вэб сайтаас татах авах бол:
www.harvestfoundation.org

*Биднийг дүр төрхийнхөө дагуу бүтэээж
дүр төрхтэйгөө адил болгон өөрчилж,
дүр төрхөө тусган харуулахын тулд
бидэнд шаардлагатай бүхнийг өгдөг
Бурханд бүх алдар магтаал нь
байх болтугай.*

Дагалдуулагч хүний хамгийн чухал чанар

Нэгэн өдөр теологич Карл Барт оюутнууддаа амжилттай пастор байх нууцыг талаар хичээл заахаар болжээ. Оюутнууд хэлэх үгийг нь тэмдэглэж авахаар дэвтрүүдээ гаргахад нь тэрээр дэвтрүүдээ далд хий та нар хэзээ ч мартахгүй гэжээ.

Түүний нууц нь гурван хэсэгтэй. Амжилттай пастор байх эхний нууц нь: “Хүмүүсээ хайрлах”. Хоёр дахь нь: “Хүмүүсээ хайрлах.” Гурав дахь нь! Та нар таачихлаа! “Хүмүүсээ хайрлах.”

Амжилттай дагалдагч бэлтгэхийн тулд мөн адил. Таны заах арга барил, материалууд ямар сайн байх нь хамаагүй. Хэрэв та дагалдагчдаа л хайрлахгүй бол та үр дүнтэй дагалдуулагч байж чадахгүй.

Та сайн дагалдуулагч баймаар байна уу!

“Дагалдагчдаа хайрла!”

Гарчиг

СУУРЬ ҮНДЭСТ тавтай морилно уу – Өвөрмөц дагалдагч бэлтгэл хi
Суралцахуй..... xii

СУУРЬ ҮНДЭС II ХИЧЭЭЛ

Гол хичээл	1
1. Бурханы дүр төрх.....	9
2. Эхэнд Бурхан.....	19
3. Бурхан бүхнийг захирдаг.....	27
4. Эцгийн зүрх сэтгэл.....	37
5. Бурхан уучилдаг.....	47
6. Бурхан тэвчээртэй.....	57
7. Бурхан бол ариун.....	67
8. Нэг нэгдмэл байдал ба гурвал.....	77
9. Сүнсээр дүүрэн байх нь.....	87
10. Ариун Сүнсний ажил.....	97
11. Бурхан ба үл үзэгдэх ертөнц.....	107
12. Миний доторх Бурханы дүр төрх.....	119

ДАГАЛДУУЛАГЧИЙН СУРАХ БИЧИГ

СУУРЬ ҮНДЭСийн талаар.....	131
----------------------------	-----

ДАГАЛДАГЧДЫН СУРАХ БИЧИГ

Судлах, хэрэгжүүлэх төлөвлөгөө ба хичээл бүрийн зураг, жишээ.....	140
Ишлэл цээжлүүлэх карт, судлал, хэрэгжүүлэлтийн нэмэлт ишлэлүүд....	188

СУУРЬ ҮНДЭСТ тавтай морилно уу

Өвөрмөц дагалдагч бэлтгэл

Эрхэм хүндэт Дагалдуулагч танаа:

Дагалдуулагч болохоор шийдэж, СУУРЬ ҮНДЭС номыг ашиглахаар болсонд тань талархал илэрхийлье.

СУУРЬ ҮНДЭСийн эхний номноос та дагалдагч бэлтгэх тусгай хичээлтэй хэдийнээ танилцсан байж болох юм. Эс бөгөөс бид таныг СУУРЬ ҮНДЭСТ урьж байна. Энэ нь өсөж буй шинэ итгэгчдийг Библийн дагуух бүрэн цогц амьдралд дагуулахад ашиглагдах багаж билээ!

СУУРЬ ҮНДЭС нь Бичээсийн талаар мэдлэгтэйгээс гадна Бурханы хайлрадаг ертөнцөд Өөрийнх нь дүр төрхийг өдөр тутмын амьдралаараа тусган харуулдаг дагалдуулагчдыг бий болгоход тусалдаг. Англи хэл дээр СУУРЬ ҮНДЭС гэсэн нь товчилсон үг ба “Христийн үйлчлэл доторх ахан дүүс” гэсэн утгатай. Гэвч СУУРЬ ҮНДЭС хэмээх нэрийн маань гол утга нь Христийг дагаж, Бурханыг хайллан, мөн бусдыгаа хайлрах “суурь үндэс”-ийг хэлж байгаа юм.

СУУРЬ ҮНДЭСийн цуврал хичээлүүд нь дараах байдлаараа онцгой:

- СУУРЬ ҮНДЭС бол цогц үйлчлэлийн аргачлал юм. Энэ нь Бурханы бүх бүтээлдээ хандсан зорилтыг чухалчилдаг.
- СУУРЬ ҮНДЭС нь Библид тулгуурладаг.
- СУУРЬ ҮНДЭСийг албан ёсны бус, жижиг эсийн бүлгүүдэд ашиглах боломжтой. “Дагалдуулагч” хүн бол туслагч болохоос анги танхимын багш биш; “дагалдагч” хүн бол идэвхтэй, оролцон суралцагчид юм.
- СУУРЬ ҮНДЭС нь хичээлд нэмэлт судалгаа, дадлагыг оруулдаг.
- СУУРЬ ҮНДЭС бол маш энгийн. Дагалдагчид сурсан зүйлээ хоёр хичээлийн хооронд хэрэгжүүлэх болно.

СУУРЬ ҮНДЭСийн хоёдугаар ном нь “Бурханы дүр төрх” гэсэн нэртэй, нийт арван хоёр хичээлээс бүрдсэн болно. Тэд Бүтээгчийн талаар, Бурханы Гурвал, Ариун Сүнс, Бурханы мөн чанар, сүнслэг ертөнц дэх Түүний захиргаа ба Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдснийг сурч, эдгээр үнэнийг амьдралдаа хэрэгжүүлэх боломжтой болох юм.

СУУРЬ ҮНДЭС II номоос та дараах зүйлсийг олох болно:

- СУУРЬ ҮНДЭС II Хичээлүүд: Үндсэн хичээл ба дагалдагч бэлтгэх арван хоёр хичээл
- Дагалдуулагчийн гарын авлага: СУУРЬ ҮНДЭС ба дагалдагч бэлтгэхэд туслах материалууд
- Сурах бичгийн гарын авлага: Дагалдагчдад шаардлагатай аргачлалууд Бурханы дүр төрхийг тусган харуулдаг дагалдагчдыг бэлтгэх явцад тань Эзэн таныг хөтлөх болтугай.

Жижиг бүлгийн ахлагч нарт өгөх зөвлөгөө

- Олон хүнийг хамруулахын тулд сандлаа тойрог хэлбрээр засна.
- Бүлгээ удирдах явцдаа зогсохын хэрэгтүй харин суух хэрэгтэй. Зааж өгөхийнхөө хажуугаар өөрөө мөн хамтран суралцаж, бүлгийг дэмж.
- Бичээсийн тухай болон холбоотой асуултуудын дагуу бүлгээрээ ярилцана.
- Яригдаж буй зүйлтэй холбоотой асуудлуудаа хуваалцах боломж дагалдагч нартаа гаргах хэрэгтэй.
- Чухал зүйл ярьж буй үедээ самбар дээр юм уу, эсвэл том цаасан дээр гол зүйлүүдийг нь бичиж бай.
- Нарийн сэдвүүдээр ярьж буй тохиолдолд бүлгээ хуваана. Дараа нь бусад бүлэгтэйгээ дүгнэлтүүдээ хуваалцах цаг гаргах хэрэгтэй.
- Санаагаа ойлгуулахын тулд зураг, диаграмм, объект болон түүхүүдийг жишээ болгон ашигла.
- Хариуг нь шууд хэлэхийн оронд сурч буй хүмүүсээ өөрсдөөр нь олуулбал сайн.
- Нуршуу байхаас зайлсхийж, тайлбараа цөөл. Харин оронд нь дагалдагчдаараа Бичээсээс уншиж, хэрэгжүүлсэн зүйлсийг нь тайлбарлуулах хэрэгтэй.
- Дагалдагчийнхаа хичээл бүрд оролцож буй байдлыг чухалчилж байгаагаа харуул – тэдний залбирал, санаа, идэвх оролцоо болон хэрэгжүүлэлт.
- “Буруу хариултуудыг” хэтэрхий засахаас болгоомжлох хэрэгтэй. Тэгэхгүй бол бүлгийн нээлттэй байдал болон хэлэлцүүлгэд саад учруулах боломжтой.
- Практик хэрэгжүүлэлтүүдийг гаргаж ирүүлэхэд дагалдагч нараа урамшуул.

Асуулт

- Хэлэлцүүлгийг үүсгэхийн тулд нээлттэй асуултуудыг тавих хэрэгтэй. “Тийм” эвэл “үгүй” гэсэн товч хариултад багтах асуултуудаас зайлсхий.
- Дасгал ажил, ишлэл судалсныхаа дараа дараах загвараар асуу:
 - ❑ Та нар юу харав, эсвэл юу сонсов?
 - ❑ Энэ нь юу гэсэн үг вэ?
 - ❑ Үүний талаар юу бодож байна?
 - ❑ Үүнийг хэрхэн хэрэгжүүлж болох вэ?

Дагалдуулагч хүний чанар

- Зааж буй зүйлийнхээ дагуу амьдарч дагалдагчдаа өөрийнхөө амьдралд оролцуулах хэрэгтэй.

- Үнэнийг олж мэдэхэд бусдыг урамшуулна.
- Хичээлийн цагуудын хооронд тайлбарлах, баяжуулах, урамшуулах, зөвлөх болон үлгэр жишээ харуулах хувийн цаг гарга.
- Сүнсний хувьд ч, оюун санааны хувьд ч хичээлээ заахад бэлэн бай. Судалгаа, эргэцүүлэл болон залбирлын цагийг Бурхантай хамт өнгрүүлдэг,
- Христийг дагах талаар өөрийн мэдэх зүйлээ хуваалцдаг хүн байна.

Хүннэйдэл



-
- Үндсэн хинеэлийн хөтөч
 - Dazaldagci бэлтгэх 12 хувиар
-

Гол хичээлийн хөтөлбөр

#

Дагалдуулагчид: СУУРЬ ҮНДЭСийн хичээл тус бүрийг үр дүнтэй байлгах үүднээс энэхүү үндсэн хичээлийн хөтөчтэй танилцаарай. СУУРЬ ҮНДЭСт хүмүүсийг үр бүтээлтэй суралцахад нь туслах зорилгоор судалгаан дээр үндэслэж гаргасан стандарт заах аргыг морддог.

Нэгдүгээрт, дагалдагчид хичээл тус бүрд шаардагдах материалыаар хангагдсан эсэхийг шалга:

- Хэрэв дагалдагчид тань СУУРЬ ҮНДЭС II номтой бол хамгийн арын хуудсанд буй Сурах бичгийн хөтөлбөрийг гаргуул. (Өөрсдөөр нь судалгаа их хийлгэх үүднээс дагалдагчид зөвхөн энэ хураангуй хувилбарыг хичээлийн үеэр ашиглах болно.)
- Хэрэв дагалдагчид тань СУУРЬ ҮНДЭС II номгүй бол Сурах бичгийн

Хөтөлбөр болон Цээжлэх ишлэлийн хуудсыг тэдэнд хувилж өгөөрэй. СУУРЬ ҮНДЭСийн хичээл бүр зорилго, үр дүн гэдэг хэсгээр эхэлдэг:

ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Үр дүн 1
- Үр дүн 2

- Үр дүн нь дагалдагчдын сурах зүйлийг л тодотгоно. Тэдгээр нь дагалдагчдын юу ойлгож (мэдлэг), мөн юу хийхийг (зан авир) заадаг.
- Зорьсон үр дүнг бодит үр дагавартайгаа харьцуулснаар дагалдуулагчид хичээлээ дуусгасанд тооцно.

Залбирлаар эхлэх

Залбирлаар эхлэх нь аливаа зүйлийг залбирлаар эхлүүлж байх ёстойг харуулсан сануулга юм. Хичээлийн заавар дээр дурдсанаар:

- Нэг юм уу, хоёр дагалдагчаар залбирнуулж хичээлээ эхлэх хэрэгтэй.

Эхний хэдэн хичээл дээр дагалдагчдад жишээ харуулбал зүгээр:

- Бидэнд Өөрийн үнэнийг илчилсэнд нь талархаж Бурханыг магтах
- Үнэнийг олж мэдэн, хэрэгжүүлэхийн тулд зүрхнүүдийг нээж өгөхийг Ариун Сүнснээс гүйх
- Залбирлд хариулж өгснийх нь төлөө Эзэнд талархах
- Оролцогчдын хэрэгцээний төлөө гүйлт хүсэлтээ өргөх

Тойм

Тойм нь өмнөх хичээлийн хэрэгжүүлэлтийг дүгнэж, харахад тань тусална. Тойм нь гурван хэсгээс бүрдэнэ:

Хичээлийн тойм Хэрэгжүүлэлтээс олж авсан туршлага Дагалдуулагчийн ажиглалт

Хичээлийн тойм

Хичээлийн зааврын дагуу:

- Өмнөх хичээлийн гол санаануудыг давтах.

Зөвлөгөө:

- Өмнөх хичээлийг нь сануулахын тулд тухайн хичээл дээр ашигласан жишиг дурд.
- Өмнөх хичээлийн гол санаануудыг дагалдагчдаар дүгнүүлэх хэрэгтэй.
- Өмнөх хичээлийн Түлхүүр Ишлэлийг цээжээр хэлүүлэх хэрэгтэй.

Хэрэгжүүлэлтээс олж авсан туршлага

Хичээлийн зааврын дагуу:

- Нэг юм уу, хоёр дагалдагчаар туршлага солилцуулж, ижил төстэй талуудыг нь дүгнүүлнэ.

Зөвлөгөө:

- Хүн нэг бүрийг хэрэгжүүлэлтийнхээ талаар товчон хуваалцахыг уриална.
- Хэрэв бүлэг тань наймаас олон хүнтэй бол бүлгээ хуваана.
- Аль болох олон хүний гэрчлэлийг сонсож болохуйц хуваагаарай. Араас нь юм ярих хэрэггүй. Бүлгийнхэндээ бүгдэд нь хуваалцуулахаар нэг дагалдагчийг сонго.

Дагалдуулагчийн ажиглалт

Хичээлийн зааврын дагуу:

- Хэрэгжүүлэлтийнх нь талаар ажигласан, бодсон зүйлээ хуваалц.

Зөвлөгөө:

- Сурсан зүйлүүдийг нь хэрэгжүүлэхэд нь тусалж хичээл зүтгэлийг нь үнэл. Чармайлт гаргасан хүмүүсийг нь дурд. Шаардлагатай бол эвтэйхэн залруулж өг. Урмыг нь бүү мохoo.
- Хэрэв асуудалтай тулгарвал бүлгээрээ зөвлөлдөх хэрэгтэй.

Оршил

Хичээлийн оршил нь гурван хэсэгтэй:

- Дагуулах дасгал ажил**
- Суралцахад туслах асуултууд**
- Шилжилт**

Дагуулах дасгал ажил

Дагуулах дасгал ажил нь богино хэмжээний жүжиг, жишээ, дуу, эсвэл хичээлийн сэдвийг танилцуулах уншлага зэрэг нь байж болно. Хичээл бурд тодорхой заавар өгөгдсөн байгаа. Хувилж тараах материалыа эртнээс бэлдсэн байгаарай.

Хэрэв Дагуулах дасгал ажил тань жишээ, зураг бол дагалдагчдадаа сурах бичигт дээр аль хуудсан дээр байгааг нь хэлж өгөөрэй.

Судлахад туслах асуултууд

СУУРЬ ҮНДЭС нь хичээлийн аль хэсэгт явж буйг ойлгомжтой болгох үүднээс зурагт тэмдэг ихтэй. СУУРЬ ҮНДЭС мөн өөр өөр тодотголуудыг ашигладаг:

- Тойрог хэлбэртэй тодотголууд нь танд заавар, мэдээллүүдийг өгөх болно.
- Хайрцгууд нь судалгааны асуултуудыг тавина.
- Чакттай хайрцгууд нь бүлгээрээ сурах явцад гарч ирж болох хариу үйлдлүүдийг тэмдэглэсэн.

Судлахад туслах асуултууд нь дагуулах дасгал ажлаар танилцуулсан санаан дээр хэлэлцүүлэг үүсгэх өдөөлт болдог. Хичээлийн зааврын дагуу:

- Дасгал ажлыг судлахад нь туслах асуултуудыг дагалдагчдаас асуу.

Зөвлөгөө:

- Зааж өгөхдөө гурван асуулт ашигла. Өөр асуулт чөлөөтэй асуугаарай.
- Асуултууд нь дагалдагчид юу ажигласан, ямар сэдвийг танилцуулсан, библийн ямар зарчим харагдсан болон тэдэнтэй хэрхэн холбогдох буйг нь асуудаг.

Шилжилт

Хичээлийн зааврын дагуу:

- Оршлоос хичээл уруугаа хөтлөх тодорхойлолт хий.

Зөвлөгөө:

- Тодорхойлолтоо хичээлийн үеэр, эсвэл хоёр хичээлийн дундах дамжлага болгож ашигла.

Судлал

Түлхүүр ишлэл

Хичээл бүрийн түлхүүр ишлэл нь
хүйлаастай хүүдэст бичигдсэн байна.

Судлах хэсэг бол хичээлийн гол хэсэг нь буюу дагалдагчид Библиэс судлах цаг юм. Энэ нь Хичээлийн Хөтөлбөрт тусгагдсан юм (хичээлийн үеэр дагалдагчид ашигладаг хэсэг ба энэ нь номын хамгийн арын хуудсанд бий). Судалгаа нь хэд хэдэн хэсгээс бүрдэнэ:

Түлхүүр ишлэл ба Судлах асуултууд
Холбоотой ишлэлүүд ба судалгааны асуултууд
Батжуулалт
Дүгнэлт

Түлхүүр ишлэл

Энэ бол хичээлийн гол санааг хамгийн сайн тусгасан ишлэл юм.

- Түлхүүр ишлэлийг харахыг дагалдагч нартаяа хэлж. Өөрөө юм уу, эсвэл бүлгийнхээ нэг гишүүнээр, чангаар уншуулсны дараа судалгааны асуултуудыг тавих хэрэгтэй.

Судлах асуултууд

Судалгааны асуултууд нь түлхүүр ишлэлийн гол утга санааг хэлэлцэхэд нь бүлгийн гишүүдэд тусална. Хичээлийн зааврын дагуу:

- Асуултуудын дагуу товчхон хэлцүүлэг эхлүүл.

Зөвлөгөө:

- Дагалдагч нараас үзэл бодлыг нь асууна. Зөв хариултыг гаргуулах гэж зүтгэх хэрэггүй. Бусдаас “Та нар юу гэж бодож байна!” гэж асууж ярилц.
- Энэ цагийг таньж, мэдэхэд ашигла. Хичээлээ зааж эхлэх хараахан болоогүй байгаа.

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

Холбоотой ишлэлүүд нь түлхүүр ишлэл дээрээс задардаг. Дагалдагчдаар судалгаа хийлгүүлэхийн тулд эдгээрт ч бас зөвлөх судалгааны асуултуудыг тавина. Санагаа батлахын тулд дагалдагчид мөн бичээсийн өөр хэсгийг ашиглаж болно.

Хичээлийн зааврын дагуу:

- Судалгааны асуултыг ашиглан Бичээсийг судлахыг дагалдагчдад хэл. Оролцоог нь нэмэгдүүлэх үүднээс гурав дөрвөн хүнтэй бүлэгт хуваах хэрэгтэй.

Зөвлөгөө:

- Жижиг бүлэг бүрд Библийн болон бүлгийн ахлагч хэрэгтэй.
- Бүлгүүдээр ишлэл уншуулж, асуултад хариулахад бэлдүүлнэ.
- Тухайн бүлгийн ахлагчид нь дүгнэлтийг хэлнэ.
- Тэдний дүгнэлтийг самбар дээр юм уу, том цаасан дээр бичих хэрэгтэй.
- Олж мэдсэн зүйлээ үзэгдэхүйц зүйлээр тайлбарлавал тус болдог.
- Хариу үйлдлийг шүүмжлэхээс зайлсхий. Оронд нь өөр хөрвүүлэгтэй хүн байгаа эсэхийг асуу.
- Хариултуудын “зөв” эсвэл “бурууг” шүүн ярих хэрэггүй.
- Дагалдагчдад гарын авлага байхгүй тохиолдолд хичээлийн өмнө асуултуудыг бүгдэд харагдахуйц газар бичих хэрэгтэй.

Бататгал

Бататгал нь дагалдагчдын Библийн хэсгээс сурсан зүйлийг нь баталгаажуулахыг хэлнэ. Бататгал нь гурван хэсэгтэй: Дасгал ажиллах, цээжлээх ба гол санаануудаа эргэн давтах.

Дасгал ажлууд

Хичээлийн хэсгээс жүжигчилсэн тоглолт хийх тохирсон жишээ олох, магтан дуулах зэрэг нэмэлт материалууд нь дасгал ажил болно. Ийм дасгал ажлыг хийснээр хичээлийн заасан зүйлийг бататгах юм.

Хичээл бүрд тохирсон зааврууд өгөгдөнө. Хувилж, тараах материалуудаа эртнээс бэлдсэн байх хэрэгтэй.

Хэрэв Дагуулах дасгал ажил тань жишээ, зураг бол дагалдагчдадаа сурх бичгийн аль хуудсанд байгааг нь хэлж өгөөрэй.

Цээжлэх ажил

Хичээлийн зааврын дагуу:

- Хичээлийн хөтөлбөрт орсон цээжлэх ишлэлийн картуудыг ашиглан бүлгээрээ түлхүүр ишлэлүүдийг цээжлээрэй.

Зөвлөгөө:

- Ишлэл цээжлүүлэх хуудсыг хувилж, зузаан цаасан дээр хэвлэн тарааж өгнө. Дагалдагч бүрд хүрэлцэхүйц хангалттай хувилах хэрэгтэй. Хичээлийн энэ хэсэгт цээжлэх ишлэлийн картуудыг тарааж өгнө.
- Ишлэлийг бүлгээрээ давтах хэрэгтэй. Шаардлагатай бол ишлэлээ хэлц хэлцээр нь хувааж болно.
- Картaa харалгүйгээр хэдэн удаа хэлээд үз.

Дагалдагчдыг картаа гарч ойрхон байлгаж, хичээл хооронд харж, цээжилж байхыг уриалж байх хэрэгтэй.

Гол санаагаа давтах

Энэ бол ишлэлүүд, хэлэлцүүлэг болон дасгал ажлуудаас сурсан зүйлээ эргэн санах боломж юм

.Хичээлийн зааврын дагуу:

- Хичээлээс ойлгох гол зүйлийг дагалдагчдаас өөрсдөөс нь асуу. Тэднийг зөв хариулсан эсэхийг нь харуулахын тулд дараах жагсаалттай товчхон тулгах хэрэгтэй.

Зөвлөгөө:

- Хичээлээ хялбар болгохын тулд бэлдэхдээ энэ хэсгийг харж үзээрэй.
- Хэд хэдэн дагалдагчаар сурсан зүйлийг нь дүгнүүлэх хэрэгтэй. Ихэнх санааг гаргаж хэлтэл нь хэлцүүлгийг үргэлжлүүлнэ. Жагсаалттайгаа товчхон тулгаж орхисон санаа байгаа эсэхийг шалга.
- Хэлэлцүүлгийн үеэр дагалдагч наарт гол санаануудын жагсаалтыг уншиж өгөх юмуу харуулж болохгүйг анхаарна уу.

Дүгнэлт

Хичээлийн зааврын дагуу:

- Дүгнэлт тодорхойлолтыг уншиж өгөх эсвэл хичээлийг өөрийнхөө үгээр дүгнэх хэрэгтэй.

Хэрэгжүүлэлт

Эцэст нь хэрэгжүүлэлт гэдэг бол хичээлийн хамгийн чухал хэсэг! Энэ нь хичээлийн санааг ойлгосон дагалдагч наарт сурсан зүйлийнх нь дагуу нэг жижиг алхам хийхэд нь тусалдаг. Энэ нь таван хэсгээс бүрдэнэ. Эхнийх нь:

Загвар асуултууд . . .

... ба боломжит хариу үйлдлүүд

Дагалдагчдад хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг бодож олоход энэ нь туслах болно. Хичээл бүрд хэрэгжүүлэлтийн талаар асуулт асууж (□), мөн боломжит хариултуудыг өгнө (☒). Хичээлийн зааврын дагуу:

- Хичээлийг хувь хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох тал дээр нь туслаарай.

Зөвлөгөө:

- Хичээлийг хэрэгжүүлж болох арга замуудын талаар хэлцүүлэг хотөл.
- Шаардлагатай бол бүлэгт ганц нэг хариултыг жишээ болгож өг.
- Сурах бичгийн арын хуудсанд буй нэмэлт ишлэлүүдийг дагалдагч наарт харуулж, хувийн судалгаа, эргэцүүлэл, хэрэгжүүлэлтийг хийлгүүлэх хэрэгтэй.
- Энэхүү асуулт, хариултууд нь бүлгээрээ хэлэлцэх үед яригдах зүйлсийн

жишээ гэдгийг ойлгоорой. Бүлгийн талаарх мэдлэг дээрээ үндэслэж асуултуудыг өөрчилж болно.

Хувийн хариулт, шийдвэр

Энэ нь дагалдагчдыг хичээлээ хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар өөрсдөөр нь бодуулж, шийдүүлэх цаг юм. Хичээлийн зааврын дагуу:

- Хичээлийг ойрын үед хэрхэн амьдралдаа хэрэгжүүлж болох талаар өөрсдөөр нь бодуул.
- Дараагийн хичээлд орохынх нь өмнө хэрэгжүүлэх нэг аргыг сонгуулж, дараахыг хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөн дээр нь бичүүлнэ. Үүнд:
 - Юу хийх, хэзээ хийх
 - Хэнд хандсан байх (хөрш, найз, гэх мэт.)

Гүйлт хүсэлт

Энэ нь дагалдагчид хэн нэгэнтэй хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөгөө хуваалцаж, бие биенийхээ төлөө залбирах цаг юм. Хичээлийн зааврын дагуу:

- Дагалдагчдыг хоёр гурваар нь жижиглэн хуваагаад нэг нэгнийхээ төлөө, ялангуяа хэрэгжүүлэх төлөвлөгөөнийхөө төлөө залбирахыг уриал.

Шилжих асуулт

Энэ бол дараагийн хичээл дээр авч үзэх, хариулах ёсгүй, товчхон холбоос асуулт юм. Хичээлийн зааврын дагуу:

- Шилжих асуултыг тавина. Гэхдээ хариулах, хэлэлцэх хэрэггүй.

Төгсгөл

Хичээлийн зааврын дагуу:

- Хичээлээ залбирлаар өндөрлөнө. Гэхдээ өмнө нь бүх заавраа өгсөн байх хэрэгтэй.

Зөвлөгөө:

- Залбирал Хичээлийг нэг өгүүлбэрээр дүгнэж өгөөрэй.
- Түлхүүр ишлэлээ нэг давтаж, цээжлэх ишлэлийн картаа хэрхэн ашиглахыг нь дахин нэг сануул. Холбоотой ишлэлүүдийг нь ч бас эргэцүүлэхийг дагалдагч наарт уриалах хэрэгтэй.
- Хэрхэн хэрэгжүүлснийг нь дараагийн хичээл дээр дагалдагч нараар хуваалцуулж, хичээлийг хэрэгжүүлэх мэргэн ухаан, урам зориг, хүсэл эрмэлзэлтэй байхын төлөө залбир.
- Өөрөө юм уу, эсвэл дагалдагчдынхаа нэгээр төлөөлүүлж залбируулна. Улгэр жишээ харуул:
 - Хичээлийн үеэр Сүнсээрээ удирдсан Бурханд талархал өргө.
 - Сурсан зүйлийнхээ төлөө төлөө Бурханд таларх.
 - Сурсан зүйлээ хэрэгжүүлэхэд нь дагалдагчдад туслахыг Бурханаас гүй.

Босгон байгуулах

Хичээл хооронд дагалдагчид бие биенийхээ амьдралд чухал нөлөө үзүүлэх цаг нь босгон байгуулах цаг юм. Энэ нь дагалдагч бэлтгэлийн хамгийн чухал цаг байж болно! Хичээлийн заавар нь дараах хайрцагт бий:

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ: Дараагийн хичээл эхлэхийн өмнө:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж зөвлөгөө
- Хичээл бүрийн хооронд үзсэнээ хэрэгжүүлэх туршлага
 - (Дагалдагчид хэрэгжүүлэлтээ дараагийн хичээл дээр хуваалцахад бэлэн байх ёстой.)

Зөвлөгөө:

- Хичээл хооронд дагалдагч бүртэй нэгээс доошгүй удаа холбогдохыг хичээ. Хэрвээ биеэр уулзах боломжгүй бол утсаар, хувийн мэйлээр харилцаж болно. Хичээлийн хэрэгжүүлэлт дээр нь дагалдагч нарыг урамшуулах хэрэгтэй.
- Дагалдагч бэлтгэлийн үеэр дараах аргуудыг ашиглаж дагалдагчидтайгаа хувийн харилцаа тогтоогоо хэрэгтэй. Үүнд:
 - Гэрт нь, ажил дээр нь, сургууль дээр нь очиж уулзах.
 - Гэр бүл, найз нөхөд, холбоотой хүмүүсийг нь таньж мэдэх.
 - Өөрийнхөө хувийн амьдрал үйлчлэлийн тал дээр тэднээс зөвлөгөө авах, өөрийг тань ажиглах боломж олгох, хувийнхаа амьдралд оролцуулах зэрэг. Удахгүй үйлчлэлд ороход нь та тэднийг ажиглах болно. Энэ бол дагалдагч бэлтгэлийн явц!

Бурханы дүр төрх

ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- “Бурханы дүр төрх” гэдэг нь ямар утгатайг ойлгоно.
- Христ бол Бурханы дүр төрх гэдгийг мэдэж авна.
- Хүн төрөлхтөн Бурханы дүр төрхийн дагуу
- бүтээгдсэн гэдгийг харна.
- Гэм нь бидний доторх Бурханы дүр төрхийг устгадгийг ухаарна.
- Христ доторх шинэ амьдрал үүнийг сэргээдгийг ойлгоно.

Залбирлаар эхлэх

- Хичээлээ эхлэхдээ нэг юм уу, хоёр дагалдагчаар залбируулах хэрэгтэй.

Оршил

Дагуулах дасгал ажил

- Дуугүй жүжиг: “Түүний дүр төрхийн дагуу бүтээгдсэн”

Оролцогчид (6 жүжигчин): “Бурхан,” Адам, Ева, Мод, Шувуу, Амьтан. (Захиас: Гуравхан хүн л жүжигчин болохоор байгаа бол тэднийг “Бурхан”, Адам, Ева гурвын дүрд тоглуулаарай. “Жүжиг – 3 Жүжигчин-г хар.”)

Хөгжим (байх албагүй): Зүгээр ая юм уу, эсвэл бүтээлийн тухай дуу. Байрлал: “Бурхан” үзэгчид уруу харж зогсоно. Бусад жүжигчид үзэгчид уруу нуруугаа харуулан, өвдөг сөгдөж “Бурхан” уруу харсан байрлалтай байна.

Жүжиг – 6 Жүжигчин

1. “Бурхан” ертөнцийг бүтээж буйгаа гараараа дүрслэн харуулна. Тэр огторгуйд оддыг бүтээнэ. Үйлдэл бүрээ удаан, алгуур хийх ёстой. “Бурхан” ертөнцийг хараад инээмсэглэнэ.
2. “Бурхан” эхний жүжигчинд хүрнэ. Тэр хүн нь мод адил, хөдөлгөөнгүй зогсоно. “Бурхан” баярлаж байгаагаа харуулна.
3. “Бурхан” хоёр дахь жүжигчинд хүрмэгц тэрээр шувуу шиг нисэж буй дүр үзүүлж байгаад шувуу шиг, хөдөлгөөнгүй сууна. “Бурханд” энэ нь таалагдана.
4. “Бурхан” гурав дахь жүжигчинд хүрмэгц тэрээр ямар нэгэн амьтаны дүр үзүүлж байгаад амьтан шиг, хөдөлгөөнгүй зогсоно. “Бурханд” энэ

нь таалагдана.

5. “Бурхан” Адам Ева хоёрын дүрд тоглож буй сүүлийн хоёр жүжигчинд хүрмэгц тэд Түүнтэй нөхөрлөж буй дүрийг хэсэг харуулаад хөдөлгөөнгүй зогсоно. “Бурхан” тэднийг хараад Өөр уруугаа гараараа заан, дараа нь тэдэн уруу, эргээд Өөр уруугаа зааж тэднийг Өөртэй нь адил гэдгийг илтгэнэ. Адам Ева хоёр “Бурханд” үнэхээр их таалагдана.

6. “Бурхан” бүх бүтээлийнхээ ард нь зогсож, тэднийг хараад сэтгэл хангалиун байдалтай толгой дохино. Үүний дараа бүх жүжигчин ёслон, тайзнаас бууна.

Жүжиг – 3 Жүжигчин

“Бурхан” 2, 3, 4-р үзэгдлийг жүжигчидгүйгээр хийнэ. Оронд нь “Бурхан” мод, шувуу, амьтан бүтээж буй хэсийг харуулахдаа модны хэлбрийг гараараа илэрхийлж, шувуудыг “нисгэж” буй мэт харуулан, нохойтой харицаж буй мэт дүр үзүүлнэ.

Адам Ева хоёр 5 ба 6-р үзэгдлийн дагуу жүжиглэнэ.

Судлахад туслах асуултууд

- Дасгал ажлыг ойлгоход нь туслах асуултуудыг дагалдагчдад тавь.
 - ❑ Жүжигчилсэн тогтолтоос та нар юу харав?
 - ❑ Бурхан бүтээлээ хараад ямар байв?
 - ❑ Хүнийг бүтээхэд бусдаас өөр зүйл ажиглагдav уу?
 - ❑ Энэ бидэнд Бурханы талаар юуг хэлж байна вэ? Бидний талаар юу өгүүлж байна? Бусад бүтээлийн тухай юу хэлж байна?

Шилжилт

- Оршил хэсгээс хичээл уруугаа холбосон тодорхойлолт хэл.

СҮУРЬ ҮНДЭСийн эхний номон дээр бид олон сайхан зүйл олж мэдэж, хэрэгжүүлсэн. Есүс бидний Хаан ба бид Хаанчлалын иргэд гэдийг сурсан. Бурханыг, бусад дагалдагч нараа болон хөршөө хайлласнаар бид Хаандаа захирагдах юм. СҮУРЬ ҮНДЭСийн хоёрдугаар номон дээр бид Бурханы талаар сурал болно. Өдөр тутмын амьдрал, үйлчлэл дээрх хэрэгжүүлэлтүүдийг гаргах хэрээрээ бид Түүний дүр төрхийн дагуу бүтээгдэх гэдэг нь ямар утгатай болохыг ойлгоно. Одоо бид СҮУРЬ ҮНДЭС II номын ерөнхий сэдвийг авч үзэж байна: Бурханы дүр төрх.

Судлал

Түлхүүр ишлэл

Тэгээд Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж,
Бурханы дүр төрхөөр эрэгтэй эмэгтэй хүнийг бүтээв.

Эхлэл 1:27

Судлах асуултууд

- Асуултууд дээр товч хэлэлцүүлэг хөтөл.
 - Бурхан хүнийг бүтээхдээ хэнийг загвар болгож ашиглав?*
 - Энэ нь хүн төрөлхтөнг чухал болгох уу? Яагаад?
 - Эрэгтэй эмэгтэй хүн хоёул Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн үү?
 - Эрэгтэй эмэгтэй хүний аль нь илүү үнэ цэнтэй вэ?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

- Судалгааны асуултыг ашиглан Бичээсийг судлан үзэхийг дагалагч нарт уриална. Оролцоог нэмэгдүүлэх үүднээс гурав, дөрвөн хүнтэй бүлгүүдэд хуваах хэрэгтэй.

Бурханы дүр төрх болох Есүс

- Колоссай 1:15 • Еврей 1:3
 - Бурхан Эцэг хүн шиг үзэгдэх биетэй юу? Хүмүүс Бурханыг харах боломжтой юу, аль эсвэл Тэр сүнс үү?
 - Есүс Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн үү, эсвэл Тэр Өөрөө Бурханы дүр төрх үү? Энэ хоёр нь ямар ялгаатай вэ?
 - Еврей 1-р бүлгийн дагуу Есүс гэж хэн болох, Түүний юу хийдгийг тодорхойл.
 - Эдгээр ишлэлүүд нь Есүсийг Бурханы дүр төрх мөн гэдгийг хэрхэн илэрхийлж байна?

Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн хүн төрөлхтөн

- Эхлэл 5:1-2 • Эхлэл 9:6
 - Бурханы дүр төрхийн дагуу хэн бүтээгдсэн бэ?
 - Бурхантай адил бүтээгдэнэ гэдэг нь юу гэсэн үг вэ? Хүн Бурхантай юугаараа адил вэ? Бид Бурханаас юугаараа ялгаатай вэ?
 - Бидний амь амьдрал яагаад онцгой үнэ цэнтэй вэ? Бид бусад бүтээлээс юугаараа ялгаатай вэ? Хүн алсны хариуд яагаад хатуу шийтгэл оноодог вэ?

Хүн төрөлхтөн – Нүглээс болж гэмтсэн

- Эхлэл 3:1-6, 22-23 • Ром 1:28-31
 - Бурханы эсрэг хүн төрөлхтний тэрслэл нь Эхлэл 3-р бүлэгт гардаг.

Үүний дараа хүний доторх Бурханы дүр төрх яасан бэ?

- Бурханы дүр төрхийн талаар мэдэх зүйлээ Ром номноос уншсан хэсэгтэйгээ харьцуулж үзээрэй. Бидний доторх Бурханы дүр төрхийг гэм нүгэл яадаг вэ?
- Хүмүүсийг бие биенээс нь юу салгадаг вэ?
- Бүх л нийгэм хүний амийг ямар нэгэн замаар үнэ цэнгүй болгодог. Бидний амьдарч буй нийгэмд үүний ямар жишээ байна?
- Энэ нь чуулган дотор мөн болдог уу? Өөрийнхөө хариултыг тайлбарлаарай.

Хүн төрөлхтөн – Бурханы дүр төрхөөр сэргээгдсэн нь

- Ефес 1:22-21
- Колоссай 3:9-10
- 2 Коринт 3:18

- Бидний шинэ хүн нь Бурханы дүр төрхөөр хэрхэн бүтээгдсэн бэ?
- Үүнийг хийх ямар практик арга замууд байна?
- Бид хэрхэн өөрчлөгдсөн бэ? Бид хүний хичээл зүтгэлээр өөрсдийгөө Бурханы дүр төрхтэй нийцүүлэх боломжтой юу?

Хуурамч дүрсүүд*

- Ром 1:22-23
 - Дуулал 135:15-18
- Хүмүүс ямар нэгэн дүрсэд мөргөхдөө өөрсдийгөө ухаантай гэж бодож болох юм. Харин Бурхан тэднийг юу гэж боддог бол?
 - Дүрсэд мөргөх нь яагаад мунхаг явдал гэж?
 - Хэрэв бид хуурамч дүрсэд мөргөвөл бидэнд юу тохиолдох вэ?
- *Нэмэлт: Танай нийгэмд хуурамч шүтээн том байр суурь эзэлдэг бол энэ хэсгийг сайтар судал.

- Бид жинхэнэ Бурханд мөргөхөд юу болдог вэ? Энэ нь бидний нийгмийг хэрхэн өөрчлөх боломжтой вэ?
- Бурханы дүр нь хүний бүтээсээ дүрүүдээс юугаараа өөр вэ?

Бататгал

Дасгал ажил

- Сурах бичиг дэх Зураг 1.1-ийг гарга.
- Энэ зургаас та нар юу харж байна?
- Энэ хүн өөрөөсөө юу асуугаад байна?
- Асуултад нь ямар ямар хариулт өгч болохоор байна вэ?

Цээжлэх ажил

- Сурах бичиг дээрх ишлэл цээжлэх картны түлхүүр ишлэлийг бүлгээрээ цээжил.
- Эхлэл 1:27

Гол санаагаа давтах

- Хичээлийн гол санаа юу болохыг дагалдагчдаар өөрсдөөр нь хэлүүлнэ. Тэднийг зөв хариулсан эсэхийг нь харуулахын тулд дараах жагсаалттай товчхон тулгаарай.

Бурханы дүр болох Есүс

- Бурхан Эцэг хүн шиг харагдахуйц бие махбодгүй. Бурхан Эцэг бол сүнс. Бид Түүнийг харж чадахгүй.
- Есүс Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдээгүй. Тэр Өөрөө Бурханы дүр юм. Есүсийн үгс болон жишээнээс бид Бурхан гэж хэн болохыг мэдэж болно.
- Есүс бол Бурхан. Гэвч Эцэг болон Түүний үүрэг өөр.
- Есүс Өөрөө Бурхан учраас Тэр Түүний алдрын туяа бөгөөд Түүний оршихуйн төгс илэрхийлэл юм.

Хүн төрөлхтөн – Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн

- Есүс бол Бурханы дүр. Хүн төрөлхтөн Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн.
- Хүн төрөлхтөн Бурханы дүр төрхийг тусган харуулахын тулд бүтээгдсэн.
- Эрэгтэй эмэгтэй хүн хоёул Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн. Энэ нь эн тэнцүү үнэ цэнтэй гэсэн үг юм.
- Бидний үнэ цэн бидний хэн болох, эсвэл юу хийснээс хамаарахгүй – бидний эд хөрөнгө, оюун ухаан, гадаад төрх, үндэс угсаа, нийгмийн давхарга, ажил мэргэжил, албан тушаал, авьяас чадвар гэх мэт. Харин бид Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн гэдгээрээ онцгой үнэ цэнтэй юм.
- Бидний үнэ цэн Бурханы амьдралыг хэрхэн үнэлдэгээс харагддаг. Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн хүнийг ална гэдэг Бурханыг доромжилж буй хэрэг.

Хүн төрөлхтөн – Нүглээс болж гэмтсэн

- Адам Ева хоёр нүгэл үйлдсэн. Бидний нэрлэдгээр Уналт буюу тэдний нүгэл ба тэрслэл нь хүн төрөлхтний доторх Бурханы дүр төрхийг гэмтээсэн. Бидний доторх Бурханы дүр төрхийг гэх нүгэл улам эвдсээр байдаг. Бидэнд ч бас байх ёстой байсан Бурханы ариун, зөвт чанарын эсрэг бодол, хандлага ба үйлдлүүдийг гэм нүгэл үүсгэдэг.
- Бурханы дүр төрхийг нийгэм ойлгохоос нааш хүний амь зүй зохистойгоор үнэлэгдэхгүй. Нийгэмд үр хөндөлт, эмэгтэйчүүдийг хүчирхийлэх явдал, хүнийг амьтнаас өөрцгүй үзэх үзэл болон амьдралыг уртасгаж болдог мэт ойлголт байдаг нь үүний нэг жишээ юм.
- Хор хөнөөлтэй гэм нүгэл нь ертөнцөөс ч, сүм чуулганаас ч олдох боломжтой.

Хүн төрөлхтөн – Бурханы дүр төрх сэргээгдсэн

- Бурхан бидний анх байсан дүрийг сэргээх зорилготой. Бид хуучин хүнээ хойш тавьж, шинэ хүнээ өмсөх ёстой гэж Библи хэлдэг. Бид шинэчлэх үйл явцад бид Ариун Сүнстэй хамт идэвхтэй оролцох хэрэгтэй.

□ Үүнийг гүйцэтгэх гол түлхүүр нь бурханлаг мэдлэг, Бичээсийн хэрэгжүүлэлт ба Эзэний Сүнсний ажил билээ.

Хуурамч дүрүүд

—Бурхан Өөрийн дүр төрхөө ихэд эрхэмлэдэг бөгөөд, өөр ямар ч хуурамч шүтээнтэй Өөрийн алдраа хуваалцахгүй. Бурханы дүр төрхийг гажуудуулж, Бүтээгчийг нь бүтээл мэт дорд оруулдаг хуурамч шүтээнийг Бурхан жигшдэг.

—Бид шүтдэг зүйлтэйгээ адил болдог. Хэрэв бид Библи дээрх Бурханд мөргөвөл, бид Түүний дүр төрхтэй адил болон өөрчлөгдөнө. Хэрэв бид хүний бүтээсэн хуурамч шүтээнд мөргөвөл бид хуурамч дүрд орно. Хэрвээ бидний нийгэм, улс үндэстэн хиймэл шүтээн шүтдэг бол зарчим, үйл ажиллагаанууд нь худал хуурмагаас үндэслэх болно.

—Бурхан биднийг дүр төрхийнхөө дагуу бүтээсэн нь бид олон талаараа Түүнтэй адил байхын тулд байв. Хүний бүтээсэн дүрүүд нь өөр — тэд Бурханыг төлөөлдөггүй. Шүтээн шүтэх явдал нь зөвхөн мунхаглал бус, бузар муу юм. 11-р хичээлийг хар.

Дүгнэлт

- Дүгнэлт тодорхойлолтыг уншиж өг. Эсвэл хичээлийг өөрийнхөө үгээр дүгнэ.

Есүс Өөрөө Бурханы дүр учир Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдээгүй. Бурхан хүн төрөлхтнийг бүтээхдээ Өөрийн дүр төрхийн дагуу бүтээсэн. Бид Түүнтэй олон талаараа төстэй байхаар бүтээгдсэн.

Хэдийгээр бид Түүний дүр төрхийн дагуу бүтээгдсэн ч, Түүнийг өөрсөдтэйгөө адил болгон “бүтээх” гэж бид хэзээ ч оролдох ёсгүй. Бид Түүний хэмжээлшгүй эрх мэдэлт чанараас бусдаар байнга мөн чанартай нь адил болохоор өсөж байх ёстой.

Хүн төрөлхтөн Бурханы эсрэг тэrsэлснээр ертөнцөд нүгэл орж ирсэн тэр цагаас хүний доторх Бурханы дүр төрх гэмтсэн. Бид Бурхантай адил зөвт байхын оронд бузар муу байх хандлагатай байдаг. Бид Ариун Сүнсний хүчээр дамжуулан Бурханы дүр төрхтэй адил болохоор өөрчлөгдөж байна. Бид Библийг судлахдаа бид уншсан зүйлдээ итгэж, түүнийг дуулгавартай дагавал, хуучин нүгэлт хүнээ хойш тавьж, Бурханы дүр төрх болох шинэ хүнийг өмсөх болно.

Хэрэгжүүлэлт

Үлгэрлэх асуулт . . .

. . . ба байж болох хариултууд

- Дагалдагчдад хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг бодож олоход нь туслах хэрэгтэй.

- Дараагийн хичээлдээ орохын өмнө бид энэхүү сурсан хичээлээ хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ? Байж болох хариу:
 - Амьдралд тань нүгэл байгаа бол бие биентэйгээ хуваалцах.
 - Найз нөхрөө Бурханы дүр төрхийн дагуу өсөж, ойлгоход нь туслах тодорхой алхмыг бодож үзэх.
 - Сурах бичгийн арын хуудсанд буй нэмэлт ишлэлүүдийг унших, залбирах, Бичээсийг эргэцүүлэх, түүнийгээ хэрэгжүүлэх алхам хийх.

Хувийн харилт, шийдвэр

- Дагалдагчдад ойрын үед хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар бodoх цаг гарга.
- Дараагийн хичээлд орохынх нь өмнө хэрэгжүүлэх нэг аргыг сонгуулж, дараах зүйлийг хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөн дээр нь бичүүл. Үүнд:

Юу хийх, хэзээ хийх

- Хэнд хандсан байх (хөрш, найз, гэх мэт.)

Гүйлт хүсэлт

- Дагалдагчдыг хоёр гурваар нь жижиг бүлэгт хувааж нэг нэгнийхээ төлөө, ялангуяа хэрэгжүүлэх төлөвлөгөөнийхөө төлөө залбирахыг уриал.

Шилжих асуулт

- Шилжих асуултыг асуу. Гэхдээ хариулт өгөх, хэлэлцэх гэх мэт зүйлийг хийх хэрэггүй.

Бурхан биднийг дүр төрхийнхөө дагуу бүтээснийг, биднийг дүр төрхийнх нь дагуу өөрчлөгдөхийг хүсдэг гэдгийг бид сурлаа. Жишээн дээрх хүн шиг энэ нь ямар утгатай болохыг асууж болох юм! Дараа дараачийн хичээлээр Бурханы дүр төрхийг өөр өөр талаас нь ярих болно. Энэ хичээлүүдийн дараа бид өөрсдөөсөө: “Нэгэнт Түүний дүр төрхийн сайн таньж, мэдсэн тул одоо бид хэрхэн улам бүр Түүнтэй адил болох вэ?” гэдэг асуултыг асууна. Дараагийн хичээл дээр бид орчлон ертөнцийг Бүтээгч Бурханы талаар илүү ярих болно.

Төгсгөл

- Хичээлээ залбирлаар өндөрлөхийнхөө өмнө бүх зааврыг өгөх хэрэгтэй.

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ: Дараагийн хичээл эхлэхийн өмнө:

➢ Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж зөвлөгөө

➢ Хичээл бүрийн хооронд үзсэнээ хэрэгжүүлэх туршилага

(Дагалдагчид хэрэгжүүлэлтээ дараагийн хичээл дээр хуваалцахад бэлэн байх ёстой.)

Хэрэгжүүлэх Төлөвлөгөө

“Би юу? Бурханы дүр төрхийн дагуу гэж үү?”



Зураг 1.1

СҮҮРЬ ҮНДЭС Цогц бүрэн Дагалдагч бэлтгэл: Бүрханы дүр төрх

Эхэнд Бурхан

ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Өмнөх хичээл дээр сурсан, хэрэгжүүлсэн зүйлсээ давтана.
- Бурхан бол бүхнийг Бүтээгч ба Өөрөө бүтээгдээгүй, эхлэл ч үгүй гэдгийг олж мэднэ.
- Бурхан бүтээлүүдээрээ алдаршдагийг харна.
- Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэнхээ хувьд хүмүүс чухал гэдгийг дахин сануулах – ба энэ нь бидний харилцаа, амьдрал дахь бүхий л зүйлсэд маань нөлөөлиө гэдгийг ойлгоно.

Залбирлаар эхлэх

- Хичээлээ эхлэхдээ нэг юм уу, хоёр дагалдагчаар залбируулах хэрэгтэй.

Тойм

Хичээлийн тойм

- Өмнөх хичээлийн гол санааг давтана.

Хэрэгжүүлэлтээс олж авсан туршилага

- Нэг юм уу, хоёр дагалдагчаар туршилага солилцуулж, ижил төстэй талуудыг нь дүгнүүлэх хэрэгтэй.

Дагалдуулагчийн ажиглалт

- Хэрэгжүүлэлтийнх нь талаар ажигласан, бодсон зүйлээ хуваалц.

Оршил

Дагуулах дасгал ажил

- Бүлгийнхэнд сурах бичиг дээрх 2.1-ээс 2.4 хүртэлх зургийг харуулна.

Судлахад туслах асуултууд

- Дасгал ажлыг ойлгоход нь туслахын тулд дагалдагчдаас асуулт асуу.
 - ❑ Зураг бүрээс та нар юу харж байна вэ?
 - ❑ Харж буй бүхнээс чинь аль нь хамгийн чухал байна вэ?

Бурханы бүтээлийн оргил нь юу байв?

Шилжилт

- Оршлоос хичээл уруугаа хөтлөх тодорхойлолт хий.

Бурхан бүхнийг оргүй хоосноос бүтээсэн бөгөөд харин Өөрөө бүтээгдээгүй. Орчлон ертөнц Бурханы агуу хүчийг харуулж байгаа бол хүн төрөлхтөн Түүний тайхам их хайрын илрэл юм. Бүх ертөнцийг бүтээсэн Бурхан биднийг бодож сэтгэн, бүтээсэн!

Судлал

Түлхүүр ишилэл

Эхэнд Бурхан тэнзэр газрээг бүтээжээ.

Эхлэл 1:1

Судлах асуултууд

- Асуултуудаас ургуулан товч хэлцүүлэг хөтөл.
 - Эхэнд гэсэн нь хэзээ вэ? Эхэнд хэн байв?
 - Энэ цагаас өмнө өөр зүйл байсан уу? Юу бүтээгдсэн бэ?
 - Хязгааргүй уудам огторгуйг Бурхан бүтээсэн гэж бодохоор ямар санагдаж байна? Энэ нь чиний хувьд юу гэсэн үг вэ?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

- Дагалдагчдад судалгааны асуултыг ашиглан Библийг судлахыг зөвлө.

Бүтээгч

- Исааиа 37:16*
 - Бурхан хэр их юм бүтээсэн бэ?
 - Бүтээгч Бурхан хэд байдаг вэ?

Бурхан алдартай

- 1 Коринт 8:5-6*
- Дуулал 101:30*
 - 1 Коринт, Колоссай, Дуулал номуудад хэнийг Бүтээгч гэж хэлж байна вэ?
 - Бурхан Эцэг, Есүс Христ, Ариун Сүнс гурвуулаа бүтээлийн ажилд оролцсон уу?
- Колоссай 1:15-18*

Хүн төрөлхтний үнэ цэнэ ба Бурханы хайр

- Иеремиа 10:11-12*

- ❑ Бидний Бурхан бол жинхэнэ Бурхан гэдэгт бид хэрхэн бат итгэлтэй байх вэ?
- ❑ Бидний ахуй соёлд бүтээлийн талаарх өөр итгэл үнэмшил бий юу? Энэ бүхэн нь үнэн байж болох уу? Бусад “бурхад” тэгвэл яах болж байна вэ?
- *Илчилэлт 1:11*
 - ❑ Зөвхөн Бурханд л бүх зүйл нь байх учиртай. Юу? Яагаад?
- *Дуулал 139:13-18*
 - ❑ Энэ ишлэл нь бидэнд нэг амийн үнэ цэнгийн талаар юу хэлж байна вэ?
 - ❑ Бурхан биднийг яах гэж бүтээсэн бэ? Та бид хоёрын талаар Тэр хэр зэрэг хувьчлан боддог вэ? Бурхан бидэнтэй ойр дотны харилцаатай байхыг хүсэж байгаа болов уу?

Хүн төрөлхтөн бол бүтээлч

- *Египетээс гарсан нь 31:1-5* • *Египетээс гарсан нь 35:25-26*
 - ❑ Энэ хоёр хэсэгт гарж буй хүмүүсийн онцгой чанарууд нь юу вэ?
 - ❑ Бид бүтээлч сэтгэлгээ, ур чадвар ба авьяасыг хаанаас авдаг вэ?
 - ❑ Бид бүтээлч сэтгэлгээгээ хэрхэн ашиглах ёстой вэ?

Бататгал

Дасгал ажил

- **Бүтээгчийг хүндэтгэн дээдлэх:** Бүтээгчийг бүлгээрээ магтан дуулж, залбирч хүндэтгэн дээдлэх хэрэгтэй. Магтаал талархлаа аль болох сурсан зүйл дээрээсээ гаргах нь зүйтэй.

Цээжлэх ажил

- Хичээлийн хөтөлбөрт орсон цээжлэх ишлэлийн картуудыг ашиглан бүлгээрээ түлхүүр ишлэлтүүдийг цээжлээрэй.
Эхлэл 1:1

Гол санаагаа давтах

- Хичээлээс ойлгох гол зүйлийг дагалдагчдаас өөрсдөөс нь асуу. Тэднийг зөв хариулсан эсэхийг нь харуулахын тулд дараах жагсаалттай товчон тулгах хэрэгтэй.

Бүтээгч

- Бурхан бүхнийг оргүй хоосноос бүтээсэн. Бүтээлээс өмнө Бурханаас өөр юу ч оршин тогтноож байгаагүй.
- Тэр тэнгэр газар ба түүн дотор оршигч бүхнийг бүтээсэн.
- Бурхан анхнаасаа л байсан. Түүнд эхлэл гэж байхгүй.
- Бүхний Бүтээгч нь болохынхoo хувьд зөвхөн Тэр л ганц үнэн Бурхан мөн.

Бурхан алдартай

- Бурхантай адил агуу нэгэн гэж үгүй. Энэ нь бүтээлээс илэрхий харагдаж байна. Бурхан бүтээлээрээ алдаршдаг.
- Бид Бурханы бүтээлийг хараад гайхан биширдэг.

Хүн төрөлхтний үнэ цэн ба Бурханы хайр

- Хүн төрөлхтөн Бурханы дүр төрхийн дагуу, Түүгээр бүтээгдсэн. Энэ нь бидний үнэ цэнг тодорхойлно. Харин бидний ур чадвар, гадаад төрх, мэдлэг ухаан эсвэл эд хөрөнгө үүнийг тодорхойлохгүй.
- Бид Бүтээгчээрээ аймшигтай бөгөөд гайхамшигтай бүтээгдсэн. Тэр биднийг төрөхөөс маань өмнө мэдэж байсан.
- Бурхан биднийг бүрэн мэднэ. Тэр үргэлж биднийг бодож байдаг ба бидэнтэй дотны, хувийн харилцаатай байхыг хүсдэг.

Хүн төрөлхтөн бол бүтээлч

- Бүтээлч чанар бол Бурханы бидэнд өгсөн Өөрийнх нь мөн чанар.
- Бид Бурхантай адил оргүй хоосноос ямар нэгэн зүйл бүтээж чадахгүй ч, Түүний бүтээсэн зүйлүүдээр гоёмсог, хэрэгцээтэй зүйлс хийж чадна.
- Бидний оюун ухаан бол агуу нөөц бололцоо. Бүхний сайн сайхны төлөө Бурханаас бидэнд өгөгдсөн зүйлсийг бид бүтээлчээр ашиглах ёстой.

Дүгнэлт

- Дүгнэлт тодорхойлолтыг уншиж өгөх юмуу эсвэл хичээлийг өөрийнхөө үгээр дүгнэ.

Бурхан бүтээгдээгүй ба Өөрөө бүхнийг Бүтээгч. Тэр бол цорын ганц үнэн Бурхан ба бүтээлүүдээрээ алдаршдаг. Бурхан бүхнийг Бүтээгч учраас алдар магтаалыг авбал зохистой. Бид Түүний дүр төрхийн дагуу бүтээгдсэн. Бид аймшигтай бөгөөд гайхамшигтай бүтээгдсэн. Бурхан биднийг төгс мэддэг ба бидэнтэй дотно, хувийн харилцаатай байхыг хүсдэг. Бидний доторх Түүний дүр төрх нь биднийг бүтээлч болгодог.

Хэрэгжүүлэлт

Үлгэрлэх асуулт . . .

. . . ба байж болох хариултууд

- Дагалдагчдад хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг бодож олоход нь туслах хэрэгтэй.
- ❑ Дараагийн хичээлд орохын өмнө бид энэхүү сурсан хичээлээ хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ? Байж болох хариулт:
 - Ур хүүхдүүдээ Бурханы бүтээлийн гайхамшиг, сүр жавхланг ярьж өгөх.
 - Бурханы бүтээлийг арчлан хамгаалахын тулд нэг жижиг ажил хийх.

- Сурах бичгийн арын хуудсанд буй нэмэлт ишлэлүүдийг унших, залбирах, Библийн хэсгээс эргэцүүлэх, түүнийгээ хэрэгжүүлэх алхам хийгээрэй.
- Бусдад үйлчлэх тал дээрээ “бүтээлч” хандаж, өмнө нь хийж үзээгүй зүйлээ хийх хэрэгтэй.
- Бүтээлийг нь ажиглаж, бусдад заан, Түүнийг алдаршуулан магт.

Хувийн хариулт, шийдвэр

- Дагалдагчдад ойрын үед хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар бодох цаг гарга.
- Дараагийн хичээлд орохынх нь өмнө хэрэгжүүлэх нэг аргыг сонгуулж, дараах зүйлийг хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөн дээр нь бичүүлнэ. Үүнд:
 - Юу хийх, хэзээ хийх
 - Хэнд хандсан байх (хөрш, найз, гэх мэт.)

Гүйлт хүсэлт

- Дагалдагчдыг хоёр гурваар нь жижиглэн хувааж нэг нэгнийхээ төлөө, ялангуяа хэрэгжүүлэх төлөвлөгөөнийхөө төлөө залбирахыг уриал.

Шилжих асуулт

- Шилжих асуултыг асуу. Гэхдээ хариулах, хэлэлцэх гэсний хэрэггүй. Бурхан бол бүхнийг Бүтээгч гэдгийг бид харлаа. Тэр мөн бүх бүтээлийнхээ дээгүүр эрх мэдэлтэй. Энэ нь юу гэсэн үг вэ? Бурханы дээд эрх мэдэл гэдэг нь юу вэ?

Төгсгөл

- Хичээлийг залбирлаар өндөрлөнө. Гэхдээ үүнээс өмнө бүх зааврыг өгсөн байх хэрэгтэй.

Залбирал

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ: Дараагийн хичээл өхлэхийн өмнө:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж зөвлөгөө
- Хичээл бүрийн хооронд үзсэнээ хэрэгжүүлэх туршлага


(Дагалдагчид хэрэгжүүлэлтээ дараагийн хичээл дээр хуваалцахад бэлэн байх ёстой.)

Хэрэгжүүлэх төлөвлөгөө

Бүтээл




Зураг 2.1



Зураг 2.2



Зураг 2.3



Зураг 2.1

СҮҮРЬ ҮНДЭС Үзүүл бүрэн Дагалдагч бэлтгэл: Бүрханы дүр төрх

Бурхан бүхнийг захирдаг

ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Өмнөх хичээл дээр сурсан, хэрэгжүүлсэн зүйлсээ давтана.
- Бурхан “дээд эрх мэдэлтэй” гэдгийг ойлгоно.
- Орчлон өртөнцийг болон хамгийн гол өөрсдийнх нь амьдралыг захирах бүрэн эрх мэдэлтэйг мэдэж авна.
- Бурхан бүх цагт бүх газар байж, бүхнийг мэддэг бөгөөд бүх хүч чадал Түүнийх гэдгийг сурна.
- Амьдралынхаа үнэ цэнийг ойлгож, Бурханд илүү захирагдахын тулд бодит алхам хийнэ.

Залбирлаар эхлэх

- Хичээлээ эхлэхдээ нэг юм уу, хоёр дагалдагчаар залбируулах хэрэгтэй.

Тойм

Хичээлийн тойм

- Өмнөх хичээлийн гол санааг давтана.

Хэрэгжүүлэлтээс олж авсан туршлага

- Нэг юм уу, хоёр дагалдагчаар туршлага солилцуулж, ижил төстэй талуудыг нь дүгнүүлэх хэрэгтэй.

Дагалдуулагчийн ажиглалт

- Хэрэгжүүлэлтийнх нь талаар ажигласан, бодсон зүйлээ хуваалц.

Оршил

Дагуулах дасгал ажил

- Жүжиг: “Ул үзэгдэгч Хаан!”

Бэлтгэл: Энэ хичээлийн төгсгөлд буй жүжгийн зохиолыг гурван хувь хувилсан байх хэрэгтэй. Гурван жүжигчин сонгож аваад хичээлийн

өмнө бэлдэнэ.

Үйл явц: Хичээлийн энэ цагт жүжигчид жүжгээ тоглоно.

Судлахад туслах асуултууд

- Дасгал ажлыг ойлгоход нь туслахын тулд дагалдагчдаас асуулт асуу.
 - ❑ Одоо ч гэсэн дэлхийг хавтгай гэж итгэдэг хүнийг та мэдэх үү? Та яг өөрөө дэлхийг бөөрөнхий гэдгийг нь харсан уу? Дэлхий бөөрөнхий гэдэгт итгэхэд тань юу нөлөөлсөн бэ?
 - ❑ Та өмнө нь Бурханыг харж байсан уу? Та Түүнд итгэдэг үү? Хэрэв итгэдэг бол Бурхан байдаг гэж итгэхэд тань юу нөлөөлсөн бэ?
 - ❑ Та монгол улсын ерөнхийлөгчийг яг бодитоор нь харж байсан уу? Хараагүй бол та түүнийг оршин тогтнодог гэдэгт итгэдэг үү? Тэр таны нутагт хамгийн дээд эрх мэдэлтэй нэгэн гэдэгт мөн итгэдэг үү? Танд юу нөлөөлсөн бэ? (Тайлбар: Үүнээс болж улс төрийн хэлэлцүүлэг уруу хазайж орж болохгүй шүү.)

Шилжилт

- Оршлоос хичээл уруугаа хөтлөх тодорхойлолт хий.

Бид өмнөх хичээлээрээ Бурхан бол бүхнийг Бүтээгч гэдгийг харсан. Энэ хичээлээр бид Бурхан дээд эрх мэдэлтэйг харах болно. Бид хэн нэгнийг “дээд эрх мэдэлтэй” гэж байгаа бол тэр нь хамгийн дээд байр суурь, эрх мэдэл ба хүч чадалтай гэж хэлж буй хэрэг юм. Бурхан оршин тогтнож буй бүхнийг захирдаг ба Тэр бол хэмжээлшгүй эрхт, хаадын Хаан гэдэг нь ямар утгатай болохыг бид ойлгоно.

Судлал

Түлхүүр ишилэл

Есүс ойртон ирээд, тэдэнд “Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг тагад өгсөн” зэж айлдав.

Матай 28:18

Судлах асуултууд

- Асуултуудаас ургуулан товч хэлцүүлэг хөтөл.
 - ❑ Есүсийн эрх мэдлийн хэмжээ нь хэр юм бэ?
 - ❑ Хэн Есүст “тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг” өгсөн юм бэ?
 - ❑ Есүс тэнгэрт хэний дээгүүр эрх мэдэлтэй вэ?

- Есүс газарт хэний дээгүүр эрх мэдэлтэй вэ?
- Иймэрхүү эрх мэдэлтэй хүнийг бид ямар хүн гэдэг вэ?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

- Дагалдагчдад судалгааны асуултыг ашиглан Библийг судлахыг зөвлө. Оролцоог нэмэгдүүлэх үүднээс гурав, дөрвөн хүнтэй бүлгүүдэд хуваах хэрэгтэй.

Бурхан бол Хаан

- *Самуел 8:6-7*
 - Хүмүүс Самуелаас хаан шаардахаар очихдоо үнэндээ хэнийг эсэргүүцэж байсан бэ?
 - Бурхан израильчуутай ямар харилцаатай байхыг хүсэж байсан бэ?
 - Бурхан Өөрийнхөө хүмүүсийг хүчээр захирдаг уу?

Есүс бол Хаан

- *Даниел 7:13-14*
 - Даниелын үзэгдэлд дурдагдсан “Эртний Нэгэн” нь хэн бэ?
 - “Хүний Хүү шиг Нэгэн” гэсэн нь Есүс. Түүнд юу өгөгдсөн бэ? Хэн Түүнд мөргөв? Харж буй зүйлээ дүрсэл.
- *Матай 19:28*
 - Есүс энд юуг дүрсэлсэн бэ? Сэнтий юуг төлөөлж байна вэ?
- *Еврей 1:3,8*
 - 1 Самеулд бид Бурхан бол Хаан гэдгийг харсан. Даниел болон Матай номон дээр Есүс бол Хаан гэсэн. Энэ бүхнийг ойлгоход бидэнд Еврей ном хэрхэн тусалж байна?
 - Еврей номын дагуу Есүс хэнтэй адил вэ? Тэр хаана сууж байна вэ? Бурхан Эцэг Есүсийг ямар нэрээр дуудаж байна вэ?

Бурханы мөн чанар

- *Иеремиа 23:21*
 - Энэ хэсгээс та нар юу харж байна? Бурханы мэдэхгүй нууц газар гэж бий юу? Яагаад үгүй гэж?
 - Бурхан тэнгэр газрыг хэрхэн “дүүргэн” оршдог вэ? Тэр нэг том хөлөө газарт, нөгөө том хөлөө тэнгэрт тавьдаг уу? Бид өөр гариг дээр очлоо гэхэд Бурхан тэнд ч бас байгаа юу?
 - Дэлхийн нөгөө талд залбирч буй хүний залбирлыг болон миний залбирлыг Бурхан зэрэг сонсож чадах уу?
- *Ром 1:20*
 - Бүтээлээс бид юуг харж чадах вэ? Хэн бүхнийг бүтээсэн бэ?
 - Дийлэнх нь манай нарнаас ч том, тэр буман оддыг байршуулна гэдэг хэр зэрэг хүч шаардсан ажил бол?
 - Иймэрхүү хүч чадалтай нэгэнтэй та хэрхэн харилцах вэ?

• Еврей 1:13

- Бурханы мэдлэгийн цар хүрээ ямар вэ? Тэр таны талаарх бүхнийг мэддэг үү? Бүх хүний талаар мэдэх үү?
- Бурхан энэ бүхнийг яаж мэдээд байна вэ?

Энэ хэсгээс бид Бурханы мөн чанарын талаар гурван зүйлийг олж мэднэ:

- Бурхан бүх газарт оршдог.
- Бурхан хэмжээлшгүй хүчтэй.
- Бурхан бүхнийг мэддэг.

- Бурхан бүхнийг захирах чадалтай гэж та бодож байна уу?
- Бүх газарт нэгэн зэрэг оршдог, хэмжээлшгүй хүч чадалтай, бүхнийг мэддэг Бурханд тайлагнана гэхээр танд ямар мэдрэмж төрж байна?

Дээд эрх мэдэлт Бурханд хандах бидний хандлага

• Дуулал 139:1-10

- Бурханы талаарх энэ тодорхойлолтыг уншихад танд ямар сэтгэгдэл төрж байна? Бурханы талаарх таны бодолтой 6-р ишлэл хэр зэрэг тохирч байна?
- Хэрэв та Бурхантай сэргөөцөлдсөн байгаад 7-р ишлэлийг уншвал ямар сэтгэгдэл төрөх байсан вэ? 10-р ишлэл бусад ишлэлүүдээ хэрхэн тэнцвэржүүлж байна вэ?

• Даниел 2:20-23

- Бурхан биднийг бүтээхдээ бүхнийг мэддэг, хэмжээлшгүй хүчтэй, хaa сайгүй оршигч болгон бүтээгээгүй. Гэхдээ Бурхан үнэхээр их хэрэгцээтэй үед нь Даниелд мэргэн ухаан, хүч чадлыг өгсөн. Даниельны хариу үйлдлээс бид юу сурч болох вэ?

• Иаков 1:12

- Түүний дүр төрхийн дагуу бүтээгдсэн ч бидэнд дээд эрх мэдэл бий юу? Бид алдар магтаалыг авах зохистой юу? Бидэнд хэр хэмжээний эрх мэдэл байгаа вэ?

Бататгал

Дасгал ажил

- Сураг Бичиг дээрх Зураг 3.1-ийг гаргуулаарай. Бүлгийн гишүүдээр Матай 19:28 болон Даниел 7:13-14 дээр үндэслэн зураг зуруулаарай. (Нехцөл: Энэ дасгалыг мөн жижиг бүлгүүдээр хийлгүүл. Том цаасан дээр, томхон зуруулаарай.)

Зурахдаа: Зургийн чадварын тал дээр санаа зовох хэрэггүй. Харин чухал санаануудыг дүрслэн харуулах дээр илүү төвлөр. Цаг гарвал зургаа бүгдэд харуулна. Амжихгүй бол дараагийн хичээл дээр авч ирэх.

Цээжлэх ажил

- Хичээлийн хөтөлбөрт орсон цээжлэх ишлэлийн картуудыг ашиглан бүлгээрээ түлхүүр ишлэлүүдийг цээжлээрэй.

Матай 28:18

Гол санаагаа давтах

- Хичээлээс ойлгох гол зүйлийг дагалдагчдаас өөрсдөөс нь асуу. Тэднийг зөв хариулсан эсэхийг нь харуулахын тулд дараах жагсаалттай товчхон тулгах хэрэгтэй.

Бурхан бол Хаан

- Бурхан Өөрийнхөө Хаанчлалд анхнаасаа л Хаан нь байсан. Библид үүнийг Бурханы Хаанчлал, эсвэл Тэнгэрийн Хаанчлал гэж нэрлэж байгаа.
- Бурхан Израилийн Хаан байхыг хүссэн. Самуелаас хаан шаардсанаараа Израиль Бурханыг Хаан байлгахаас татгалзсан.
- Бурхан Өөрийнхөө дээд эрх мэдлээр биднийг хүчилдэггүй. Түүнд захирагдах үгүйг бид сонгодог. Тэр биднийг “чөлөөт сонголт”-тойгоор бүтээсэн.

Есүс бол Хаан

- Есүс Бурхан Эцэгээс хааны эрх мэдлийг хүлээн авч буй үзэгдлийг Даниел зөгнөн харсан. Есүсийн дээд эрх мэдэл нь мөнхийх бөгөөд бүх үндэстнийг захирах юм.
- Есүс дэлхий дээр энгийн амьдралаар амьдарсан. Дахин амилсныхаа дараа Тэр тэнгэрт одон, Бурхан Эцэгийнхээ сэнтийн баруун гарч заларсан. Түүнд бүх эрх мэдэл өгөгдсөн бөгөөд Эцэгтэйгээ хамт мөнхөд хаанчилна.

Бурханы мөн чанар

- Иеремиа Бурханы хэмжээлшгүй эрхт чанарыг биширдэг байсан. Бурхан үргэлж оршиж байдаг ба өөрийг нь хэзээ ч орхихгүй, хэлсэн зүйлээ гүйцэтгэх бүрэн хүч чадалтай гэдгийг ойлгосон нь түүнийг тайвшруулж байв.
- Энэ хичээл нь Бурханы гурван мөн чанарыг харуулж байна. Тэр бол теологийн талаасаа бүх газарт нэгэн зэрэг оршдог, хэмжээлшгүй чадалт, бүхнийг мэдэгч билээ.
- Бүх газарт нэгэн зэрэг оршин байгаа гэдэг талаасаа Бурхан бүх цагт, бүх газар болж буй бүхнийг мэдэж байгаа гэсэн үг. Тэр сүнс учраас хaa сайгүй орших боломжтой.
- Хэмжээлшгүй чадалт гэдэг нь Бурханд бүх хүч чадал бий гэсэн үг юм.
- Бүхнийг мэдэгч гэдэг нь Бурхан бүх зүйлийг мэддэг гэсэн үг.
- Энэ бол Бурханы мөн чанарыг тодотгох гурван хүчин зүйл юм. Энэхүү чанарууд дээр Түүний эрх мэдлийг нь тооцож үзвэл Тэр бол хаадын Хаан бөгөөд бүхний Захирагч юм.

Дээд эрх мэдэлт Бурханд хандах бидний хариу

- Бурханы хэмжээлшгүй эрхт захиргааг мэдсэнээр бид Түүнээс эмээхүй дотор Түүнийг бишрэн хүндэтгэх учиртай.
- Бидний хувьд хамгийн чухал хариу нь Түүнийг хувьдаа Хаан хэмээн хүлээн зөвшөөрч амьдралаа удирдуулах явдал мөн.
- Хэдийгээр бид Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн ч бүрэн эрх мэдэлтэй биш. Ганцхан Түүнд л тэнгэр газар дээрх бүх эрх мэдэл бий бөгөөд зөвхөн Бурхан л алдар магтаалыг авах зохистой.
- Мэдлэг ухаан, хүч чадлын эх сурвалж болохынх нь хувьд бид Бурханыг магтаж, бидэнд мэдлэг, ойлголтыг өгсөнд Түүнд даруухнаар талархах учиртай.
- Тэр бол Хаан бөгөөд бид Түүний Хаанчлалын иргэд болсон тул хувь завшаантай.

Дүгнэлт

- Дүгнэлт тодорхойлолтыг уншиж өгөх юмуу эсвэл хичээлийг өөрийнхөө үзээр дүгнэ.

Бурхан бол орчлон ертөнцийн Хаан. Хэдий Тэр Хаан боловч Өөрт нь захирагдахыг хүсэхгүй байгаа хүмүүсийг хэмжээлшгүй хүчээрээ албадан захирдаггүй. Тэр бидэнд чөлөөт сонголтыг өгсөн. Түүний захиргаан дор хүслээрээ орох нь бидний сонголт. Бурхан бүх ертөнцийг дүүргэн оршдог ба бүх мэдлэг, хүч чадал Түүнийх. Энэ бол Бурханы мөн чанар. Иймээс Тэр захирах учиртай. Есүс Эцэгтэйгээ хамт захирдаг ба Түүний баруун гаргат залран байгаа. Тэнгэр газар дээрх бүх эрх мэдэл Түүнд өгөгдсөн бөгөөд Тэр мөнхөд захирна.

Бурхан үргэлж бидэнтэй хамт бөгөөд үргэлж бидний сайны төлөө бүх хүч чадал, мэргэн ухаанаа ашиглах учраас Бурханы мөн чанар нь бидэнд агуу тайвшралыг өгөх болно. Тэр бүх бүтээлийн, бүх үндэстний болон миний амьдралын Хаан. Бид олон талаараа Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн. Гэвч Тэр бидэнтэй дээд эрх мэдлээ хуваалцдаггүй. Ганцхан Бурхан л Хаан.

Хэрэгжүүлэлт

Үлгэрлэх асуулт . . .

. . . ба байж болох хариултууд

- Дагалдагчдад хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг бодож олоход нь туслах хэрэгтэй.
- ❑ Дараагийн хичээлд орохын өмнө бид энэхүү сурсан хичээлээ хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ? Байж болох хариулт буюу хийх ажил:

- Хүслээрээ Түүнд захирагдаж, Түүний тушаалыг дуулгавартайгаар биелүүлэх.
- Сурах бичгийн арын хуудсанд буй нэмэлт ишлэлүүдийг унших, залбирах, Библийн хэсгээс эргэцүүлэх, түүнийгээ хэрэгжүүлэх алхам хийгээрэй.
- Бурхан бидэнд хүчийг өгөхөөр бидэнтэй хамт байдгийг санан таньдаг хүндээ сайн дураараа сайн үйлс хийгээрэй.

Хувийн хариулт, шийдвэр

- Дагалдагчдад ойрын үед хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар бодох цаг гарга.
- Дараагийн хичээлд орохынх нь өмнө хэрэгжүүлэх нэг аргыг сонгуулж, дараах зүйлийг хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөн дээр нь бичүүл. Үүнд:
 - Юу хийх, хэзээ хийх
 - Хэнд хандсан байх (хөрш, найз, гэх мэт.)

Гүйлт хүсэлт

- Дагалдагчдыг хоёр гурваар нь жижиглэн хувааж нэг нэгнийхээ төлөө, ялангуяа хэрэгжүүлэх төлөвлөгөөнийхөө төлөө залбирахыг уриал.

Шилжих асуулт

- Шилжих асуултыг асуу. Гэхдээ хариулах, хэлэлцэх гэсний хэрэггүй. Бурхан бол хэмжээлшгүй эрхт Хаан гэдгийг бид харлаа. Тэр бидний Эцэг гэдэг нь ямар утгатай вэ?

Төгсгөл

- Хичээлийг залбирлаар өндөрлөнө. Гэхдээ үүнээс өмнө бүх зааврыг өгсөн байх хэрэгтэй.

Залбираал

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ: Дараагийн хичээл өхлэхийн өмнө:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж зөвлөгөө
- Хичээл бүрийн хооронд үзсэнээ хэрэгжүүлэх туршилага

(Дагалдагчид хэрэгжүүлэлтээ дараагийн хичээл дээр хуваалцахад бэлэн байх ёстой.)

Хэрэгжүүлэх Төлөвлөгөө

Үл үзэгдэгч Хаан!

Дүрүүд

- Зөрүүд Заяа
- Шинжлэх ухаанч Шинээ
- Гүн ухаантан Ганаа

(Тайлбар: Зөрүүд, Шинжлэх ухаанч, Гүн ухаантан гэдэгтэй толгой холбогдох нэрнүүдийг сонгоорой.)

Заяа: Сайн уу! Би зөрүүд Заяа байна! Намайг яагаад ингэж дууддаг юм бүү мэд! (Бүлэгт хандаж хэлнэ.) Бодвол миний харж байж итгэдэг зангаас минь болдог юм байлгүй. Би дандаа ингэж хэлдэг юм: “Би харж байж л итгэнэ дээ!”

Шинээ: Юу болсон бэ зөрүүд Заяа?

Заяа: Юу ч болоогүй ээ, шинжлэх ухаанч Шинээ. Би зүгээр л юмыг харж байж л итгэдэг гэдгээ энэ хүмүүст хэлсэн юм.

Шинээ: Бүх юмыг уу?

Заяа: Тийм ээ! Бүх юмыг!

Шинээ: Өө тийм үү! Би саяхан нэг сэтгүүл дээрээс дэлхийг тойрч буй хиймэл дагуулуудын хийсэн нээлтийн талаар уншиж байсан юм...

Заяа: Байз даа! Зогс! Чи арай надад дэлхийг бөөрөнхий гэж хэлэх гээд байгаа юм биш биз дээ?

Шинээ: Тийм ээ, дэлхийг бөөрөнхий гэдэг нь ойлгомжтой шүү дээ! Үүнийг бид аль эртнээс л мэдэж байсан!

Заяа: Ха! Гэхдээ чи өөрөө энэ бөөрөнхий гээд байгаа дэлхийгээ яг нүдээрээ харсан уу?

Шинээ: Би сансраас авсан зургийг нь харж байснаас гадна энэ тухай номноос уншиж байсан.

Заяа: (Зөрүүд царай гарган, гарсаа зөрүүлээд, цааш харна.) Наадах чинь л гол асуудал нь байгаа юм даа! Яг нүдээрээ хараагүй болохоор би лав итгэж чадахгүй! Би харж байж л итгэнэ!

Ганаа: (Орж ирнэ.) Сайн уу зөрүүд Заяа.

Заяа: Сайн сайн гүн ухаантан Ганаа.

Ганаа: Би сая нэг юм бодлоо ...

Заяа: Өө үгүй ээ, дахиад л биш шүү!

Ганаа: Тийм ээ, би сая хаадын Хаан Есүсийн талаар бодлоо ...

Заяа: Есүс хаадын Хаан гэж үү?

Ганаа: Тийм ээ. Тэр бол хаадын Хаан!


Заяа: Чи яг тэр Есүсээ хаан ширээнд сууж байхыг нь харсан юм уу?

Ганаа: Үгүй ээ, гэхдээ би Түүний тухай Библиэс уншсан ба өөрийнхөө амьдралаас Түүний эрх мэдлийг нь харж байна. Бурхан бүхнийг мэддэг, хэмжээлшгүй хүч чадалтай, нэгэн зэрэг хaa сайгүй оршигч Нэгэн гэж итгэдэг. Тэр бүхний дээр эрх мэдэлтэй ба дэлхий дээрх бүх үндэстнийг захирадаг.

Заяа: (Цааш харна.) Үгүй, үгүй, үгүй! Намайг лав биш! Бүхнийг чаддаг, хэмжээлшгүй хүч чадалтай, хaa сайгүй оршигч Бурхан гэнэ ээ? Хэзээ ч үгүй! Чиний энэ үл үзэгдэгч Хааныг чинь би хэзээ ч харж байгаагүй учраас итгэхгүй. Би лав Түүнийг өөрийнхөө Хаан болгохгүй! Би хэлдэг зүйлээ л хэлье даа: “Би харж байж л итгэнэ!”

СҮҮРЬ ҮНДЭС Цогц бүрэн Дагалдагч бэлтгэл: Бурханы дүр төрх

Тэнгэр газар дээрх бүх эрх мэдэл
Матай 19:28 эсвэл Даниел 7:13-14-г дүрслэн зур.



Зураг 3.1

Эцгийн зүрх сэтгэл

ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Өмнөх хичээл дээр сурсан, хэрэгжүүлсэн зүйлсээ давтана.
 - Эцэг хүн хүүхэдтэйгээ харилцаатай байхыг хүсдэгийн адил Бурхан бидэнтэй харилцах хүсэлтэй байдгийг олж мэднэ.
 - Эцэг нь бүх хүүхдийнхээ хэрэгцээнд санаа тавьдгийг харна.
 - Сайн эцгийн үлгэр дуурайл авна – Тэнгэрлэг Эцэгээсээ.
 - Бурханы хүүхдүүд болохынхoo хувьд эдлэх эрх, хувь завшаанаа таньж мэднэ.
 - Эцэгийн сахилгажуулах хайрыг хүлээн авч сурна.
 - Өнчин, бэлэвсэн болон бусад хүмүүст санаа тавьснаар Эцэгтэйгээ илүү адил болох зорилго тавина.

Залбирлаар эхлэх

- Хичээлээ эхлэхдээ нэг юм уу, хоёр дагалдагчаар залбируулах хэрэгтэй.

Тойм

Хичээлийн тойм

- Өмнөх хичээлийн гол санааг давтана.

Хэрэгжүүлэлтээс олж авсан туршлага

- Нэг юм уу, хоёр дагалдагчаар туршлага солилцуулж, ижил төстэй талуудыг нь дүргүүлэх хэрэгтэй.

Дагалдуулагчийн ажиглалт

- Хэрэгжүүлэлтийнх нь талаар ажигласан, бодсон зүйлээ хуваалц.

Оршил

Дагуулах дасгал ажил

- Жүжигчилсэн уншлага: “Гахай ба буурцаг” (Лук 15:11-32)
Энэ бол яриан жүжиг юм. Жүжигчид урд гарч сууж байгаад юм уу,

эсвэл босож зогсож байгаад уншина. Тэд түүхийг жүжиглэн харуулж болох ч зайлшгүй шаардлагагүй.

Бэлтгэл: Энэ хичээлийн төгсгөлд буй унших хэсгийг таван хувь хувилж бэлдсэн байна. Гайгүй сайн уншиж чадах таван хүнийг жүжигчин болго. Эхлээд түүхтэй нь сайн танилцуулж байгаад ихээхэн сэтгэл хөдлөлтэй уншуулаарай.

Тоглолт: Үзэгчдэд энэ түүхийг Лук номын 15-р бүлгээс авсан гэдгийг хэлээд жүжигчдээ танилцуулна. Тэднээр жүжгийг уншуулсны дараа судалгааны асуултуудыг тавиарай.

Судлахад туслах асуултууд

- Даасгал ажлыг ойлгоход нь туслахын тулд дагалдагчдаас асуулт асуу.
 - ❑ Есүс эцгийн хайрыг ойлгуулахын тулд энэ түүхийг ярьсан. Та нар энэ түүхээс эцгийн талаар юу олж мэдэв? Тэр эцэг юу хийсэн бэ? Эцэг юу ярив? Түүний хайрын юу нь таныг гайхахад хүргэв?
 - ❑ Та энд гарч буй хоёр хүүгийн аль нэгтэй нь адилхан байна уу? Аль нь илүү тантай адил байна? Яагаад?
 - ❑ Эцэг хүү хоёрын харилцаа яагаад чухал вэ?

Шилжилт

- Оршлоос хичээл уруугаа хөтлөх тодорхойлолт хий.

Бурхан бүхнийг захирдаг гэдгийг бид өмнөх хичээл дээр үзсэн. Тэр бол дээд эрх мэдэлтэй, хаадын Хаан. Энэ хичээлээр бид Бурхан Эцэгийн талаар сурал болно. Бурхан хэдийгээр төгс хүчит Хаан мөн ч, бидний амьдралд сонирхолгүй, санаа тавьдаггүй, хол, тусгаар байдаг гэсэн уг биш юм. Харин ч Тэр бидэнд санаа тавьж, ойр байдаг. Тэр бүр биднийг Өөрийнхөө хүүдхүүд болгон үрчлэн авсан!

Судлал

Түлхүүр ишилэл

Дахин айдаст хүргэх боолчлолын сүнсийг та нар хүлээн аваагүй, харин үрилэлийн Сүнсийг авсан билээ.

Түүзээр бид “Аав! Энэг минь!” зэж дуулдаг.

Биднийг Бурханы хүүхдүүд зэдгийг Сүнс Өөрөө бидний сүнсийн хамт зэршилдээз.

Ром 8:15,16

Судлах асуултууд

- Асуултуудаас ургуулан товч хэлцүүлэг хөтөл.
 - Есүс болон дагалдагч нарынх нь ярьдаг байсан хэл бол Арамей хэл юм. Арамей хэлэн дээр Абба гэдэг уг нь “Эцэг” гэдэг үгийн хамгийн дотно хэлбэр юм. Эцэг гэдэг үгийг бид өөр ямар үгээр илэрхийлдэг вэ?
 - Таны Эцэг бол Бурхан гээд төсөөл дөө. Энэ нь Түүнийг үзэх үзэлд тань хэрхэн нөлөөлж байна?
 - Энэ ишлэл дээр хэлж буйгаар Сүнс бидэнд Эцэг уруу хандсан хүслийг өгдөг ба бид Түүнийг сэтгэлийнхээ угаас дууддаг гэж хэлж байна. Та ялангуяа Эцэг гэдэг талаас нь Түүнд хандаж байсан удаатай юу?
 - Эцэг хүү хоёрын харилцаа дотно байхад юу юу шаардлагатай вэ? Хүүхдүүдээ Өөртэйгөө дотно харилцаатай байлгахын тулд Бурхан юу хийсэн бэ?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

- Дагалдагчдад судалгааны асуултыг ашиглан Библийг судлахыг зөвлө. Оролцоог нэмэгдүүлэх үүднээс гурав, дөрвөн хүнтэй бүлгүүдэд хуваах хэрэгтэй.

Аавын хүүхдүүд

- 1 Иохан 3:1 • Ефес 1:1-5
- Хүүхдүүд эцгээсээ ямар эрх, завшааныг хүртдэг вэ? Бурхан бидэнд хайраа харуулахын тулд хийж чадах хамгийн агуу зүйл юу вэ?
- Аавтайгаа явж буй хүүхдүүдийг хараад танд юу ажиглагддаг вэ? Аав хүү хоёр адилхан харагддаг уу? Итгэгч биш хүмүүс биднийг хараад Бурханы талаар юу сурч болох вэ?
- Бурхан биднийг үрчлэн авахыг хэзээнээс төлөвлөж эхэлсэн бэ? Энэ нь танд юуг илэрхийлж байна? Энэ тухай бодоход таны сэтгэлд ямар байдлаар хүрч байна вэ? Шалтгаан нь юу вэ?
- Бурхан биднийг бүтээж, бидэнтэй харилцахыг хүссэн нь ямар зорилготой юм бол? Бурхан биднийг хайрынхаа улмаас үрчилж авахаар сонгосон гэдэг нь ямар учиртай юм бол oo?

Эцэгийн халамж

- Дэд хууль 1:31 • Дуулал 68:5
- Израильчууд Мосегийн удирдлаган дор цөлд дөчин жилийг өнгрөөсөн. Дэд хууль номыг Мose бичсэн. Цөлд байхад нь Израильчуудыг халамжилж байсан Бурханы хайрыг Мose хэрхэн дүрсэлсэн бэ?
- Эцгээрээ халамжлуулж буй хүүхдийн сэтгэгдэлийг та яаж дүрслэх вэ? Бурхан биднийг хэрхэн “халамжилдаг” талаар таны бодол юу байна?
- Дэлхий дээрх хамгийн эмзэг хүмүүс бол бэлэвсэн, эцэггүй, өнчин хүмүүс гэдгийг Дуулал номын 68-р бүлэг бидэнд сануулдаг. Бурхан Эцэг тэдэнд хэрхэн санаа тавьдаг бол?
- Бид Бурханы өмнө чухалд тооцогдохын тулд алдартай, ухаантай эсвэл баян байх ёстой гэсэн санаа өмнөх ишлэлд харагдсан уу? Эндээс чи

хувьдаа юу гэж дүгнэж байна?

Эцэгийн зүрх сэтгэлийг суулгах нь

• Иаков 1:27

- Бурхан Эцэг маань бидэнд юу хий гэж хэлсэн бэ?
- Бэлэвсэн, ганц бие эцэг, эхчүүд болон салсан хүмүүст ямар ямар асуудал тулгардаг вэ?
- Итгэгч бид бүхэн бэлэвсэн эмэгтэйчүүд болон өнчин хүүхдүүдийг өмгөөлж, халамжилж, туслахын тулд хийж болох ямар ямар практик алхмууд байна?

• Еерей 12:7-8

- Энэ ишлэл дээр хэлж буйгаар Эзэний сахилгажуулалт бидэнд сайн уу?
- Бурхан яагаад биднийг сахилгажуулдаг юм бэ? Түүний зорилго нь юу вэ? Тэр яагаад зовлон зүдгүүрийг зөвшөөрнө вэ?
- Хүмүүс Бурханы сахилгажуулалтад хандаж болох хандлагуудыг жагсаа. Бурханы бидэнд чиглэсэн зорилгыг гүйцэтгэхэд ямархуу хандлага шаардлагатай байна вэ?
- Ихэнх хүүхэд аавыгаа хажуудаа байх үед давгүй сайн зантай байдаг уу? Бурхан үргэлж бидэнтэй хамт. Энэ нь бидний амьдралд ямар өөрчлөлтийг авчрах учиртай вэ?
- Эцэг эхчүүд хүүхдүүдээ сахилгажуулах нь таны бодлоор зөв үү? Зүй зохистой сахилгажуулалт гэж юу вэ? Үүнийг хийх зөв хандлага нь юу вэ?

Батжуулалт

Дасгал ажил

- Сураг бичиг дээрх Зураг 4.1-ийг бүлгийнхнээрээ гаргуул.
 - Энэ зурагнаас хараад Бурхан Эцэгийн зүрх сэтгэлийн талаар та юу хэлж болох вэ?
 - Хүүхдүүдийнх нь талаар юу хэлж болох вэ?
 - Аль хүүхэд нь тантай илүү адил байна вэ?

Цээжлэх ажил

- Хичээлийн хөтөлбөрт орсон цээжлэх ишлэлийн картуудыг ашиглан бүлгээрээ түлхүүр ишлэлүүдийг цээжил.

Ром 8:15,16

Гол санаагаа давтах

- Хичээлээс ойлгох гол зүйлийг дагалдагчдаас өөрсдөөс нь асуу. Тэднийг зөв хариулсан эсэхийг нь харуулахын тулд дараах жагсаалттай товчхон тулгах хэрэгтэй.

Аавын хүүхэд

- Бурхан биднийг Өөрийнхөө хүүхэд болгон гэр бүлдээ үрчлэн авсан ба бидэнд бүхий л эрх, хувь завшааныг олгосон.

- Бид дэлхий дээрх эцгүүдтэйгээ цаг өнгрүүлэхийн хэрээр тэдэнтэй илүү адил болж тэднийг дуурайдаг. Үүнтэй адил бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ хэдий чинээ их цаг өнгрөөнө, төдий чинээ Түүнтэй адил болно.
- Хүмүүс бидэнтэй танилцсанаар Бурхан Эцэгийг маань Хэн болохыг таньж мэдэх ёстой.
- Дэлхий ертөнцийг бүтээхээсээ ч өмнө Бурхан биднийг Өөрийнхөө хүүхдүүд болгон үрчлэн авахаар төлөвлөжээ.
- Бурхан бүх зүйлийг бүтээсний нэг үндсэн зорилго нь бидэнтэй хайрын, эвсэг гэр бүлийн харилцаатай байхын тулд юм.

Эцэгийн халамж

- Израильчуудыг цөлд дөчин жил хэсүүчлэхэд Бурхан тэднийг харж хамгаалж байсан. Бурхан тэднийг хоол унд, хувцас хунар, чиглүүлэлт, дайснуудаас нь хамгаалах хамгаалалт зэрэг хэрэгцээтэй бүхнээр нь хангаж байв. Үүний адил Бурхан биднийг бүх талаар нь анхаарч, халамжилдаг.
- Бурхан Эцэг санхүүгийн нөхцөл байдал, нийгмийн давхараагаас нь үл хамааран хүүхдүүдээ бүгдийг нь халамжилдаг.
- Бэлэвсэн, өнчин, хамгаалалтгүй хүмүүст Бурхан илүү ойр байдаг. Тэр тэдэнд санаа тавьдаг.

Эцэгийн зүрх сэтгэлийг суулгах нь

- Бид Эцэгийн зүрх сэтгэлийг харуулснаар Бурханы дүр төрхийн тусгал болдог.
- Бэлэвсэн, өнчин хүмүүсийг харж хандаж байхыг Бурхан чуулганд даалгасан.
- Ганц бие эцэг эхчүүд болон бэлэвсэн өмэгтэйчүүдэд хүүхдүүдээ өсгөх, санхүүгийн гачигдал, ганцаардал, аюултай нөхцөл байдал гэх мэт онцгой хэрэгцээтэй талбар ихтэй.
- Сайн эцэг хүүхдүүдээ заримдаа хатуу замаар сургадаг. Тийм эцэг хүүхдээ хүмүүжүүлэхийн тулд шинэ даалгаврыг өгдөг.
- Сайн эцэг эх шаардлагатай үед хүүхдүүдээ сахилгажуулдаг.
- Бурханлаг тэсвэр тэвчээр, зан төлөв дотор өсгөж, улам илүү Өөрийнхөө дүр төрхийн дагуу өөрчлөхийн тулд Бурхан ч бас биднийг сахилгажуулдаг. Түүнийг сахилгажуулах нь гэмшиж Түүнд дуулгавартай байх нь бидэнд сайн.
- Бурхан зөв зүйтэй сахилгажуулалтын төгс үлгэр жишээг үзүүлдэг юм. (Хүүхдийг тэнэг мангар, хэнд ч хэрэггүй гэх мэтээр загнан, гараараа юм уу, эсвэл хатуу зүйлээр чанга, шархалхаар цохих нь яав ч зөв байж чадахгүй.)
- Бид үргэлж Бурханы оршихуйд байдаг. Бид Бурхан Эцэгээсээ эмээж, Түүнийг хүндлэхийг хүсэж буй учраас Бурхан бидэнтэй үргэлж хамт байдаг гэдгийг ойлгох нь биднийг олон буруу зүйлийг үйлдэхээс хамгаална.

Дүгнэлт

- Дүгнэлт тодорхойлолтыг уншиж өгөх юмуу эсвэл хичээлийг өөрийнхөө үгээр дүтнэ.

Бидний Бурхан бол алс хол байдаг Бурхан биш. Харин ч биднийг хайрлаж, бидэнтэй харилцахын тулд ойр байдаг Эцэг маань билээ. Тэр биднийг Өөрийнхөө хүүхдүүд болгон үрчлэн авсан бөгөөд бүхий л эрх, хувь завшааныг дагалдуулж өгсөн. Эцэг маань болохынхоо хувьд биднийг хүмүүжүүлэхийн тулд халамжилж, мөн сахилгажуулдаг. Өөрийнх нь хайрын хариуд Тэр биднийг эмзэг бүлгийнхэнийг халамжилж байгаасай гэж хүсдэг. Тэр биднийг улам бүр Өөртэй нь адил болж, Түүний дүр төрхийн дагуу өөрчлөгдөөсэй гэж хүсдэг.

Хэрэгжүүлэлт

Үлгэрлэх асуулт . . .

. . . ба байж болох хариултууд

- Дагалдагчдад хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг бодож олоход нь туслах хэрэгтэй.
 - ❑ Дараагийн хичээлд орохын өмнө бид энэхүү сурсан хичээлээ хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ? Дараах хариултууд бол боломжит хариултууд юм:
 - Бурханыг сонсож, дуулгавартай дагахын тулд шийдвэртэй алхмууд хий. Ялангуяа амьдралд чинь буй Бурханы сахилгажуулалтыг эсэргүүцэж, Тэнгэрлэг, хайрладаг Эцэгт найдаж чадахгүй байгаа тохиолдолд.
 - Бусдад, ялангуяа хүүхдүүддээ хайр харуулах бодит замуудыг бодож ол.
 - Бэлэвсэн, өнчин, ганцаардсан хүмүүст Бурханы халамж, хайрыг дамжуул.
 - Сурах бичгийн арын хуудсанд буй нэмэлт ишлэлүүдийг унших, залбирах, Библийн хэсгээс эргэцүүлэх, түүнийгээ хэрэгжүүлэх алхам хийгээрэй.

Хувийн хариулт, шийдвэр

- Дагалдагчдад ойрын үед хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар бодож цаг гарга.
- Дараагийн хичээлд орохынх нь өмнө хэрэгжүүлэх нэг аргыг сонгуулж, дараах зүйлийг хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөн дээр нь бичүүл:
 - Юу хийх, хэзээ хийх
 - Хэнд хандсан байх (хөрш, найз, гэх мэт.)

Гүйлт хүсэлт

- Дагалдагчдыг хоёр гурваар нь жижиглэн хувааж нэг нэгнийхээ төлөө, ялангуяа хэрэгжүүлэх төлөвлөгөөнийхөө төлөө залбирахыг уриал.

Шилжих асуулт

- Шилжих асуултыг асуу. Гэхдээ хариулах, хэлэлцэх гэсний хэрэггүй.

Энэ хичээлээр бид Бурхан Эцэгийн талаар, биднийг Өөрийнхөө хүүхдүүд болгон үрчлэн авсан тухай болон биднийг бурханлаг зан төлөвтэй болгохын тулд сахилгажуулдаг гэдгийг олж мэдлээ. Бурхан биднийг улам Өөртэй нь адил болж, дүр төрхийнх нь дагуу өөрчлөгдөөсэй гэж хүсдэг. Дараагийн хичээлээрээ бид Бурханы мөн чанарыг үргэлжлүүлэн судална. Бурхан училдаг. Энэ нь бидний талаар юуг харуулж байна?

Төгсгөл

- Хичээлийг залбирлаар өндөрлөнө. Гэхдээ үүнээс өмнө бүх зааврыг өгсөн байх хэрэгтэй.

Залбирал

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ: Дараагийн хичээл

Эхлэхийн өмнө:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж зөвлөгөө
- Хичээл бүрийн хооронд үзсэнээ хэрэгжүүлэх туршлага

(Дагалдагчид хэрэгжүүлэлтээ дараагийн хичээл дээр хуваалцаад бэлэн байх ёстой.)

Хэрэгжүүлэх төлөвлөгөө

Гахай ба буурцаг

Лук 15:11-32-оос авсан жүжигчилсэн унилага.

Дүрүүд

- Есүс
- Бага хүү
- Эцэг
- Том хүү
- Зарц

Есүс: Хоёр хүүтэй нэг хүн байжээ. Бага хүү нь эцэгтээ ...

Бага хүү: Аав аа, эд хөрөнгөнөөсөө оногдох хувийг минь надад өгөөч.

Есүс: гэхэд эцэг нь хоёр хүүдээ хөрөнгөө хувааж өгөв. Хэдхэн өдрийн дараа бага хүү нь хамаг юмаа хамаад, алс холын оронг зорин оджээ. Тэнд тэр дур зоргоороо амьдарч, эд хөрөнгөө үрэн таран хийв. Түүнийг бүх юмаа барж дуусахад тэрхүү нутагт нь ч сүрхий өлслөлөн болж, тэр юм юмаар гачигдаж эхлэв. Тэгээд тэр явж, уг нутгийн нэгэн хүнийг бараадах болж гэнэ. Тэр хүн гахайгаа хариулулахаар түүнийг явуулдаг байлаа. Тэр гайхайны идэж байсан буурцгаар ходоодоо дүүргэхийг хүсэмжлэвч хэн ч түүнд юу ч өгсөнгүй. Тийнхүү тэр ухааран...

Бага хүү: Энгийн минь хөлсөлсөн хүмүүсийн хичнээн нь ч талхаар элбэг дэлбэг байдаг билээ дээ. Гэтэл би энд өлсөж үхэх нь. Би босood эцэг уруугаа очьё. Тэгээд түүнд “Аав аа, би тэнгэрийн эсрэг, таны өмнө нүгэл үйлджээ. Би цаашид таны хүү гэгдэх нь зохисгүй, харин намайг хөлснийхөө нэг хүн болгооч” гэж хэлье

Есүс: Тэгээд тэр босож, эцэг уруугаа явжээ. Харин эцэг нь түүнийг холоос хараад, ихэд өрөвдөн гүйн ирж, тэврээд үнсэв.

Бага хүү: Аав аа, би тэнгэрийн эсрэг, таны өмнө нүгэл үйлджээ. Би цаашид таны хүү гэгдэх нь зохисгүй.

Есүс: Харин эцэг нь боолууддаа ...

Эцэг: Хамгийн сайхан хувцас хурдан авчирж, түүнийгхувцасла. Гарт нь бөгж зүү, хөлд нь гутал өмсгө. Тарган тутал авчирж нядал. Бүгдээрээ найрлаж цэнгээ. Учир нь энэ хүү маань үхсэн байсан юм. Гэвч амилжээ. Тэр алдагдсан ч олдлоо.

Есүс: Ууган хүү нь талбай дээрээ байжээ. Тэр буцаж, гэртээ ойртон ирэхдээ дуу хуур, бүжиглэх чимээг сонсоод, зарц нарынхаа нэгийг дуудаж, юу болоод байгааг асууж шалгаав. Тэр түүнд...

Зарц: Дүү чинь ирсэн. Таны эцэг түүнийг эсэн мэнд эргэж ирсэнд тарган тутал нялдуулав.


Есүс: Харин ууган хүү нь уурлаж, дотогш орохыг хүссэнгүй. Тэгтэл эцэг нь гарч ирээд түүнийг аргадан гүйж эхлэв. Хүү нь түүнд...

Том хүү: Хар, олон жилийн турш би танд зарагдаж байна. Би хэзээ ч таны

тушаасныг зөрчиж байгаагүй. Гэвч анд нөхөдтэйгээ баярлах үед минь та ганц ишиг ч надад өгч байгаагүй. Харин хөрөнгийг чинь янхнуудтай нийлж цөлмөсөн энэ хүүгээ ирэхэд нь түүнд зориулж тарган тугал нядалж байдаг

Эцэг: Миний хүү, чи үргэлж надтай хамт байсан. Минийх гэсэн бүхэн чинийх шүү дээ. Харин чиний энэ дүү үхсэн байсан. Гэтэл амьдарчээ. Алдагдсан боловч олдлоо. Иймээс бид баярлан цэнгэх ёстай.

Бурханы хүүхдүүд



Зураг 4.1

Бурхан уучилдаг

ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Өмнөх хичээл дээр сурсан, хэрэгжүүлсэн зүйлсээ давтана.
- Уучлал бол Бурханы мөн чанарын тусгал гэдгийг ойлгоно.
- Бурхан биднийг эхэлж уучилсан ба бидэнд бусдыг уучлахыг тушаадаг гэдгийг сурна.
- Есүс уучлалыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлснийг харна.
- Есүстэй адил уучилдаг болоход суралцана.

Залбирлаар эхлэх

- Хичээлээ эхлэхдээ нэг юм уу, хоёр дагалдагчаар залбируулах хэрэгтэй.

Залбирал

Тойм

Хичээлийн тойм

- Өмнөх хичээлийн гол санааг давтана.

Хэрэгжүүлэлтээс олж авсан туршлага

- Нэг юм уу, хоёр дагалдагчаар туршлага солилцуулж, ижил төстэй талуудыг нь дүгнүүлэх хэрэгтэй.

Дагалдуулагчийн ажиглалт

- Хэрэгжүүлэлтийнх нь талаар ажигласан, бодсон зүйлээ хуваалц.

Оршил

Дагуулах дасгал ажил

- Нээлтийн дуу: “Эзэний заасан гуйлт” (Матай 6:9-13)
- “Эзэний заасан гуйлт” дууг хамтдаа дуулаарай. Хэрэв аяаг нь мэдэхгүй бол хамтдаа залбираарай.

Тэнгэрт байгаа бидний Эцэг минь,
Таны нэр ариунаар дуурсагдаг.
Таны хаанчлал ирэх болтугай.

Хүсэл тань тэнгэрт шигээ газар дээр биелэгдэх болтугай.
Өдөр тутмын минь талхыг энэ өдөр бидэнд өгөөч.
Бид өртөнгүүдээ уучилсны адил бидний өрийг мөн уучлаач.

Биднийг сорилтод бүц оруулаач;
Харин бузар муугаас гэтэлгээч.

Учир нь хаанчлал, хүч чадал, алдар сүр үүрд Таных. Амен.

Судлахад туслах асуултууд

- Дарагал ажлыг ойлгоход нь туслахын тулд дагалдагчдаас асуулт асуу.
- “Эзэний заасан гуйлт” сэдвээр бид өмнөх хичээлүүд дээрээ юу юу сурсан билээ?
- Уучлалын талаар юу гэж залбирахыг Есүс дагалдагчдадаа заасан бэ?
- Хэрэв зөвхөн Бурхан л нүглийг уучлах эрхтэй юм бол яагаад бидэнд бусдын нүглийг уучлах тушаал өгсөн юм бэ?
- Үгийг нь сайтар ажиглаарай: “Бид өртөнгүүдээ уучилсны адил бидний өрийг мөн уучлаач.” Бурхан биднийг уучлах болон бид бусдыг уучлах хоёр ямар холбоотой вэ? Энэ нь юу гэсэн үг юм бол?

Шилжилт

- Оршлоос хичээл уруугаа хөтлөх тодорхойлолт хий.

Өмнөх хичээл дээр Бурхан бол бидний Эцэг ба бид Түүний хүүхдүүд гэдгийг сурсан. Энэ хичээлээр бид Бурхан Эцэгийнхээ нэгэн чухал чанарыг судлах болно. Энэ бол Түүний Ууч чанар. Энэ чанар бидэнд ч мөн байх ёстой. Библи Христ биднийг уучилсан гэдгийг илтгэдэг бөгөөд энэ нь бидний бусдыг уучлах уучлалын загвар ба үндэс болдог.

Судлал

Түлхүүр ишилэл

Бурхан та нариаг Христ дотор уучилснаа
адил бие биенээ уучлан, нэг нэгнийгээ энэрэн
үян зөөлөн сэмзэлээр ханг.

Ефрес 4:32

Судлах асуултууд

- Асуултуудаас ургуулан товч хэлцүүлэг хөтөл.
 - Хэн эхэлж уучилсан бэ?
 - Хэн бидний уччалын загвар болсон бэ? Энэ нь бусдыг учлахад маань хэрхэн нөлөөлж байна?
 - Биднийг уучилсан Христийн уччалыг илэрхийлж болох ямар ямар үгнүүд байгаа вэ?

Зураглал

- Сурах бичиг дээрх Зураг 5.1-ийг тэдэнд үзүүл.

Судлах асуултууд

- Асуултуудаас ургуулан товч хэлцүүлэг хөтөл.
 - Зураг 5.1 түлхүүр ишлэлийг хэрхэн дүрсэлж байна?
 - Энэ зурагнаас бид юу сурч болох вэ?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

- Дагалдагчдад судалгааны асуултыг ашиглан Библийг судлахыг зөвлө.

Бурхан уучилдаг

- *Мика 7:18-19* • *1 Иохан 1:9*
 - Бурхан Эцэг юуг чөлөөтэйгөөр хийдэг вэ? Тэр юунд баярладаг вэ?
 - Дараахыг сонсоод чамд юу бодогдож байна: “бидний гэмийг хөл доор гишгэчнэ”, мөн “тэдний бүх нүглийг далайн гүн уруу хаяна”!
 - Бид нүглээ улайвал Бурхан уучилна гэдгийг хэрхэн баттай мэдэх вэ?

Есүс уучлалыг үзүүлсэн

- *Лук 5:17-25*
 - Энэ түүхэн дээр гарч буй эрчүүд Есүсээр найзыгаа эдгээлгэх ямар агуу зүйл хийсэн бэ?
 - Нөхдийнх нь итгэлийг хараад Есүс саа өвчтэй хүнд эхлээд юу гэж хэлсэн бэ? Тэр хүний найзууд юу гэж бодож байсан бол?
 - Есүс яагаад түүнийг эдгээхээсээ өмнө уучилсан бэ? Энэ нь хүмүүстӨөрийнх нь эрх мэдлийн талаар юут ойлгуулсан бэ?
- *Лук 23:34*
 - Өөрийг нь ташуурдаж, зодож, өргөст титэм зүүлгэж, доромжилж, загалмайг нь үүрүүлж, загалмайд цовдолсон Ромын цэргүүдийг Есүс загалмай дээрээс хараад ямар хариу үйлдэл үзүүлсэн бэ?
 - Ихэнх хүн яах байсан бол?
- *Үйлс 7:59-60*
 - Стефан ингэж хариулахыг хаанаас сурсан юм бол?
 - Стефан үүнийг өөрийнхөө хүчээр хийж чадах байсан гэж чи бодож байна уу? (Тайлбар: Үйлс 7:55-ыг үз.)
 - Энэ жишээнээс бид юу сурч болох вэ?

Есүстэй адил уучлах

- *Матай 18:21-22* • *Матай 6:11-15*
 - Бидний эсрэг нүгэл үйлдсэн хүнийг бид уучлахдаа хэр вэ? Тэдгээрийг бид тоолох ёстой юу?
 - Бидний хувьд гол төлөв ямар хамаа хүрээний хүмүүсийг уучлах шаардлага их гардаг вэ?
 - Уучлахгүй бол юу болдог вэ? Уучлах үгүй нь тухайн тохиолдлоос шалтгаалах уу?
- *Ефес 4:29-32*
 - 31-р ишлэл дээр дурдагдсан сөрөг чанаруудаас болж ямар ямар хамаа харилцаанд саад учирдаг вэ? Эдгээр нь ягаад Ариун Сүнсийг гомдоодог вэ?
 - Бидний түлхүүр ишлэл болох 32-р ишлэл дээр Паул үүнээс гарах замыг бичсэн. Бурхан бидний Христ дотор ямар замаар уучилсан бэ? Тэгвэл бид бие биенээ хэрхэн уучлах ёстой вэ?
 - Уучлалгүй харилцаа яадаг вэ? Уучилдаггүй хүмүүст юу тохиолддог вэ?

Бататгал

Дасгал ажил

- Жүжигчилсэн уншлага: “Үл уучлагч зарц”
 - Бэлтгэл:** Энэ хичээлийн төгсгөлд буй жүжгийн зохиолыг дөрвөн хувь хэвлээд дөрвөн уншигч сонгож авна. Тэдэнд зохиолыг эхэлж харуул. Тэднийг аль болох сэтгэл хөдлөлтэйгөөр уншихад уриал.
 - Тогтолт:** Эхлэхдээ Матай 18:21-22-ыг унишина. Дараа нь Есүс энэ түүхийг Петрийн асуултанд хариулж хэлсэн гэдгийг тайлбарла. Жүжигчилсэн уншлагын дараа судалгааны асуултуудыг тавь.
- Санаа авч болох судалгааны асуулт
 - Энэ сургаалт зүйрлэл дээрх аль дүр нь Бурханыг илэрхийлж байна вэ?
 - Аль нь бидний дүрсэлж байна? Аль нь бидний эргэн тойрон дахь хүмүүсийг илэрхийлж байна?
 - Энэ сургаалт зүйрлэлээр Есүс юуг заахыг хүссэн бэ?

Цээжлэх ажил

- Хичээлийн хөтөлбөрт орсон цээжлэх ишлэлийн картуудыг ашиглан бүлгээрээ түлхүүр ишлэлүүдийг цээжлээрэй.

Ефес 4:32

Гол санаагаа давтак

- Хичээлээс ойлгох гол зүйлийг дагалдагчдаас өөрсдөөс нь асуу. Тэднийг зөв хариулсан эсэхийг нь харуулахын тулд дараах жагсаалттай товчхон тулгах хэрэгтэй.

Бурхан уучилдаг

- Бурхан Эцэг үргэлж уучилдаг. Тэр Израилийн хөвгүүдийг олон удаа уучилсан. Есүсийн загалмай дээрх үхлээр дамжуулж Бурхан биднийг болзолгүйгээр уучлах боломжтой болсон.
- Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Бурхан итгэмжит. Тэр бол шударга. Тэр бидний нүглийг уучилж, бүхий л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ.
- Бурхан биднийг уучлахдаа бүрэн уучилдаг. Тэр бидний гэм нүгэл, алдаа зөрчлийг бүрэн гүйцэд цэвэрлэдэг. Бурхан бидний нүглийн шийтгэлийг загалмай дээрх Есүст тохсон.
- Учлагдсан хүмүүсийг харагдаа Бурхан Есүсийг хардаг – зөвт.

Есүс уучилдаг

- Саа өвчтэй хүний найзууд нь түүнийг Есүс дээр авч ирэхэд Тэр түүний нүглийг уучилсан. Нүглийг уучлах эрх мэдэлтэй гэдгээ харуулахын тулд Тэр эхлээд хамгийн агуу зүйлийг нь хийсэн.
- Есүс загалмай дээр амьсгал хураахаасаа өмнө зовж байхдаа Өөрийгөө өрөвдөх юм уу, эсвэл Өөрийг нь ад үзэж байсан цэргүүдэд муугаар хандаагүй.
- Цэргүүдийг Есүс уучилсан тухай Стефан сонссон байсан нь зайлшгүй. Тэр чулуудуулж үхэхдээ өөр уруу нь чулуу шидэж байсан хүмүүсийг

Есүсийн адил уучилсан.

- Есүсийн адил уучлах
- Бид Есүсийн адил уучилснаар Түүний дүр төрхийг тусган харуулдаг. Бурхан биднийг ямар байхад уучилсныг бодохоор бид бусдыг уучлахдаа илүү энэрэнгүй байхад хүрдэг.
- Есүс бидэнд уучлалын загвар, үндэс, хүч нь болсон. Тэр мөн биднийг оршихуйгаараа хүчирхэгжүүлдэг.
- Долоон удаа уучлах нь дэндүү хангалттай гэж Петр бодож байсан. Ямар нэгэн зааг байхгүй гэдгийг Есүс тодорхой хэлсэн. Бидэнтэй ойр буй хүмүүсийг бид дахин дахин уучлах шаардлага гардаг – хань ижил, эцэг эх, хамтран ажиллагч, цуглааны анд болон найз нөхөд гэх мэт.
- Гэм нүглийн мөнхийн үр дагаварыг зөвхөн Бурхан л уучлах эрхтэй ч бид хүнийхээ түвшинд бие биенийхээ нүглийг уучлах ёстой. Тэд Бурханаас уучлал гүйх ёстой хэвээрээ ч бид тэдний эсрэг гомдол хорсол тээх шаардлагагүй.
- Өрөвдөх сэтгэлгүй, үл хайрлан, уучлахгүй байгаад байвал бидний дотор бузар муу, хорон хандлагууд улам бүр нэмэгдэнэ. Эдгээр нь хорсол, уур хилэн, хэрүүл маргаан, хов жив болон хорон санаа юм. Эдгээр нь Бурханд таалагддагтгүйгээс гадна, бидний Бурхантай харилцах дотны харилцаанд маань саад учруулж, Ариун Сүнсийг гомдоодог.
- Учлах сэтгэл нь чуулган, гэр бүл, ажлын газар, хaa сайгүй хэрэгтэй чанар. Хорслоос болж харилцаагаа алдахгүйн тулд болзолгүйгээр уучил.

—Уучлал бол сонголт бус, тушаал. Бид ах дүүгийнхээ нүглийг уучлахгүй бол Эцэг маань биднийхийг уучлахгүй гэж Есүс хэлсэн учраас энэ нь маш чухал.

Дүгнэлт

- Дүгнэлт тодорхойлолтыг уншиж өгөх юмуу эсвэл хичээлийг өөрийнхөө угээр дүгнэ.

Бурхан уучилдаг. Тийм учраас биднийг ч мөн адил байлгахыг хүсдэг. Бүх харилцаанд, ялангуяа чуулганд уучлал шаардлагатай байдгийг Бурхан мэдэх учраас үүнийг тушаал болгон өгсөн. Өөрийг нь алж байсан хүмүүсийг уучилснаар Есүс хамгийн гайхамшигтай жишээг харуулсан. Тэр цагаас хойш итгэгчид Бурханы адилаар ертөнцийг болзолгүйгээр гайхалтай уучилсаар ирсэн. Бурханы биднийг уучилсан явдалд бид хэрхэн хариулах вэ? Бид Бурханд талархалтайгаар бусдыг уучлан, мөн тэднийг уучилж өгөөч гэж Бурханаас залбиран, даруухнаар өөрсдөө уучлал гүйж сурах хэрэгтэй!

Хэрэгжүүлэлт

Үлгэрлэх асуулт . . .

. . . ба байж болох хариулт

- Дагалдагчдад хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг бодож олоход нь туслах хэрэгтэй.
 - ❑ Дараагийн хичээлд орохын өмнө бид энэхүү сурсан хичээлээ хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ? Байж болох хариулт:
 - Харилцаан дээр ямар нэг эвдэрч сэвтсэн зүйл байгаа бол бодож үзээрэй. Бид уучлал гүйх шаардлагатай юу? Хэн нэгэн бидний эсрэг нүгэл үйлдсэн үү? Бид негөө хүнээ гэмшихийг хүлээх аястай байгаа юм биш биз?
 - Харилцаанд сэв сууж завсар орохос өөр хэцүү асуудал гэж байна уу. Гэмшиж, Бурханаас уучлал гүй.
 - Сурах бичгийн арын хуудсанд буй нэмэлт ишлэлүүдийг унших, залбирах, Библийн хэсгээс эргэцүүлэх, түүнийгээ хэрэгжүүлэх алхам хийгээрэй.

Хувийн хариулт, шийдвэр

- Дагалдагчдад хичээлээр сурсан зүйлээ шинэ дээр нь хувийнхаа амьдралд хэрхэн хэрэгжүүлж болох талаар бodoх цаг гарга.
- Дараагийн хичээлд орохынх нь өмнө хэрэгжүүлэх нэг аргыг сонгуулж, дараах зүйлийг хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөн дээр нь бичүүл:
 - Юу хийх, хэзээ хийх
 - Хэнд хандсан байх (хөрш, найз, гэх мэт.)

Гүйлт хүсэлт

- Дагалдагчдыг хоёр гурваар нь жижиглэн хувааж нэг нэгнийхээ төлөө, ялангуяа хэрэгжүүлэх төлөвлөгөөнийхөө төлөө залбирахыг уриал.

Шилжих асуулт

- Шилжих асуултыг асуу. Гэхдээ хариулах, хэлэлцэх гэсний хэрэггүй. Бурхан уучилдаг. Тэр мөн тэвчээртэй. Дараагийн хичээл дээр бид Бурханы тэвчээртэй чанарын талаар сурал болно. Та илүү тэвчээртэй байх юмсан гэж хааяа хүсдэг үү?

Төгсгөл

- Хичээлийг залбирлаар өндөрлөнө. Гэхдээ үүнээс өмнө бүх зааврыг өгсөн байх хэрэгтэй.

Залбирал

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ:

Дараагийн хичээл эхлэхийн өмнө:

- Хичээл бүрийн хооронд узүүлэх халамж зөвлөгөө
- Хичээл бүрийн хооронд үзсэнээ хэрэгжүүлэх туршлага

(Дагалдагчид хэрэгжүүлэлтээ дараагийн хичээл дээр хуваалцаад бэлэн байх ёстой.)

Үл уучлагч зарц


Матай 18:23-35-ын жуужигчилсэн унилага

Дүрүүд

- Есүс
- Эзэн
- Боол 1
- Боол 2

- Есүс: Иймээс тэнгэрийн хаанчлалыг боолуудтайгаа тооцоо хийхийг хүссэн нэгэн хаантай зүйрлэж болно. Тэр тооцоо хийж эхлэх үед арван мянган талантын өртэй нэгийг нь түүн уруу аваачив. Харин түүнд өрөө төлөх юм байхгүй тул эзэн нь түүнийг эхнэр, хүүхдүүдийнх нь хамт хамаг юмтай нь худалдаад өрийг нь барагдуулахыг тушаажээ. Боол нь сөхрөн унаж, сунан мөргөөд түүнээс...
- Боол 1: Намайг тэвчин хүлцэнэ үү. Би танд бүгдийг буцааж төлнө
- Есүс: гэж гуйхад тэрхүү боолын эзэн нь түүнийг ихэд өрөвдөөд суллаж, өрийг нь хэлтрүүлжээ. Харин өнөөх боол гадагш гараад өөрт нь зуун денарын өртэй байсан өөрийнхөө анд нөхөр болох нэгэн боолыг олж хараад, барин авч хоолойг нь шахаж
- Боол 1: Өрөө төл!
- Есүс: гэв. Харин анд нөхөр нь болох тэр боол сөхрөн унаж, түүнээс гуйн
- Боол 2: Намайг тэвчин хүлцээч. Чамд буцааж төлнэ.
- Есүс: гэж хэлжээ. Тэр үүнийг хүсээгүй учраас явж, түүнийг өр ширээ буцааж төлтөл нь шоронд хориулав. Түүний бусад найз боолууд нь болсон явдлыг хараад ихэд гуниж, эзэн дээрээ очиж болсон бүгдийг нь мэдэгджээ. Тэгтэл эзэн нь нөгөөх боолыг дуудаад, түүнд
- Эзэн: Бузар муу боол оо, чи надаас гуйсан тул би бүх өрийг чинь хэлтрүүлсэн. Би чамайг өршөөсний адил чи бас анд нөхөр чинь болох тэр боолыг өршөөх ёстой байсан бус уу?
- Есүс: гээд, ихэд хилэгнэн уурлаж, өр ширээ бүгдийг буцаан төлөх хүртэл нь түүнийг зандалчинд тушаажжээ. Түүнчлэн та нарын нэг бүр чинь ах дүүгээ зүрх сэтгэлээсээ учлахгүй бол Миний тэнгэрлэг Эцэг ч та нарт мөн тэгж хандах болно.

Уучлалын давтамж



Зураг 5.1

СҮҮРЬ ҮНДЭС Цогц бүрэн Дагалдагч бэлтгэл: Бүрханы дүр төрх

Бурхан тэвчээртэй

ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид...

- Өмнөх хичээл дээр сурсан, хэрэгжүүлсэн зүйлсээ давтана.
- Бурханы тэвчээртэй чанарын ач холбогдлыг ойлгож, талархана.
- Христтэй улам адил болохын тулд илүүтэвчээртэй болох хэрэгтэйг олж мэднэ.
- Бурханы тэвчээрийн үр дүнд бид аврагдсаныг – бидний тэвчээр ч мөн бусдад тусалдгийг харна.
- Бусдад сөргө нөлөө үзүүлдэг тэвчээргүй зан чанараа олж харан, өөрчлөгдөхийн тулд тодорхой алхам хийнэ.
- Тэвчээрийн үр жимс нь Бурханы дүр төрхийн нэг хэсэг гэдгийг ухааран түүн дотор өсөхөд зоригжино.

Залбирлаар эхлэх

- Хичээлээ эхлэхдээ нэг юм уу, хоёр дагалдагчаар залбируулах хэрэгтэй.

Тойм

Хичээлийн тойм

- Өмнөх хичээлийн гол санааг давтана.

Хэрэгжүүлэлтээс олж авсан туршлага

- Нэг юм уу, хоёр дагалдагчаар туршлага солиццуулж, ижил төстэй талуудыг нь дүгнүүлэх хэрэгтэй.

Дагалдуулагчийн ажиглалт

- Хэрэгжүүлэлтийнх нь талаар ажигласан, бодсон зүйлээ хуваалц.

Оршил

Дагуулах дасгал ажил

- Бүлгийнхэнд сурах бичиг дээрх Зураг 6.1 ба Зураг 6.2-ыг харуулна.

Судлахад туслах асуултууд

- Дасгал ажлыг ойлгоход нь туслахын тулд дагалдагчдаас асуулт асуу.
 - Зураг 6.1 дээрээс чи юу харж байна? Энэ хүн юу хийж байна?
 - Энэ хүн Бурханд хандан залбирахдаа итгэлтэй байна уу?
 - Зураг 6.2 дээрээс чи юу харж байна? Иймэрхүү хатуу захиргаатай бурхны дор амьдарвал ямар байх бол?
 - Бидний Бурхан нь Зураг 6.2-д дүрслэгдсэн бурхнаас юугаараа ялгаатай вэ?

Шилжилт

- Оршлоос хичээл уруугаа хөтлөх тодорхойлолт хий.

Өмнөх хичээлээр бид Бурханы училдаг чанарын талаар, мөн дүр төрхийн нь дагуу бүтээгдсэн бид ч адил училдаг байх ёстой талаар сурсан. Энэ хичээлээр бид Бурханы тэвчээртэй чанарыг авч үзнэ. Хэрэв Бурхан бидэнд тэвчээртэй ханддаг юм бол бид ч мөн адил аливаа нөхцөл байдалд бие биедээ тэвчээртэй хандах ёстой.

Судлал

Түлхүүр ишилэл

Эзэн удаашралыг тооцдог зарим хүмүүсийн бодгоз шиг Өөрийнхөө амлалтад хойрго биш.

Харин и Тэр хэнийг и мөхүүлэхийг хүсэлгүй,
бүгдийг зэмшилд ирээсэй хэмээн
хүсэн та наарт тэвчээртэй хангдаз.

2 Петр 3:9

Судлах асуултууд

- Асуултуудаас ургуулан товч хэлцүүлэг хөтөл.
 - Эзэний тэвчээр нь бидэнд ямар талаараа ашигтай вэ?
 - Бурхан тэвчээр муутай байсан бол энэ ертөнц яах байсан бол?
 - Петрийн сануулж буй амлалт гэсэн нь Есүсийн хоёр дахь ирэлт. Энэ ишлэлийн дагуу Есүс яагаад хараахан ирээгүй байна вэ?
 - Есүсийн үхэл ба амилалтаас гучин жилийн дараа Петр тэрхүү захиагаа бичсэн. Хүмүүс Түүний хоёр дахь ирэлтийг хүлээж тэвчихгүй болж эхэлж байсан байна. Эзэний тэвчин хүлээдэгт та талархаж байна уу?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

- Дагалдагчдад судалгааны асуултыг ашиглан Библийг судлахыг зөвлө. Оролцоог нэмэгдүүлэх үүднээс гурав, дөрвөн хүнтэй бүлгүүдэд хуваах хэрэгтэй.

Бурхан тэвчээртэй

- Ром 2:4 • 1 Тимот 1:16
 - ❑ Ром 2:4 дээр Бурхан энэрэл, хүлээц, тэвчээрээр “баян” гэж хэлсэн. Энэ гурван чанар нь элбэг арвинаар зохицон хослохын учир юу вэ? Эдгээр нь биднийг гэмшилд уур хилэнгээс илүү хурдан хөтөлдөг юм болов уу? Тийм бол яагаад тэр вэ?
 - ❑ Дамаск орох замдаа Христийг харахаасаа (Үйлс 9:1-20) өмнө Паул итгэгчдийг хяхан хавчиж байсныг санаарай. Паул яагаад мөнх амийг хүртэв? Энэ нь түүний нигүүлсэлийг ойлгох ойлголтод хэрхэн нөлөөлөв?
- Бүлгээрээ товчхон залбирах цаг гарга. Бурханд тэвчээртэй байдгийнх нь төлөө, түүгээр нь дамжин ирдэг асар их ивээлийнх нь төлөө таларх.

Бурханы дур төрх ба тэвчээр

- Дуулал 37:7 • Сургаалт үгс 14:29
 - ❑ Тэвчээр нь бидний доторх Бурханы дур төрхийг хэрхэн тусган харуулдаг вэ?
 - ❑ Зөвт бус хүмүүс амжилттай байгаад өөрсдөө амжилтгүй байх үед бид ихэнхдээ хэрхэн ханддаг билээ?
 - ❑ Сургаалт үгс нь хүлээцтэй хүнийг түргэн зантай хүнтэй харьцуулдаг. Хүлээцтэй хүнд юу байна вэ?
 - ❑ Хүнд нөхцөл байдалд түргэн зантай хүний гаргасан үйлдлүүд нь хожим ямар үр дагавар авчирдаг вэ? Хүлээцтэй хүний хандах үйлдлүүдийн хожмын үр дүн нь юу вэ?
 - ❑ Хэн нэгэн түргэн зан түргэн загнааснаас болон та гомдож байсан уу? Та хэн нэгнийг гомдоож байсан уу?
 - ❑ Хүн тэвчээргүй мөртлөө түргэн зангуй байж болох уу? Бид тэвчээргүй байдлаа өөр ямар ямар замаар харуулдаг вэ?
 - ❑ Өөрөө яг адил зүйлийг үйлчихээд бусдад тэвчээргүй хандах тохиолдол бидэнд байдаг уу? Яагаад ийм байна?
- Галат 6:9-10 • Ефес 4:1-3
 - ❑ Христэд итгэгчдийн үйл ажиллагаа гал халуунаар эхэлсэн ч зогсох тохиолдол байдаг. Сайныг үйлдэхдээ хойргошихоос бид хэрхэн зайлсхийх вэ? Шууд үр дүн гарагүй тохиолдолд бид заримдаа яадаг вэ?
 - ❑ Сүнсний нэгдмэл байдлыг хадгалахын тулд итгэгчдэд ямар ямар чанар хэрэгтэй вэ?
- Галат 5:22,25

- ❑ Бид тэвчээр дотор хэрхэн өсдөг вэ? Өсөлтийн явцад бидний хийх зүйл болон Ариун Сүнсний хийх зүйл нь юу вэ?

Бататгал

Дасгал ажил

- Ажиглалт: “Есүсийн тэвчээр” (Марк 7 ба 8)

Бэлтгэл: Дагалдагдад бататгах дасгал хичээлийн хөтөлбөрийг үзүүлж хоёр, гурван хүнтэй жижиг бүлэгт хуваана. Тэгээд бүлэг бүрд 1-р хэсэг юм уу, 2-р хэсгийг оноож өгөх хэрэгтэй.

Гүйцэтгэл: Жижиг бүлгүүд дараачийн хуудсан дээр буй жижиг бүлгийн асуултуудын дагуу өөрсдийн авсан хэсэг дээр ажиллана. Том бүлгээрээ дахин нийлээд том бүлгийн асуултуудын дагуу ярилцана.

1-р хэсэг – Цэвэр ба цэвэр бус

Фарисайчуудад хандсан Есүсийн хариу: Марк 7:5-13

Дагалдагчдад хандсан Есүсийн хариу: Марк 7:14-19

2-р хэсэг – Дөрвөн мянган хүнийг хооллосон нь

Фарисайчуудад хандсан Есүсийн хариу: Марк 8:5-13

Дагалдагчдад хандсан Есүсийн хариу: Марк 8:14-21

Жижиг бүлэгт зориулсан асуулт

- ❑ Энэ хэсгийн хам сэдэв нь юу байв?
- ❑ Есүс хэнд тэвчээртэй хандах шаардлага гарсан бэ?
- ❑ Тэр юу хэлэв, юу хийв?
- ❑ Бид Есүсээс юу сурх ёстой вэ?

Том бүлэгт зориулсан асуулт

- ❑ Энэ дөрвөн жишээнээс та нар юуг ажиглав?
- ❑ Хүмүүс буруу ойлголттой байх эсвэл санаатай эсэргүүцээд байхаар та нарт ямар санагддаг вэ?
- ❑ Та нар Есүсээс юу сурав?

Цээжлэх ажил

- Хичээлийн хөтөлбөрт орсон цээжлэх ишлэлийн картуудыг ашиглан бүлгээрээ түлхүүр ишлэлүүдийг цээжлээрэй.

2 Петр 3:9

Гол санаануудаа давтах

- Хичээлээс ойлгох гол зүйлийг дагалдагчдаас өөрсдөөс нь асуу. Тэднийг зөв хариулсан эсэхийг нь харуулажын тулд дараах жагсаалттай товчхон тулгах хэрэгтэй.

Бурхан тэвчээртэй

—Христийг дээш одсоноос хойш өнөөг хүртэлх бүх итгэгч өөрийнх нь амьдарч буй цагт Түүнийг ирээсэй гэж найдаж байсан. Бид ч мөн адил

найдан, Түүнийг хүлээж байна. Гэсэн ч Бурханы тэвчээр ба бүх хүнийг гэмшилд ирээсэй гэсэн хүсэл нь биднийг оролцуулаад сая сая хүнийг авралд хүргээд байна.

—Бурханы энэрэл, хүлээц ба тэвчээр нь хүмүүсийг гэмшилд хүргэдэг.

—Бурханы гайхамшигтай тэвчээр өөрийг нь мөнх аминд хүргэсэн гэдгийг агуу элч Паул ойлгожээ.

Бурханы дүр төрх ба тэвчээр

—Зөвт бус хүн ажил дээр тушаал дэвших юм уу, бизнесийн тал дээр амжилттай байх нь бидэнд хэцүү байдаг. Иймэрхүү үеүдэд бид Эзэнийг тэвчээртэйгээр хүлээнээр бид Христийн дүр төрхийг өөрсдийнхөө дотор тусган харуулах болно. Бид өөрсдийнхөө бус Бурханы шударга ёсонд найдах ёстай.

—Тэвчээртэй хүн агуу ойлголттой байдаг. Түргэн зантай хүмүүс хожим нь харамсах үйлдлүүдийг байнга үйлдэж байдаг. Тэд үр дагаварыг нь тооцолгүйгээр өөрсдийнхөө хайлрадаг, дотны хүмүүсийг үг ба үйлсээрээ гомдоодог.

—Бусад хүн суралцах, өөрчлөгдөх, бидний хэмжүүрт хүрэхдээ удаан байхад бид тэвчээр алдаж эхэлдэг. Хэрэв бид өөрсдөд маань Бурханы үзүүлсэн агуу тэвчээрийг санавал бусдыг буруутган шүүх гэж яаралгүй хүлээцтэй хандах болно.

—Бид Христтэй адил үйлчлэхдээ үргэлж шууд үр дүнг хараад байдаггүй. Бидэнд тулгарч буй нэг томхон асуудал нь зүрх алдалгүйгээр Христтэй хамт алхаж, хийж буй зүйлээ үргэлжлүүлэх явдал мөн. Бидний хамгийн агуу найдвар болох Христийн бидэнд өгөх мөнх шагналаас гадна Тэр биднийг энэ амьдралд маань ч бас ивээнэ гэсэн амлалт байгаа.

—Шинэ Гэрээн дээрх захицуудыг бичсэн хүмүүсийн зарим нь чуулганы доторх хуваагдлын асуудлуудтай тулж байсан пастор ахлагч нар байсан. Нэгдмэл байдлаа хадгалахад хамгийн чухал зүйл бол нэг нэгэндээ тэвчээртэй хандах явдал юм.

—Ариун Сүнс бидний амьдралд тэвчээрийн үр жимсийг ургуулдаг ч бид Түүнд цаг тутамд хариулж байх ёстай.

Дүгнэлт

- Дүгнэлт тодорхойлолтыг уншиж өгөх юмуу эсвэл хичээлийг өөрийнхөө үгээр дүгнэ.

Бурханы зан төлөвийн гол чанарууд болох Түүний агуу хүлцэл, энэрэл ба тэвчээр нь биднийг Түүн уруу татдаг. Хэрэв Тэр бидэнд хүлээцтэй хандаагүй бол бид хаана байх байсан бол? Бид бүгд нүгэл үйлдсэн ба Түүний уур хилэнг хүртэх зохистой гэж Ром 3:23 хэлдэг. Гэсэн ч Тэр бидэнд туйлын тэвчээртэй ханддаг ба хэнийг ч мөхөхийг хүсдэггүй.

Хүүхдүүд нь болохынхоо хувьд бид бусдад Түүний тэвчээрийг үзүүлэх ёстай. Бид гэр орон, ажил төрөл болон харилцаан дээрээ хэцүү нөхцөл байдалтай тулгардаг. Бид нэг бол мунхаг хандана, нэг бол ухаалгаар

хүлээцтэй хандана. Тэвчээртэй мэргэн ухаан нь нэгдмэл байдал уруу хөтөлдөг. Бид тэвчээргүй загнах болгондоо хүмүүсийг гомдоож, харилцаагаа сүйтгэж, буруу шийдвэр гаргадаг. Бид Ариун Сүнсэнд нээлттэй хандахын хэрээр Тэрээр биднийг тэвчээртэй чанарт сургаж Бурханы дүр төрхийг илүү тусган харуулахад тусалдаг.

Хэрэгжүүлэлт

Үлгэрлэх асуулт . . .

. . . ба байж болох хариулт

- Дагалдагчдад хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг бодож олоход нь туслах хэрэгтэй.
 - Дараагийн хичээлд орохын өмнө бид энэхүү сурсан хичээлээ хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ? Байж болох хариулт:
 - Хэрэв бид хэн нэгнийг тэвчээргүй зангаасаа болж гомдоосон бол харилцаагаа сэргээхийн тулд тэр хүнээсээ даруухнаар уучлал гүйж өхний алхмыг хийх хэрэгтэй. Дараа нь асуудлыг шийдэх дөлгөөн, хүлээцтэй арга замыг бодож ол.
 - Хэрэв бид эцэг эх, ах дүү, хань ижил болон үр хүүхдүүддээ үргэлж уурлан, тэднийг шүүмжилж, тэвчээргүй хандвал тэдний өмнө үйлдлийнхээ төлөө гэмшиж, өөрсдийнхөө төлөө залбирахыг гүйх ёстой. Бид өдөр бүр Бурханы тэвчээрийг хүлээн авахын тулд Түүнээс гүйх хэрэгтэй.
 - Сурах бичгийн арын хуудсанд буй нэмэлт ишлэлүүдийг унших, залбирах, Библийн хэсгээс эргэцүүлэх, түүнийгээ хэрэгжүүлэх алхам хийгээрэй.

Хувийн хариулт, шийдвэр

- Дагалдагчдад ойрын үед хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар бодох цаг гарга.
- Дараагийн хичээлд орохынх нь өмнө хэрэгжүүлэх нэг аргыг сонгуулж, дараах зүйлийг хэрэгжүүлэл тийн төлөвлөгөөн дээр нь бичүүл:
 - Юу хийх, хэзээ хийх
 - Хэнд хандсан байх (хөрш, найз, гэх мэт.)

Гүйлт хүсэлт

- Дагалдагчдыг хоёр гурваар нь жижиглэн хувааж нэг нэгнийхээ төлөө, ялангуяа хэрэгжүүлэх төлөвлөгөөнийхөө төлөө залбирахыг уриал.

Шилжих асуулт

- Шилжих асуултыг асуу. Гэхдээ хариулах, хэлэлцэх гэсний хэрэггүй.

Бурхан бидэнд тэвчээртэй ханддагт бид баярлах хэрэгтэй. Түүний хүлээцтэй чанар бмайгаагүй бол бид яах байсан бэ? Дараагийн хичээл дээр бид Бурханы мөн чанаруудын нэг болох ариун байдлыг авч үзнэ. Бурхан бол ариун. Энэ нь бидний амьдралд ямар нөлөө үзүүлэх вэ?

Төгсгөл

- Хичээлийг залбирлаар өндөрлөнө. Гэхдээ үүнээс өмнө бүх зааврыг өгсөн байх хэрэгтэй.

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ:


Дараагийн хичээл эхлэхийн өмнө:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж зөвлөгөө
- Хичээл бүрийн хооронд үзсэнээ хэрэгжүүлэх туршлага

(Дагалдагчид хэрэгжүүлэлтээ дараагийн хичээл дээр хуваалцаад бэлэн байх ёстой.)

Хэрэгжүүлэх төлөвлөгөө

Бурхан үнэхээр тэвчээртэй юу?



Zураг 6.2

СҮҮРЬ ҮНДЭС Үзүүл бүрэн Дагалдагч бэлтгэл: Бүрханы дүр төрх

Бурхан бол ариун

ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Ариун байдал гэж юу болохыг судална.
- Ариун байдал бол Бурханы гол мөн чанаруудын нэг гэдгийг сурна.
- Өөрөө ариун байдгийн адил биднийг мөн ариун байхыг Бурхан шаарддаг ба биднийг ариун байдал дотор өсөхөд тусална гэдгийг ойлгоно.
- Биднийг ариун байдалд зааварлах гол багаж нь Түүний Үг гэдгийг ойлгоно.
- Өдөр бүр илүү ариун амьдрах зориг төрнө.

Залбирлаар эхлэх

- Хичээлээ эхлэхдээ нэг юм уу, хоёр дагалдагчаар залбируулах хэрэгтэй.

Залбираал

Тойм

Хичээлийн тойм

- Өмнөх хичээлийн гол санааг давтана.

Хэрэгжүүлэлтээс олж авсан туршлага

- Нэг юм уу, хоёр дагалдагчаар туршлага солилцуулж, ижил төстэй талуудыг нь дүгнүүлэх хэрэгтэй.

Дагалдуулагчийн ажиглалт

- Хэрэгжүүлэлтийнх нь талаар ажигласан, бодсон зүйлээ хуваалц.

Оршил

Дагуулах дасгал ажил

- Бүлгийнхэнд сурх бичиг дээрх 7.1-ээс 7.4 хүртэлх зургийг харуулна.

Судлахад туслах асуултууд

- Дасгал ажлыг ойлгоход нь туслахын тулд дагалдагчдаас асуулт асуу.

Зураг 7.1 дээр юу болж байна вэ?

- Илчлэлт номын 4:8-р ишлэлийг хамтдаа уншин, тэнгэрийн улсад тэнгэр элч нартай хамт дараах угсийг хүндэтгэн хэлж байна гээд төсөөлөөд нэг үзээрэй.
- “Тусгаар байх” гэдэг бол “ариун” гэдэг үгийн нэг утга. Бүтээсэн бүхнээсээ Бурхан ямар талаараа өөр, онцгой, “тусгаар” вэ?

Зураг 7.2 Бурханы ариун байдалтай ямар холбоотой вэ?

- Хэрвээ харанхуй нь хорон муу, бузар, гэм буруугийн бэлэг тэмдэг юм бол гэрэл нь юуг илэрхийлэх бол? Бурхан Өөрийгөө юунаас тусгаар байлгадаг вэ?
- Бурханы ариун байдлыг илтгэх ямар үг байна вэ?
- “Цэвэр, шударга, зөвт” чанарууд нь “ариун” гэдэг үгэн дотроо багтана. Энэ зураг Бурханы ариун байдлыг хэрхэн дүрсэлж байна?

Зураг 7.3 юуг төлөөлж байна вэ?

- Загалмай дээр Есүс биднийг хэрхэн “ариун” эсвэл “тусгаар” болгосон бэ?

Зураг 7.4 дээр юу болж байна?

- Зураг 7.1 ба 7.2 дээрээс бид Бурханы ариун ба тусгаар байдлыг харж болно. Зураг 7.3 дээрээс Бурхан биднийг загалмайгаар дамжуулан тусгаар болгосон гэдгийг харж байна. Дөрөв дэх зурагнаас бид юу сурч болох вэ?
- Зураг 7.4 дээр хэн ярьж байна вэ?
- Бид хэрхэн ариун байх вэ? Энэ нь таны бодлоор юу гэсэн үг юм бол?

Шилжилт

- Оршлоос хичээл уруугаа хөтлөх тодорхойлолт хий.

Өмнөх хичээлээрээ бид Бурханаас тэвчээрийн төлөө гүйсан. Бурхан бидэнд хүлээцтэй ханддаг учир бид ч мөн адил бусдад хүлээцтэй хандах ёстой. Энэ хичээлээр бид Бурханы ариун байдлыг судлах ба Тэр биднийг хэрхэн ариун байлгах гэж хүсдгийг ойлгоно.

Судлал

Түлхүүр ишлэл

Харин та нарыг дүүдсан ариун төзөний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтуун. Яагаад зэвэл “Би ариун үчраас та нар ариун байгтуун” зэж бичиждсэн юм.

1 Петр 1:15-16

Судлах асуултууд

- Асуултуудаас ургуулан товч хэлцүүлэг хөтөл.
 - Бурхан биднийг ямар байлгахаар дуудсан бэ?
 - Бурхан биднийг боломжгүй зүйлд дуудсан уу?
 - Бид Бурхантай адил ариун байж чадах уу?
 - Бид одоо байгаа байдалдаа сэтгэл ханах ёстой юу, эсвэл илүү ариун болохыг хүсэх ёстой юу?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

- Дагалдагчдад судалгааны асуултыг ашиглан Библийг судлахыг зөвлө. Оролцог нэмэгдүүлэх үүднээс гурав, дөрвөн хүнтэй бүлгүүдэд хуваах хэрэгтэй.
- Еврей, Грек хэлэн дээрээс Бичээс уруу орчуулсан “ариун” гэдэг үг нь олон утгатай гэдгийг тайлбарла. Яг зөв утга нь тухайн хам сэдвээсээ хамаарна.
 - Тусгаар эсвэл онцгой ашиглалтад зориулагдсан
 - Сайн, нинжин сэтгэлт, энэрэнгүй
 - Цэвэр эсвэл цэвэршүүлсэн
 - Ариун, ёс суртахууны хувьд гэм зэмгүй
 - Шударга ба зөвт
 - Хүндэт, ариун нандин эсвэл бишрэлт

Бурхан бол ариун

- Дуулал 89:7-8
 - Энэ хэсгийг уншихад танд ямар мэдрэмж төрж байна вэ?
 - “Эмээдэс төрөм, сүрдэм агуу” Бурхан гэсэн нь ямар утгатай юм бол?
 - “Түмэн цэргийн Бурхан ЭЗЭН” гэдэг нэрийг сонсоход танд юу бодогддог вэ?
- Исааиа 5:16
 - Бидний Эзэн хэрхэн өргөмжлөгдхөн вэ?
 - Тэр ариун байдлаа хэрхэн харуулах вэ?

“Үнэн зөв” гэдэг үгээр юуг илэрхийлж байна вэ?

Бурхан биднийг ариусгадаг

- Бидний ариун байдал нь олон талтайг тайлбарлах хэрэгтэй – нэг нь бидний “Христ дотор” байгаагийн улмаас өгөгсөн ариун байдал.
- *Филиппой 4:21-22*
 - Энэ захидал дээр итгэгч хүмүүсийг юу гэж нэрлэсэн бэ? Энэ нэр итгэгч хүн бүрд хамаатай юу эсвэл өндөөр үнэлэгдсэн тодорхой бүлэг итгэгчдэд хамаатай юу? Энэ нь бидэнд юуг илэрхийлж байна вэ?
- *Колоссай 1:22-23*
 - Загалмай дээрх Христийн үхлээр дамжуулан Бурхан бидэнд ямар онцгой зүйлийг хийж өгсөн бэ? Бурхан Эцэг биднийг яаж хардаг вэ?
 - Христийн үхлээр гүйшэд илэрхийлэгдсэн Бурханы хайрын хариуд бид яах ёстай вэ?
- *Еерей 13:12*
 - Бид хэрхэн ариусгагдсан бэ?

Ариун байдал доторх өсөлт

- Бурханд ашиглагдахын төлөө тусгаарлагдан, өдөр бүр ариун байдал дотор өсөх нь ариусгалын бас нэг тал нь юм.
- *Ефес 1:4*
 - *Ефес 5:25-27*
 - Бурхан ариун ард түмэнтэй байхыг хэзээнээс хүссэн бэ?
 - Бурхан биднийг анхнаасаа төлөвлөгөөндөө оруулчихсан байсныг илэрхийл. Бид одоо тийм юм шиг харагдаж байна уу?
 - Христ чуулганыг хэрхэн цэвэрлэдэг вэ? Үр дүн нь юу вэ?
 - Ефес 5 дээр гарч буй “үг” нь юуг илэрхийлж байгаа вэ?
 - Бурханы үгийг дагалгүйгээр дан ганц уншснаар бид ариусах боломжтой гэж та бодож байна уу?

Бурханы дүр төрх – Ариун байдал

- *Ром 12:1*
 - Өөрсдийн биеэ амьд, ариун тахил болгон өргөнө гэсэн нь юу гэсэн үг вэ? Бидний “өргөл” нь Бурханд таалагдахын тулд ямар байх ёстай вэ?
 - Хэрэв бид ариун амьдралаар амьдрахгүй бол бидний өргөж буй магтаал, залбирал Бурханд таалагдах болов уу?
- *Ефес 5:3*
 - Энэ ишлэлд Бурханы ариун хүмүүст зохимжгүй нүглүүдийг жагсаасан байгаа. “Садар самуун” гэдэг нь юу юут хэлж байна вэ? “Аливаа бузар бурай, шунал” гэдэг нь юут хэлж байна? Бурхан “багахан” нүглийг тооцдог болов уу?
- *2 Тимот 2:19-22*
 - Бид “хүндэтгэлд зориулсан ариусгагдсан, Эзэндээ нийцсэн бөгөөд аливаа сайн үйлд бэлтгэгдсэн сав” байх ёстай гэж Паул бичсэн. Бид яаж ийм болох вэ? Та Эзэндээ нийцсэн, ариун багаж байхыг хүсэж байна уу?”

- ❑ “Ариун байдал” гэдгийг өөрийн үгээр тайлбарла. Ариун амьдралаар амьдарч байгаа эсэхээ яаж мэдэх вэ? Амьдралынхаа бүх талбарыг хэрхэн ариун байлгах вэ?

Бататгал

Дасгал ажил

- Магтаалын дуу: “Ариун”

Бурханы ариун байдлын тухай нэг дуу сонгоорой. Доорх дууг ашиглавал сайн ч, өөр дуу сонгож болно. Бурханы ариун байдлыг бүлгээрээ магтан дуулаарай. Аяаг нь мэдэхгүй бол үгийг нь хамтдаа уншаарай.

Жишээ нь:

- “Ариун, ариун” (“Бид Таны өмнө зурхээ өргөе”)
- “Бүгдийн Эзэн ариун, ариун, ариун” (“Эзэн бол ариун”)
- “Ариун, ариун, ариун”

Төгс хүчит Эзэн Бурхан ариун, ариун, ариун!

Өглөө эрт бид Танд магтаалын дууг өргөнө;

Ариун, ариун, ариун! Нигүүлсэнгүй, хүчит!

Бурхан гурвал байдлаар оршдог!

Төгс хүчит Эзэн Бурхан ариун, ариун, ариун!

Таны ажил цийлс Таны нэрийг алдаршуулна

Дэлхийд, тэнгэрт, далай тэнгист;

Ариун, ариун, ариун! Нигүүлсэнгүй, хүчит!

Бурхан гурвал байдлаар оршдог!

Цээжлэх ажил

- Хичээлийн хөтөлбөрт орсон цээжлэх ишлэлийн картуудыг ашиглан бүлгээрээ түлхүүр ишлэлүүдийг цээжлээрэй.

1 Петр 1:15-16

Гол санаагаа давтах

- Хичээлээс ойлгох гол зүйлийг дагалдагчдаас өөрсдөөс нь асуу. Тэднийг зөв хариулсан эсэхийг нь харуулахын тулд дараах жагсаалттай товчхон тулгах хэрэгтэй.

Бурхан бол ариун

- Бурханы ариун байдал нь Түүний төгс хүчит, агуу сүрдмээр чанарыг харуулдаг. Тэр зүгээр л нэг бузар мууд дургүй дорой бурхан биш.
- Бурхан шударга байдлаараа өргөмжлэгдсэн. Бурхан зөв шударга шүүдэг
— эд хөрөнгө, албан тушаал хардаггүй. Бурхан хүн нэг бүрийг Библид бичигдсэн шударга зарчмын дагуу шүүдэг.
- Хүүхэд сайн эцгээсээ өмээн хүндэтгэхийн адил бид Бурханаас өмээн, хүндэлж байх ёстой. Эцэг нь хүүхдээ сургах эрх мэдэлтэй ба

дуулгаваргүй занг нь сахилгажуулдаг. Гэсэн ч хүүхэд эцгийнхээ дэргэд байхад аюулгүй байдаг. Эцгийнх нь сахилгажуулалт хайрын улмаас өөрийнх нь сайны төлөө гэдгийг хүүхэд ойлгодог.

Бурхан биднийг ариусгадаг

- Шинэ Гэрээн дээр итгэгчдийг “ариун хүмүүс” гэж нэрлэдэг.
- Библи бидний ариун байдлын олон талыг заадаг. Нэг нь Бурханы өмнөх бидний байр байдал. Бид учлагдахын тулд Христийн загалмайн үхэлд итгэл найдвараа тавьснаар Бурхантай эвлэрч Түүний өмнө ариунд тооцогддог.
- Бид хэзээ ч өөрсдийнхөө хичээл зүтгэлээр Бурхантай адил төгс болж чадахгүй. Бидний зөвтөл нь зөвхөн “Христ дотор” байгаагийн улмаас юм.

Ариун байдал доторх өсөлт

- Библи биднийг амьдралын хэв маяг, үйлдлээрээ ариун байдал дотор өсөх ёстой гэж сургадаг. Бурхан биднийг ариун, гэм зэмгүй байлгахаар дуудсан. Энэ бол эрхэм хүндтэй дуудлага бөгөөд биднийг Бурханы ашиглалтад зориулж тусгаарладаг.
- Угийг уншиж, дуулгавартай дагахын хэрээр Бурхан биднийг ариусгахын тулд бидний дотор ажиллах болно.

Бурханы дүр төрх – ариун байдал

- Бидний дуурайх ёстой төгс дүр төрх бол Бурханы дүр төрх. Бид хэзээ ч Түүн шиг төгс болохгүй ч улам бүр өсөх болно.
- Есүсийн загалмай дээрх өргөл нь Хуучин Гэрээний тахил өргөх тогтолцоог халсан. Бичээс биднийг амьдралаа өргөхийг уриалж байгаагаараа ариун, зөв зүйтэй амьдралыг шаарддаг. Бид ариун амьдралаар амьдрахдаа Бурханд таалагддаг.
- Бид бүрэн ариун байдал уруу дуудагдсан. Бичээс биднийг “жаахан ч гэсэн садар самуун, бузар булаг, шунахайрал”-тай байж болохгүй гэж тушаадаг.
- Эзэндээ нийцтэй, хүндэтгэлд зориулсан сав байхыг хүсэж байвал бид бузар муугаасаа эргэх хэрэгтэй.
- Ариун байдал гэдэг бол өргөн утгатай. Энэ нь зөвхөн хорон муугаас холуур байх явдал биш юм. Ариун байдал гэдэг бол Бурханы өмнө зөв шударга амьдарч Түүнд үйлчлэхийн тулд бэлтгэгдсэн багаж байхыг хэлнэ.

Дүгнэлт

- Дүгнэлт тодорхойлолтыг уншиж өгөх юмуу эсвэл хичээлийг өөрийнхөө үгээр дүгнэ.

Бурхан бол ариун. Тэрээр илэрхийлэхийн аргагүй агуу сүр жавхлан, хүч чадал дотор оршдог. Бид Бурханы энэрэлд баясдаг.

Тэр биднийг Өөрийнхөө хүүхдүүд болгон үрчлэн авсан ч бид төгс хүчит, ариун Нэгэн болох Эзэнд үйлчилдэг гэдгээ мартаж болохгүй.

Бурхан биднийг ариусгасан. Нэг талаасаа бид Есүсийн цусаар аврагдахдаа бүрэн цэвэрлэгдэж ариун болсон. Нөгөө талаасаа өдөр тутмын амьдралыг маань ариун байлгахын тулд Бурхан бидний дотор ажиллаж байна. Бурхан үүнийг өөрийнхөө үгээр дамжуулан хийдэг. Энэ бол ариусгалыг хийдэг гол зэвсгийн нэг юм. Бид дуулгавартай дагавал тэр үг биднийг өөрчлөх чадалтай. Бид энэ үйл явцад мөн идэвхтэй оролцох хэрэгтэй. Бид өөрсдийгөө амьд, ариун тахил болгон Бурханд өргөх ёстай. Энэ бол Түүнд үнэхээр таalamжтай хүндэтгэл мөргөлийн хэлбэр юм. Бид ариун байхаар дуудагдсан. Хийж буй зүйлдээ бузар муугийн аливаа хэлбэрээс зайлсхийх ёстай. Хэрэв бид Эзэндээ нийцтэй, хүндэтгэлд зориулагдсан сав байхыг хүсэж байвал үг, үйлсдээ Түүний адил ариун байх ёстай.

Хэрэгжүүлэлт

Үлгэрлэх асуулт . . .

. . . ба байж болох хариу

- Дагалдагчдад хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг бодож олоход нь туслах хэрэгтэй.
- Дараагийн хичээлд орохын өмнө бид энэхүү сурсан хичээлээ хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ? Байж болох хариу нь:
 - Яг одоо хэн нэгэнтэй хамт залбир. Ариун байх шаардлагатай талбаруудаа нэг нэгэнтэйгээ хуваалцаж, ариусгалд бие биенээ уриал. (Бусад хүн оролцсон ёс суртахууны талын гэмээ улайхдаа нэрийг нь дурдах зэрэгт маш болгоомжтой хандах хэрэгтэй.)
 - Бурханы зорилгын төлөө өөрчилж, “тусгаарлах” шаардлагатай талбаруудыг бидэнд харуулж өгөхийг Ариун Сүнснээс гүйх. Ариун байдлыг хэрэгжүүлэх үүднээс дуулгавартай байх тодорхой алхам хий.
 - Мөс чанарын хувьд Бурханы өмнө амьдарч буйгаа санан, хийж буй бүх зүйлдээ Өөрийнх нь дүр төрхийг тусган харуулахад туслаач гэж гүйж байх.
 - Сурах бичгийн арын хуудсанд буй нэмэлт ишлэлүүдийг унших, залбирах, Библийн хэсгээс эргэцүүлэх, түүнийгээ хэрэгжүүлэх алхам хийгээрэй.

Хувийн хариулт, шийдвэр

- Дагалдагчдад ойрын үед хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар бodoх цаг гарга.
- Дараагийн хичээлд орохынх нь өмнө хэрэгжүүлэх нэг аргыг сонгуулж,

дараах зүйлийг хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөн дээр нь бичүүл:

- Юу хийх, хэзээ хийх
- Хэнд хандсан байх (хөрш, найз, гэх мэт.)

Гүйлт хүсэлт

- Дагалдагчдыг хоёр гурваар нь жижиглэн хувааж нэг нэгнийхээ төлөө, ялангуяа хэрэгжүүлэх төлөвлөгөөнийхөө төлөө залбирахыг уриал.

Шилжих асуулт

- Шилжих асуултыг асуу. Гэхдээ хариулах, хэлэлцэх гэсний хэрэггүй.

СҮҮРЬ ҮНДЭС I бараг л тэр чигээрээ Есүс дээр төвлөрсөн бол СҮҮРЬ ҮНДЭС II Бурхан Эцэгийн талаар их дурдагдаж байна. Дараагийн хичээл дээрээ бид Бурханы гурвал чанарын талаар сурна – Бурхан Эцэг, Бурхан Хүү ба Бурхан Ариун Сүнс. Гэхдээ л Бурхан бол ганц Бурхан. Бурхан бол Гурвал бөгөөд мөн тэгэхийн зэрэгцээ Нэг Нэгдмэл Нэгэн билээ. Бид Түүнтэй адил аливаа харилцаан дээрээ хэрхэн нэгдмэл байх вэ?

Төгсгөл

- Хичээлийг залбирлаар өндөрлөнө. Гэхдээ үүнээс өмнө бүх зааврыг өгсөн байх хэрэгтэй.


Залбирайл

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ:

Дараагийн хичээл эхлэхийн өмнө:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж зөвлөгөө
 - Хичээл бүрийн хооронд үзсэнээ хэрэгжүүлэх туршлага
- (Дагалдагчид хэрэгжүүлэлтээ дараагийн хичээл дээр хуваалцаад бэлэн байх ёстой.)

"Байсан, байгаа, хожим
ирэх төгс хүчтэй Эзэн Бурхан
ариун, ариун, ариун"




Зураг 7.1

"Та нарын Эзэн Бурхан
бол ариун Бурхан."




Зураг 7.2

"Бид ариун болгуулсан."



Зураг 7.3

"Надтай адил
ариун бай."



Зураг 7.4

СҮҮРЬ ҮНДЭС Цогц бүрэн Дагалдагч бэлтгэл: Бүрханы дүр төрх

Нэг нэгдмэл байдал ба Гурвал

ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Өмнөх хичээл дээр сурсан, хэрэгжүүлсэн зүйлсээ давтана.
- Бурханы гурвал шинжийг судална – гурвал мөртлөө ганц Бурхан.
- Бурханы Гурвальг нэг бүрчлэн судлан тус бүртэй нь харилцаатай болно.
- Гурван бие нь нэг нэгэнтэйгээ төгс уялдаа холбоотойг харна.
- Бусадтай илүү зөв харилцахад урамшина.

Залбирлаар эхлэх

- Хичээлээ эхлэхдээ нэг юм уу, хоёр дагалдагчаар залбируулах хэрэгтэй.

Залбираал

Тойм

Хичээлийн тойм

- Өмнөх хичээлийн гол санааг давтана.

Хэрэгжүүлэлтээс олж авсан туршлага

- Нэг юм уу, хоёр дагалдагчаар туршлага солилцуулж, ижил төстэй талуудыг нь дүгнүүлэх хэрэгтэй.

Дагалдуулагчийн ажиглалт

- Хэрэгжүүлэлтийнх нь талаар ажигласан, бодсон зүйлээ хуваалц..

Оршил

Дагуулах дасгал ажил

- Жүжигчилсэн уншлага: “Эзэний Сүнс над дээр байна”

Бэлтгэл: Энэ хичээлийн төгсгөлд буй унших хэсгийг бүлгийнхэнд бүгдэд нь хувилж өг.

Уншлага: Материалын энэ цаг дээр тараах хэрэгтэй. Исаиа 61:1-2 дээрх

Эш үзүүллэгийг Мессия Есүс хэрхэн гүйцэлдүүлж буйг Шинэ Гэрээний бичээч Лук бичин тэмдэглэснийг тайлбарла. Нэг нь Лукийн бичсэн эхний хэсгийг уншина. Дараа нь бүлгээрээ Исаиагийн ишлэлийг хамтдаа уншина. Төгсгөлд нь нэг хүн Лукийн дүгнэлт ишлэлийг уншина.

Судлахад туслах асуултууд

- Дарагал ажлыг ойлгоход нь туслахын тулд дагалдагчдаас асуулт асуу.
 - ❑ Тэр өдөр синагогт юу болсон бэ?
 - ❑ Лук, Исаиа хоёр дээрх ишлэлүүдэд Бурхан Эцэг, Есүс, Ариун Сүнс нарын нэгдмэл үйлчлэлийг хэрхэн тэмдэглэсэн байна вэ?
 - ❑ Лук, Исаиа номон дээр Есүсийн үүргийг юу гэж тайлбарласан байна вэ? Бурхан Эцэгийн оролцоо нь юу байв? Үйл явцад Ариун Сүнсний оролцоо юу байв?
 - ❑ Бурханы Сүнс Өөр дээр нь байсны илрэл болгон Есүс ямар үйлчлэлийг гүйцэлдүүлсэн бэ? Эцэг нь Есүсийг юу хийлгэхээр тосолсон бэ?

Шилжилт

- Оршлоос хичээл уруугаа хөтлөх тодорхойлолт хий.

Энэ хичээлээр бид Бурханы Нэг нэгмдэл байдал ба гурвал шинжийг авч үзнэ.

“Гурвал” гэдэг үг Библи дээр огт гардаггүй ч чуулганы түүхийн эхнээс л цорын ганц Бурханы гурвал шинжийг ойлгосоор ирсэн. Нэг Бурхан гэдгийг нь илэрхийлэхдээ “Нэгдмэл”, Эцэг, Хүү, Ариун Сүнсийг тайлбарлахдаа “гурвал” гэдэг үгийг ашиглаж байжээ.

Судлал

Түлхүүр ишилэл

Эзэн Есүсийн низүүлсэл, Бурханыа хайр,
Ариун Сүнсний нөхөрлөл та бүгдтэй
хамт байх болтугай.

2 Коринт 13:14

Судлах асуултууд

- Асуултуудаас ургуулан товч хэлцүүлэг хөтөл.
 - ❑ Коринтын чуулганд хандсан элч Паулын энэхүү ерөөл нь юугаараа өвөрмөц байна вэ?
 - ❑ Энд хэдэн Бие дурдагдаж байна? Тэд хэн бэ?

- Энэ өрөөлдөө Паул яагаад гурвууланг нь дурдсан юм бол?
- Гурвал Бурхантай харилцах харилцааг маань ямар үгээр илэрхийлэх вэ?
- Таны бодлоор нигүүлсдэг нь ганц Есүс үү? Бурхан Эцэг л зөвхөн хайрладаг уу? Ариун Сүнс л нөхөрлөлийг бий болгодог уу?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

- Дагалдагчдад судалгааны асуултыг ашиглан Библийг судлахыг зөвлө. Оролцоог нэмэгдүүлэх үүднээс гурав, дөрвөн хүнтэй бүлгүүдэд хуваах хэрэгтэй.

Бурханы Нэгдмэл шинж

- *Дэд хууль 6:4*
 - Израилийн энэхүү тунхаглааас та юуг харж чадах вэ?
 - Энд хэдэн Бурхан байна вэ?
- *Исааи 44:6*
 - Хэн “эхэн ба эцэс” вэ?
 - Энд хэдэн Бурхан гарч байна вэ?
- *1 Коринт 8:4*
 - Харь үндэстнүүд шүтээнүүддээ тахил өргөхдөө үнэн бурхдад мөргөж байсан уу?
 - Энэ ишлэлд хэдэн Бурхан байна вэ?
 - Дээрх гурван ишлэлийн дүгнэлт нь юу вэ?

Хуучин Гэрээг судлах нь

- *Эхлэл 1:26* • *Исааи 6:8*
 - Энэ хоёр ишлэл дээр хэн ярьж байна вэ? Бурхан хэнд хандаж ярьж байна вэ?
 - Ярианы сэдэв нь юу вэ?
 - Энэ нь бидэнд юуг хэлж байна вэ?

Шинэ Гэрээг судлах нь

- *Матай 3:16-17*
 - Хэн баптиسم хүртэж байна? Тэнгэрээс дуугарч буй нь Хэн бэ? Хэн тагтаа адил бууж ирэв? Хэдэн Бие дурдагдав?
- *Матай 28:19*
 - Шинэ итгэгчдэд Хэний нэрээр баптиism хүртээхийг тушаасан бэ? Хэдэн Бие дурдагдав?
- *Иохан 14:16-17*
 - Энэ хэсэгт Есүс Хэнд хандан залбирах гэж байна вэ? Тэр юуг гүйж байна вэ? Хэдэн Бие дурдагдав?

Нэгдэл ба гурвал - загвар

- *Иохан 17:20-21*
 - Есүс, Эцэг хоёрын хооронд ямар нэгэн таарамжгүй зүйл байна уу?

- ❑ Есүсийн залбирлын дагуу ертөнцийг итгүүлэх хэмжээнд бид хэрхэн нэгдмэл байх вэ?
- ❑ Итгэгчдийн дундах хайр, нэгдмэл чанарыг ажигласандаа итгэгч болсон хүмүүсийг та мэдэх үү?

Бататгал

Дасгал ажил

- Бүлгийнхэнд сурах бичиг дээрх зураг 8.1 ба 8.2-ыг харуулна.
 - ❑ Нэгдэл чанарыг энд ямар байдлаар дурсэлсэн байна вэ?
 - ❑ Бид хүмүүстэй харилцах харилцаан дээрээ нэгдмэл байдлыг сахивал энэ нь Бурханы дүр төрхийг хэрхэн харуулж байна вэ?
 - ❑ Итгэгчдийн нэгдмэл байдал нь ертенцийг Есүст итгүүлэхэд хэрхэн туслах вэ?

Цээжлэх ажил

- Хичээлийн хөтөлбөрт орсон цээжлэх ишлэлийн картуудыг ашиглан бүлгээрээ түлхүүр ишлэлүүдийг цээжлээрэй.

2 Коринт 13:14

Гол санаагаа давтах

- Хичээлээс ойлгох гол зүйлийг дагалдагчдаас өөрсдөөс нь асуу. Тэднийг зөв хариулсан эсэхийг нь харуулахын тулд дараах жагсаалттай товчхон тулгах хэрэгтэй.

Бурханы нэгдэл шинж

- Ганц л Бурхан байна. Гурван тусгаар бурхан биш юм.
- Есүс, Эцэг, Ариун Сүнс гурав нь төгс нэгдэл юм.
- Бурханы агуу төлөвлөгөөнд гурвуулаа Өөр Өөрсдийнхөө үүргийн дагуу оролцно — жишээлбэл нигүүлсэл.

Хуучин Гэрээг судлах нь

- Хуучин Гэрээнд, тэр ч байтугай бүтээлд Гурвал оролцдог.

Шинэ Гэрээг судлах нь

- Гурван бие байгааг Шинэ Гэрээ тодорхой харуулдаг.
- Энэхүү Гурвал нь Бурхан Эцэг, Бурхан Хүү (Есүс) ба Бурхан Ариун Сүнс билээ.
- Бүгд Өөр Өөрсдийн үүрэг, ажилтай.

Нэгдмэл байдал ба гурвал – загвар

- Есүс биднийг ч мөн Өөртэй нь адил нэгдмэл байлгахыг хүсдэг.

Дүгнэлт

- Дүгнэлт тодорхойлолтыг уншиж өгөх юмуу эсвэл хичээлийг өөрийнхөө үзээр дүгнэ.

Библи дээрх Бурханы нэгдмэл байдал ба гурвал шинжийн талаарх онол нь бүх цаг үеийн хамгийн агуу үнэн ба тайлагдашгүй нууц юм. Бурхан

бол Сүнс бөгөөд Сүнслэг шинжүүд нь махан биеийн шинжүүдээс өөр тул ийм байгаа юм. Бидний үзсэн харсан туршлага дотор энэ гурвал шинжтэй дүйцэхүйц зүйл үгүй. Бид ойлгохын тулд Бичээст найдах хэрэгтэй. Ганц Бурхан байдаг ч Тэрээр Гурвал төлөв байдлаар оршдог гэж Библи бидэнд хэлж байна – Бурхан Эцэг, Бурхан Хүү, Бурхан Ариун Сүнс.

Бурханы гурвал шинжийн адил биднийг ч мөн нэгдмэл байлгахын тулд Есүс Эцэгтээ залбирсан. Энэхүү нэгдмэл байдлаар Есүсийг Бурхан илгээсэн гэдэгт ертөнц итгэх болно гэж Есүс залбирсан.

Хэрэгжүүлэлт

Үлгэрлэх асуулт . . .

. . . ба байж болох хариу

- Дагалдагчдад хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг бодож олоход нь туслах хэрэгтэй.
- Дараагийн хичээлд орохын өмнө бид энэхүү сурсан хичээлээ хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ? Байж болох хариу нь:
 - Нэгдмэл байхын тулд Бурханаас Түүний мэргэн ухаан, зүрх сэтгэлийг гүйгаарай.
 - Тодорхой нэг асуудал дээр хань ижилтэйгээ санал нийлэх; гэр бүлийн харилцаагаа сэргээхэд чиглэсэн алхам хийх; эсвэл хөрш, найз нөхөд болон цуглааны гишүүнтэйгээ харилцах харилцаагаа сайжруулах гэж оролдох.
 - Сурах бичгийн арын хуудсанд буй нэмэлт ишлэлүүдийг унших, залбирах, Библийн хэсгээс эргэцүүлэх, түүнийгээ хэрэгжүүлэх алхам хийгээрэй.
 - Тус тусдаа хийгээд хүрэх байсан амжилтаас илүү амжилт гаргахын тулд бусадтай хамтарч ажилла.
 - Бусдыг Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн гэдгийг байнга санаж яв.
- Исаиа 61 дээр хэлсний дагуу бид хэрхэн ажиллаж, үйлчлэх вэ? Бид хамт олныхоо дунд Бурханы дүр төрхийг хэрхэн харуулах вэ? Жишшээлбэл:
 - Гэр оронгүй хүмүүст хоол хүнс өгөх (“ядууст сайн мэдээг хүргэх”)
 - Настай бэлэвсэн эмэгтэйг эргэх (“шаналсан зүрхтэй хүмүүсийг эдгээх”)
 - Шоронд буй хэн нэгнийг эргэх юмуу хорслоос болж “хоригдсон” хүмүүст туслах (“олзлогдогсодод эрх чөлөөг тунхаглах”)
 - Сохор хүний ажилд туслах, найздаа Бурханы “ивээлийг” олж харахад нь туслах, сүнсний дарамтаас чөлөөлөөгдхөд нь туслахын тулд хэн нэгэнтэй хамт залбирах (“хүлээстэй хүмүүсийг чөлөөлөхийн тулд”)

- Хөршүүддээ болон найз нөхдөдөө Бурханы хайрын тухай ярьж өгөх (“Эзэний тааламжит жилийг тунхаглах”)

Хувийн хариулт, шийдвэр

- Дагалдагчдад ойрын үед хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар бодох цаг гарга.
- Дараагийн хичээлд орохынх нь өмнө хэрэгжүүлэх нэг аргыг сонгуулж, дараах зүйлийг хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөн дээр нь бичүүл:
 - Юу хийх, хэзээ хийх
 - Хэнд хандсан байх (хөрш, найз, гэх мэт.)

Гүйлт хүсэлт

- Дагалдагчдыг хоёр гурваар нь жижиглэн хувааж нэг нэгнийхээ төлөө, ялангуяа хэрэгжүүлэх төлөвлөгөөнийхөө төлөө залбирахыг уриал.

Шилжих асуулт

- Шилжих асуултыг асуу. Гэхдээ хариулах, хэлэлцэх гэсний хэрэггүй. Бид ойлгоход хэцүү ч, чухал ойлголтын тухай сурлаа! Дараагийн хоёр хичээлээрээ бид Бурхан Ариун Сүнсний талаар болон Түүнтэй хэрхэн холбогдох талаар сурна. Гурвалаас гадна бидний амьдрал дахь Ариун Сүнсний ажил үүрэг нь юу вэ? “Сүнсээр дүүрэн байх” гэдэг нь юу гэсэн үг вэ?

Төгсгөл

- Хичээлийг залбирлаар өндөрлөнө. Гэхдээ үүнээс өмнө бүх зааврыг өгсөн байх хэрэгтэй.

Залбирайл

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ:


Дараагийн хичээл эхлэхийн өмнө:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж зөвлөгөө
- Хичээл бүрийн хооронд үзсэнээ хэрэгжүүлэх туршлага


(Дагалдагчид хэрэгжүүлэлтээ дараагийн хичээл дээр хуваалцаад бэлэн байх ёстой.)

Хэрэгжүүлэх төлөвлөгөө

Нэгдмэл байдлын загвар



Зураг 8.1



Зураг 8.2

Эзэний Сүнс над дээр байна

Лук 4:14-17

Есүс Сүнсний хүч дотор Галиилд буцаж ирэв. Түүний тухай зар эргэн тойрон дахь газар тархсан байлаа. Тэр синагогуудад нь сургаал зааж эхэлсэн агаад бүгд Түүнийг магтан шагшицааж байв.

Есүс Өөрийн өссөн хот Назартаа ирж, заншсан ёсоороо Амралтын өдөр синагогт орж, Судраас уншихаар босов. Түүнд эш үзүүлэгч Исаиагийн номыг өргөн барив. Есүс номыг нээн, доор бичигдсэн хэсгийг олоод:

Исаиа 61:1-2

Эзэн Бурханыя Сүнс Минийн дээр байна.

Үнир нь Эзэн намайг зөвөгсдөг сайн мэдээг
дэлгэрүүлэхийн тулд томилсон юм.

Тэр Намайг шаналсан зүрхтэй хүмүүсийг эдзээн,
олзлогдогсдог эрх чөлөөг түнхаглаж, хүлээстэй хүмүүсийг
чөлөөлөхийн тулд, мөн Эзэний тааламжит жил, бидний
Бурханыя ошоо авах өдрийг түнхаглан, бүх гашуудасдээг
тайвиргуулахын тулд болой.

Лук 4:20,21

гэж уншаад, номоо хуйлж, харгалзагчид эргүүлэн өгөөд, суув. Синагогт байсан бүгдийн нүд Түүнийг ширтэн байлаа. Тэр тэдэнд хандаж, - Энэхүү Судар өнөөдөр сонсголд тань биеллээ гэж айлдав.

СҮҮРЬ ҮНДЭС Үзүүл бүрэн Дагалдагч бэлтгэл: Бүрханы дүр төрх

Сүнсээр дүүрэн байх нь

ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид...

- Өмнөх хичээл дээр сурсан, хэрэгжүүлсэн зүйлсээ давтана.
- Ариун Сүнс гэж хэн болох, юу хийдгийг судална.
- Ариун Сүнс заах, зөвлөх, ятгах, цэвэрлэх үүрэгтэйг ойлгоно.
- Гэмшил, дуулгавар, цэвэр ариун байдал дотор амьдрах урам зоригтой болно.
- Сүнсээр дүүрэн байх боломжтой болно.
- Энэ долоо хоногт хэн нэгэн хэрэгцээтэй байгаа хүнд туслах чиглүүлэлтийг авахын тулд Ариун Сүнснээс гүйна.

Залбирлаар эхлэх

- Хичээлээ эхлэхдээ нэг юм уу, хоёр дагалдагчаар залбируулах хэрэгтэй.

Залбирал

Тойм

Хичээлийн тойм

- Өмнөх хичээлийн гол санааг давтана.

Хэрэгжүүлэлтээс олж авсан туршлага

- Нэг юм уу, хоёр дагалдагчаар туршлага солилцуулж, ижил төстэй талуудыг нь дүгнүүлэх хэрэгтэй.

Дагалдуулагчийн ажиглалт

- Хэрэгжүүлэлтийнх нь талаар ажигласан, бодсон зүйлээ хуваалц.

Оршил

Дагуулах дасгал ажил

- Жүжигчилсэн тогтолт: “Өөр нэгэн туслагч”

Бэлтгэл: Энэ хичээлийн төгсгөлд буй жүжгийн зохиолыг таван хувь хувилна. Хичээл эхлэхийн өмнө жүжгээ бэлдэх хэрэгтэй.

Тоглолт: Энэ цагт жүжгээ тогло.

Судлахад туслах асуултууд

- Дасгал ажлыг ойлгоход нь туслахын тулд дагалдагчдаас асуулт асуу.
 - ❑ Энэ жүжгээс та юу харав?
 - ❑ Есүс дагалдагчдадаа тэдний нэг нь Өөрөөс нь урвах тухай болон удахгүй Өөрөө тэдэнтэй хамт байхаа болих тухай хэлэхэд дагалдагчдад нь ямар мэдрэмж төрсөн бол?
 - ❑ Есүс дагалдагчдадаа Ариун Сүнсний тухай тайлбарлахдаа ямар ямар зүйл ярьсан бэ?
 - ❑ Есүс дагалдагчидтайгаа гурван жил гаруй хамт байсан. Ариун Сүнс тэдэнтэй хэр удаан байх вэ? Энэ нь тэднийг тайвшируулсан уу, эсвэл улам будилуулсан уу?

Шилжилт

- Оршлоос хичээл уруугаа хөтлөх тодорхойлолт хий.

Дараагийн хоёр хичээллээрээ бид Гурвалын нэг болох Ариун Сүнсний талаар сурал болно. Эхлээд амьдралд маань орших Ариун Сүнсний заах, чиглүүлэх, гэм нүглийг илрүүлэх үүргийг авч үзнэ. Тэгээд бид үнэний Сүнс болохынх нь хувьд Түүнд хэрхэн хариу үзүүлэх болон “Сүнсээр дүүрэн байх” гэдэг нь ямар утгатай болохыг харна.

Судлал

Түлхүүр ишилэл

Би Энэзээсээ зүйхаг, Тэр та нарт өөр
Туслагчийг өгнө. Тэр та нартай үүрг хамт байна –
Тэр бол үнэний Сүнс.

Иохан 14:16, 17а

Судлах асуултууд

- Асуултуудаас ургуулан товч хэлцүүлэг хөтөл.
 - ❑ Хэн үүнийг хэлсэн бэ?
 - ❑ Энэ ишлэлд Есүсийг оролцуулаад хэдэн Бие байна вэ?
 - ❑ Есүс яагаад “өөр Туслагч”-ийг өгнө гэж амласан бэ?
 - ❑ Ариун Сүнс ямар талаараа “Туслагч” вэ? “Туслагч” гэдэг үгийн оронд өөр ямар ямар үгийг хааяа ашигладаг вэ?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

- Дагалдагчдад судалгааны асуултыг ашиглан Библийг судлахыг зөвлө. Оролцоог нэмэгдүүлэх үүднээс гурав, дөрвөн хүнтэй бүлгүүдэд хуваах хэрэгтэй.

Бүх үнэний Багш

- Иохан 14:26 • Уйлс 6:8-10
 - Иохан Ариун Сүнсний нэгэн чухал үйлчлэлийг тайлбарласан. Тэр нь юу вэ? Та урьд нь үүнийг амсаж байсан уу? Есүсийн зааж байсан зүйлс яг хэрэгцээтэй цагт толгойд чинь орж ирээд л!
 - Ариун Сүнс нь “үнэний Сүнс” гэж нэрлэгддэг. Чуулганд Сүнс үнэнийг, “эрүүл сургаал”-ыг хэрхэн заадаг вэ? Сайн номлол, эрүүл сургаалаар дутахад Чуулганд юу тохиолддог вэ?
 - Стефаны үйлчлэлд гайхамшигт тэмдгүүд байсан. Мөн түүнийг ярьж байхад хүмүүс бараг эсэргүүцэж чаддаггүй байсан. Яагаад тэр вэ?

Хүлээн зөвшөөрөх, гэмээ илчлэх, дуулгавартай, цэвэр ариун байх

- Иохан 16:7-8 • 1 Иохан 1:9
 - Үнэний Сүнс нь Есүсийн зааж байсан үнэнтэй холбоотой. Хувийн амьдралд маань Сүнс хэрхэн үнэнийг заадаг вэ?
 - Хэрэв бид нүгэлтэй гэдгээ мэдвэл яах ёстой вэ? Биднийг дуулгавартай дагасны хариуд Бурхан яадаг вэ?
- Иохан 14:15-16 • 1 Коринт 6:19-20
 - Ариун Сүнс, дуулгавартай байдал хоёрын хамаарал нь юу вэ?
 - Иохан 14-ийн 15, 16-р ишлэл ямар холбоотой вэ?
 - Ариун Сүнсний орших “сүм” гэдэг нь юу вэ? Бидний хувьд энэ сүмийг арчлахад хийх шаардлагатай зүйлс нь юу вэ?
 - Залбирах цаг гарга. Бүлгийнхнийг дагуулаад залбируулаарай: “Миний ‘сүмийг’ бохир, замбраагүй болгоод байгаа ямар нэгэн юм байгаа юу? Бурханыг биеэрээ илүү сайн алдаршуулах арга зам бий юу?” Бүлгээрээ Бурханаас уччлал болон өөрчлөгдөх хүчийг гүйгаарай.

Ариун Сүнсээр дүүрэн байх

- Уйлс 1:3-8
 - Амилсныхаа дараа Есүс деч хоногийн турш дагалдагчидтайгаа хамт байсан ба тэдний нүдний өмнө тэнгэрт одсон (Уйлс 1:9-11). Үр дүнтэй гэрчлэгчид байхын тулд эдгээр дагалдагчид хаанаас хүчийг авах вэ?
- Уйлс 6:3-7
 - Эхэн үеийн чуулган үйлчлэгч болохыг хүссэн хүнд ямар шалгуурыг тавьдаг байсан бэ? “Сүнсээр дүүрэн” үйлчлэлийнх нь үр дүн нь юу байв?
- Уйлс 11:24
 - Энэ ишлэл дээр Барнабыг итгэл ба Ариун Сүнсээр дүүрэн байсан гэж байна. Үр ашиг нь юу байв?

• *Ефес 5:18*

- ❑ Энэ ишлэл нь Грек хэлэн дээрээ дараахыг илэрхийлж буй тушаал юм: “Ургэлжлүүлэн Сүнсээр дүүрсээр бай.” Бид яаж байнга Сүнсээр дүүрэн байх вэ?
- ❑ Залбирах цаг гарга. Бүлгийн хүн нэг бүрд Ариун Сүнсний дүүргэлт, Ариун Сүнсний хүч байхын төлөө залбир.

Бататгал

Дасгал ажил

- Бүлгийнхэнд сурах бичиг дээрх зураг 9.1-ийг харуулна.
 - ❑ Энэ зураглалаас та юу харж байна?
 - ❑ Ургэлж Сүнсээр дүүрэн байхын тулд энэ хүнд юу хэрэгтэй вэ?
 - ❑ Тагтаагаар дүрсэлсэн Ариун Сүнс энэ хүнд юуг авчирж байна вэ?

Цээжлэх ажил

- Хичээлийн хөтөлбөрт орсон цээжлэх ишлэлийн картуудыг ашиглан бүлгээрээ түлхүүр ишлэлүүдийг цээжлээрэй.

Иохан 14:16,17а

Гол санаагаа давтах

- Хичээлээс ойлгох гол зүйлийг дагалдагчдаас өөрсдөөс нь асуу. Тэднийг зөв хариулсан эсэхийг нь харуулахын тулд дараах жагсаалттай товчхон тулгах хэрэгтэй.

Өөр Туслагч

—Есүс дагалдагчдын Туслагч нь байсаар ирсэн. Тэр удахгүй тэднийг орхиод явахаа мэдэж байсан тул тэдэнд Ариун Сүнсийг буюу өөр Туслагчийг илгээхээ амласан. Тэрхүү Туслагч өнөөдөр ч гэсэн бидэнд туслахад бэлэн байна.

—Грек хэлэн дээрх параклет гэдэг үгийг “туслагч,” “өмгөөлөгч,” “хамгаалагч,” “тайтгаруулагч” хэмээн янз янзаар орчуулж болно. Бидэнд ямагт туслан, биднийг хамгаалан байдаг Ариун Сүнсний ажил үйлсийг эдгээр нэр тодорхойлно.

Бүх үнэний Багш

—Ариун Сүнс бол бидний багш. Сайн номлол, эрүүл сургаал бол Чуулганы маш чухал хэсэг. Бидэнд бүхий л үнэнийг заах нь Ариун Сүнсний үүрэг юм.

—Ариун Сүнс бидэнд сонссон зүйлийг маань санахад тусалдаг.

—Ариун Сүнсний мэргэн ухаан, хүчний тусlamжтайгаар Стефан өөртэй нь маргалдагчидтай мэтгэлцсэн жишээг бид харж болно.

. Хүлээн зөвшөөрөх, гэмээ илчлэх, дуулгавартай, цэвэр ариун байх

—Ариун Сүнс нүглийг илчилдэг. Бүхий л үнэнийг мэдэгч Нэгэн л зөвхөн үнэнээр ятгах боломжтой.

- Бид энэхүү ятгалгад даруу гэмшлээр хариулах ёстай. Бид ингэснээрээ цэвэрлэгдэн, ариусна.
- Ариун Сүнсний хүчийг авахын тулд бид Библид Бурханы хэлсэн зүйлүүдэд дуулгавартай байх ёстай.
- Бидний бие бол Ариун Сүнсний орших сүм билээ. Бурханыг үл хүндлэх муу зуршил, гэм нүглүүдээс биеэ хол байлгаснаар бид Бурханыг биеэрээ хүндэтгэн дээдэлнэ.

Ариун Сүнсээр дүүрэн байх

- Үр дүнтэй гэрчлэлийн хүч нь Ариун Сүнсээс ирдэг.
- Дагалдагчид хэдийгээр Есүстэй гурван жил хамт байсан ч Ариун Сүнсний хүчийг авахаас нааш үйлчлэлээ эхлээгүй.
- Эхэн үеийн Чуулган итгэл, хүч, Ариун Сүнсээр дүүрэн хүмүүсийг үйлчлэгч болгож байсан. Тэдний үйлчлэлээр сайн мэдээ тархаж олон хүн Эзэн дээр ирсэн.
- Бид үргэлж Ариун Сүнсээр дүүрэн байх ёстай. Үргэлж дүүрэн байхын тулд Бурхантай зөв харилцаатай байж, цэвэр ариун, дуулгавартай амьдралаар амьдарч, бүх зүйлд зөвхөн Түүнд найдан алхах шаардлагатай.

Дүгнэлт

- Дүгнэлт тодорхойлолтыг унишиж өгөх юмуу эсвэл хичээлийг өөрийнхөө үгээр дүгнэ.

Бидэнтэй үргэлж хамт байж, бүх үнэнийг заах өөр нэгэн Туслагчийг илгээнэ гэж Есүс амласан. Энэ бол Ариун Сүнс - үнэний Сүнс. Үр дүнтэй үйлчлэхийн тулд Ариун Сүнсээр дүүрэн байх нь чухал гэдгийг Библи сургадаг. Ариун Сүнс бидэнтэй хамт идэвхтэй ажилладаг. Өөрсдөөрөө дамжуулж Түүнийг ажиллаасай гэж хүсэж л байгаа бол бид цэвэр ариун, дуулгавартай амьдралыг өргөх хэрэгтэй.

Хэрэгжүүлэлт

Үлгэрлэх асуулт . . .

. . . ба байж болох хариулт

- Дагалдагчдад хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг бодож олоход нь туслах хэрэгтэй.
- Дараагийн хичээлд орохын өмнө бид энэхүү сурсан хичээлээ хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ? Дараах хариултууд бол боломжит хариултууд юм:
 - Туслагч бидэнтэй хамт гэдгийг үргэлж санаж яван аливаа нөхцөл байдалд Түүнээс ойлголт, чиглүүлэлтийг гүйж байх хэрэгтэй.
 - Бурханд хүндэтгэлгүй муу зуршил юмуу цэвэр бус талбраа ялан

- дийлэхийн тулд Ариун Сүнс туслахыг гүйн залбир.
- Сурах бичгийн арын хуудсанд буй нэмэлт ишлэлүүдийг унших, залбирах, Библийн хэсгээс эргэцүүлэх, түүнийгээ хэрэгжүүлэх алхам хийгээрэй.
 - Хэрэгцээтэй байгаа хэн нэгэнд ивээл болоход Ариун Сүнс чиглүүлж өгөхийн төлөө гүйгаарай.

Хувийн хариулт, шийдвэр

- Дагалдагчдад ойрын үед хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар бодох цаг гарга.
- Дараагийн хичээлд орохынх нь өмнө хэрэгжүүлэх нэг аргыг сонгуулж, дараах зүйлийг хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөн дээр нь бичүүл:
 - Юу хийх, хэзээ хийх
 - Хэнд хандсан байх (хөрш, найз, гэх мэт.)

Гүйлт хүсэлт

- Дагалдагчдыг хоёр гурваар нь жижиглэн хувааж нэг нэгнийхээ төлөө, ялангуяа хэрэгжүүлэх төлөвлөгөөнийхөө төлөө залбирахыг уриал.

Шилжих асуулт

- Шилжих асуултыг асуу. Гэхдээ хариулах, хэлэлцэх гэсний хэрэггүй. Биднийг ариусган, үйлчлэлд үр дүнтэй байлгахын тулд Ариун Сүнс биднийг дүүргэн дотор маань оршдог гэдгийг бид харлаа. Бусдыг ивээхийн тулд Ариун Сүнс биднийг чухамдаа яаж бэлтгэж, хүчирхэгжүүлж, биднээр дамжин ажилладаг юм бэ?

Төгсгөл

- Хичээлийг залбирлаар өндөрлөнө. Гэхдээ үүнээс өмнө бүх зааврыг өгсөн байх хэрэгтэй.

Залбирай

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ:
Дараагийн хичээл эхлэхийн өмнө:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж зөвлөгөө
- Хичээл бүрийн хооронд үзсэнээ хэрэгжүүлэх туршилага

(Дагалдагчид хэрэгжүүлэлтээ дараагийн хичээл дээр хуваалцахад бэлэн байх ёстой.)

Хэрэгжүүлэх төлөвлөгөө

Өөр нэгэн Туслагч

Дүрүүд

- Өгүүлэгч
- Есүс
- З дагалдагч

Өгүүлэгч: Тэдний нэг нь урвах, Есүс Өөрөө удахгүй тэднийг орхих, ертөнц тэднийг үзэн ядах тухай Есүс түгшсэн дагалдагчдадаа хэлсэн дээд өрөөнд ямар ч баяр хөөр байгаагүй. Тэр тэднийг бүрмөсөн орхихгүй бөгөөд илүү дээр Нэгэн оронд ирэхийг тэдэнд мэдүүлэхийг хүссэн. Энэ баярын зоогон дээр юу болсон байж болох талаар хамтдаа харцаа.

Есүс: Хүүхдүүд минь, Би та нартай тун богино хугацаанд байх болно. . . Та нар зүрхээ бүү зовоо. Бурханд найд; мөн Надад итгэ. . . Хэрвээ та нар Надад хайртай бол Миний тушаалыг биелүүлнэ. Та нартай үүрд хамт байх нэгэн Туслагч болох үнэний Сүнсийг Би Эцэгээсээ гүйн, та нар уруу явуулна. . . Тэр та нартай хамт, дотор чинь амьдрах учир та нар түүнийг таньж мэдэх болно. . .

Дагалдагч 1: (Удаан, гунигтайгаар) Өөр Туслагч гэнэ ээ? . . .

Дагалдагч 2: (Бодох гэж оролдоно) Үүрд хамт байна гэж үү? . . .

Дагалдагч 3: (Удаан давтан хэлнэ) Одоо бидэнтэй хамт амьдардаг, дараа бидний дотор орох?

Есүс: (Болгоомжтойгоор тайлбарлана) Энэ бүгдийг Би та нартай хамт байхдаа ярилаа. Харин Миний нэрээр Эцэгийн илгээх Ариун Сүнс болох Туслагч нь та нарт бүх зүйлийг заах бөгөөд Миний та нарт хэлж байсан бүгдийг сануулах болно.

Дагалдагч 1: (Гайхсан байдалтай). . . Ариун Сүнс гэнэ ээ?

Дагалдагч 2: (Ойлгох гэж хичээнэ) Есүс шиг бидэнд бүхнийг заадаг?

Дагалдагч 3: Таны бидэнд хэлсэн бүгдийг сануулна гээд байгаа?

Есүс: (Зөвшөөрөнгүй) Эцэгээс Миний та нар уруу илгээх үнэний Сүнс болох Туслагч ирээд Намайг гэрчилнэ.

Дагалдагч 1: (Үүнийг ойлгох гэж хичээнэ) Та бидэнд үнэний Сүнсийг илгээнэ . . .

Дагалдагч 2: Тэгээд энэ Сүнс бидэнд Таны тухай бүгдийг ярьж өгнө . . .

Дагалдагч 3: (Гуниглан) Яагаад? Яагаад тэгж байгаа юм бэ? Таныг өөрсөдтэйгээ хамт байлгамаар байна!

Есүс: (Хайрлан, гунигтайгаар) Эдгээр зүйлийг хэлснээс минь болж та нар уй гашуугаар дүүрэв. Гэвч Би та нарт үнэнийг хэлье: та нарын тусын тулд Би явж байгаа юм. Би явахгүйгээр Туслагч та нар дээр ирэхгүй; харин Би явбал, та нар уруу Түүнийг илгээх

болно.

Дагалдагч 1: (алгуурхан) Та явж байгаа нь . . .

Дагалдагч 2: Бидний сайны төлөө гэж үү . . .

Дагалдагч 3: Мөн энэ нь Туслагчийг илгээх цорын ганц зам гэж үү?

Есүс: (Зөвшөөрөн, болгоомжтойгоор илүү тайлбарлана) Энэ Сүнс ирмэгцээ ертөнцөд нүглийн буруутгалыг тулган зөвт байдал хийгээд шүүлтийг авч ирэх болно . . . хүмүүс Надад итгэдэггүй учир гэм нүгэл . . . Би Эцэг уруугаа явснаар та нар Намайг дахин харахгүй учир зөвт байдал . . . энэ ертөнцийг ноёлогч нь буруутгагдах учир шүүлт.

Дагалдагч 1: (Ойлгох гэж хичээн) Ариун Сүнс ертөнцийг гэм нүглийнх нь улмаас буруутгана . . .

Дагалдагч 2: Зөвт байдал . . . ба шүүлт . . .

Дагалдагч 3: (Гуунгтайгаар) Гэвч бид Таныг дахиж харахгүй шүү дээ!

Есүс: (Хайлран) Та нарт хэлэх та нарын одоо ойлгож чадахааргүй олон зүйл Надад бий. Харин үнэний Сүнс ирээд та нарыг бүхий л үнэн уруу хөтөлнө. Тэр Өөрөөсөө ярихгүй; Тэр зөвхөн сонссон зүйлээ ярих бөгөөд хожим болох зүйлсийг мэдүүлнэ. Надад байгаа зүйлийг та нарт мэдүүлснээр Тэр Надад алдрыг өргөх болно.

Дагалдагч 1: Энэ бүхнийг ойлгоход бэрх юм.


Дагалдагч 2: Өөр хэн бидэнд үнэнийг хэлэх вэ!

Дагалдагч 3: (Айсан байдалтай) Ялангуяа ертөнц биднийг үзэн ядаж буй тохиолдолд . . .

Есүс: Миний дотор та нар амар тайван байгаасай гэсэндээ Би энэ бүгдийг хэллээ. Энэ ертөнцөд та нар зовлонтой байх болно. Гэвч зоригтой байгтун! Би ертөнцийг ялсан (Тэнгэр өөд ширтэн залбирна) Эцэг минь, цаг боллоо . . .

СҮҮРЬ ҮНДЭС Цогц бүрэн Дагалдагч бэлтгэл: Бурханы дүр төрх

Ариусгагдсан ба дүүрсэн



Зураг 9.1

ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Өмнөх хичээл дээр сурсан, хэрэгжүүлсэн зүйлсээ давтана.
- Ариун Сүнс итгэгчдийн дотор, тэднээр дамжуулан юу хийдгийг судална.
- Ариун Сүнс биднийг зан байдал, оюун бодол, үйлсийн хувьд Бурханы дүр төрхийн дагуу болгон өөрчилдөг гэдгийг олж мэднэ.
- Бидний дотор Сүнсний хөгжүүлэхийг хүсэж буй зан төлвүүдийг ойлгоно – Ариун Сүнсний үр жимс.
- Итгэгчдийн үйлчлэлд зориулж өгдөг Ариун Сүнсний бэлгийг ялган танина.
- Бусдад Ариун Сүнсний ажиллах боломжийг олгохын тулд алхам хийнэ.

Залбирлаар эхлэх

- Хичээлээ эхлэхдээ нэг юм уу, хоёр дагалдагчаар залбируулах хэрэгтэй.

Залбираал


Тойм

Хичээлийн тойм

- Өмнөх хичээлийн гол санааг давтана.

Хэрэгжүүлэлтээс олж авсан туршлага

- Нэг юм уу, хоёр дагалдагчаар туршлага солилцуулж, ижил төстэй талуудыг нь дүгнүүлэх хэрэгтэй.

Дагалдуулагчийн ажиглалт

- Хэрэгжүүлэлтийнх нь талаар ажигласан, бодсон зүйлээ хуваалц.

Оршил

Дагуулах дасгал ажил

- Жүжигчилсэн тоглолт: “Шинэ машин”

Бэлтгэл: Машины эзэн, түүний найз хоёрын дүрд тоглох хоёр сайн дурын жүжигчинг сонгох хэрэгтэй. Энэ хичээлийн төгсгөлд буй жүжгийн зохиолыг хоёр хувь хувил. Оосортой түлхүүр болон гарын алчуур бэлдээрэй. Сандал хажуу тийш нь харуулж тавин жолоочийн суудал болгож ашиглана. Машины эзэн урд халаасандаа түлхүүрээ, хойд халаасандаа алчуураа хийсэн байна.

Жүжиг: Жүжгийг энэ мөчид тоглуул.

Судлахад туслах асуултууд

- Дасгал ажлыг ойлгоход нь туслахын тулд дагалдагчдаас асуулт асуу.
 - Та жүжгээс юуг харав?
 - Машин яаж ажилладаг вэ?
 - Машин түрэх амархан уу? Түрэх боломжтой юу?
 - Хэрвээ машин нь бидний амьдралыг, мотор нь Ариун Сүнсийг бэлэгдэж байгаа бол амьдралын маань тэрхүү “мотор”-ыг асаах түлхүүр нь юу юу байж болох вэ?

Шилжилт

- Оршлоос хичээл уруугаа хөтлөх тодорхойлолт хий.

Гурвалын Нэг болох Ариун Сүнс нь биднийг бурханлаг амьдралаар амьдарч, үр дүнтэй үйлчлэхэд хэрэгцээтэй хүчийг өгөн, биднийг дүүргэдэг. Машин мотороор хөдлөх зориулалттай байдаг шиг бид Ариун Сүнсээр удирдуулах хэрэгтэй. Энэ хичээлээр Ариун Сүнс бидний төлөө, биднээр дамжуулан бусдын сайн сайхны тулд юу хийдгийг сурх болно.

Судлал

Түлхүүр ишилэл

“Би Энэгийнхээ амласныг та нарт илзээнэ.
Харин та нар дээрээс ирэх хүчийг өмсглөө
энэ хомдоо үлд.”

Лүк 24:49

Судлах асуултууд

- Асуултуудаас ургуулан товч хэлцүүлэг хөтөл.
 - Эцэг өөдөөгөө одохын өмнө Есүсийн хэлсэн зүйлүүдийн нэг нь энэ юм. Эцэгийн амлалт юу байв?
 - Дагалдагчдыг Иерусалимд үлдэж, Ариун Сүнсийг хүлээхийг Есүс яагаад захив? Шууд хүмүүст сайн мэдээг тунхаглаад эхлэхийг яагаад тушаасангүй вэ?
 - Дагалдагчид нь “хүчийг өмсөх” тухай хэлэхдээ Есүс юуг ойлгуулах гэсэн юм бол?
 - Дагалдагчдын зүйлчлэлд Бурханы хүч яагаад хэрэгтэй юм бол? Бурханы тушаасан зүйлүүдийг хийхэд бидэнд ч бас Бурханы хүч хэрэгтэй юу? Бид өөрсдийнхөө чадалд найдвал юу болох вэ?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

- Дагалдагчдад судалгааны асуултыг ашиглан Библийг судлахыг зөвлө. Оролцоог нэмэгдүүлэх үүднээс гурав, дөрвөн хүнтэй бүлгүүдэд хуваах хэрэгтэй.

Түүний чанараар тоноглогдох

- Ром 5:5 • Галат 5:22-23
 - Бидэнд Бурханы хайрыг хүртэх боломжийг юу өгсөн бэ?
 - Бид яаж итгэгч хүний мөн чанаруудыг хүлээн авдаг вэ? Энэхүү чанарууд нь бидний доторх Бурханы дүр төрхийг хэрхэн харуулдаг вэ?
 - Ариун Сүнсний тусламжгүйгээр бид Бурхантай адил болж чадах уу?
 - Эдгээр чанарууд нь зөвхөн зарим нэг итгэгчдэд зориулагдсан уу – эсвэл бүх итгэгчид үү?

Түүний зүйлчлэлийн төлөө хүчирхэгжих нь

- Иохан 14:12-17
 - Есүс ямар ямар ажил хийсэн бэ?
 - Бид хэрхэн агуу ажлыг хийх вэ? Есүс үүнийг хэрхэн тайлбарласан бэ?
- Ром 12:6-8 • 1 Коринт 12:4-11
 - Эдгээр ишлэлд итгэгчдэд өгсөн Ариун Сүнсний бэлгүүдийн тухай бичигдсэн байдаг. Нэг хүнд энэ бүх бэлэг авьяас нь байх боломжтой болов уу? Зөвшөөрсөн эсвэл үгүйсгэснийхээ шалтгааныг хэлнэ үү?
 - Ариун Сүнсний өөр өөр бэлгүүдтэй хэсэг бүлэг итгэгчид нэгдэн илүү томоор Бурханы дүр төрхийг чуулганд болон ертөнцөд хэрхэн харуулах боломжтой вэ?
 - Бусдын сайны төлөө Ариун Сүнс таны дотор хөгжүүлээсэй гэж хүсэж буй ямар нэгэн бэлэг авьяас байна уу?
- Дагалдагч бүрд хариулах боломж олгох хэрэгтэй. Хэрвээ бүлэг тань томдоод байвал гурав, дөрвөн хүнтэй бүлгүүдэд хуваа. Бүгд хуваалцаж дууссаны дараа нэг нэгнийхээ төлөө залбир.

Түүний дүр төрхийн дагуу өөрчлөгдөх нь

- 2 Коринт 3:18 • 1 Коринт 2:10-12,16
 - Бид хэнээр дамжуулан хэрхэн өөрчлөгдөж байна вэ?
 - Христ уруу хараагаа чиглүүлэхэд бидний дотор юу болох вэ?
 - Сүнс бидэнд яаж тусалдаг вэ? Яагаад?
 - Бурханы ойлголтуудыг бид хэрхэн ухаарах вэ?
 - Ариун Сүнсээр дамжуулан Эзэний хүслийг мэдэх нь бидний доторх Христийн дүр төрхийг хэрхэн төлөвшүүлэх вэ?
- Залбирах цаг гаргаарай. Бидний доторх Бурханы дүр төрхийг сэргээх Ариун Сүнсний ажилд өөрсдийгөө захишуулах хэрэгтэй.

Бататгал

Дасгал ажил

- Бүлгийнхэнд сурах бичиг дээрх зураг 10.1-ийг харуулна.
 - Энэ зурагнаас та юу харж байна?
 - Энэ хүн Есүсийн ямар ажлыг дурсаж байна?
 - Энэ хүн яаж Есүсийн хийсэн ажлуудаас ч “илүү агуу” зүйлсийг хийх боломжтой байна вэ? Жишээлбэл, Есүс дагалдагчдын хөлийг угаасан. Бусдад даруухнаар үйлчлэхэд нь туслахын тулд Сүнс энэ хүнийг хэрхэн тоноглох боломжтой вэ?

Цээжлэх ажил

- Хичээлийн хөтөлбөрт орсон цээжлэх ишлэлийн картуудыг ашиглан бүлгээрээ түлхүүр ишлэлүүдийг цээжлээрэй.

Лук 24:49

Гол санаагаа давтах

- Хичээлээс ойлгох гол зүйлийг дагалдагчдаас өөрсдөөс нь асуу. Тэднийг зөв хариулсан эсэхийг нь харуулахын тулд дараах жагсаалттай товчхон тулгах хэрэгтэй.

Ариун Сүнсэнд найдах

—Үйлчлэлээ гүйцэтгэхийн тулд “дээрээс ирэх хүчийг өмсөхөөр” Иерусалимд хүлээх нь дагалдагчдад чухал байв. Бид ч мөн энэ хүчийг “өмсөх” хэрэгтэй.

Түүний чанаруудаар дүүрэн байх нь – Сүнсний үр жимс

—Сүнсний үр жимс нь итгэгч хүний зан төлөвөөр илрэх Бурханы дүр төрх юм.

—Зүрхэнд маань буй Бурханы хайрыг Ариун Сүнс бидэнд ойлгуулдаг ба бусдыг үнэнээр хайрлахад тусалдаг.

—Ариун Сүнс бидний дотор Бурханд таалагдахуйц чанаруудыг төлөвшүүлдэг. Эдгээрийг “Сүнсний үр жимс” гэж нэрлэдэг.

Үйлчлэлд хүчирхэгжих нь – Сүнсний ажил

—Сүнсний ажил ба бэлгүүд нь биднээр дамжуулан Бурханы дүр төрхийг

харуулдаг.

- Есүс амьдрал ба үйлчлэл дээрээ олон гайхамшигтай зүйлийг хийсэн. Тэр биднийг Өөрөөс нь ч агуу зүйлсийг Ариун Сүнсний өгөх хүчээр хийх боломжтой гэж хэлсэн.
- Ариун Сүнсний өгдөг бэлгүүд нь олон. Зарим нь бидэнд төрөлхөөс байсан чадварыг хөгжүүлснээр бий болдог бол зарим нь ер бусын чадвар юм. Чуулганыг хүчирхэгжүүлэхийн тулд Сүнс эдгээр бэлгүүдийг өгдөг.

Түүний дүр төрхийн дагуу өөрчлөгдөх нь – үргэлжлэн хийгдэх

Сүнсний ажил

- Тойм: Хүн Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн ч нүгэл үйлдсэнээр энэ нь гэмтсэн.
- Христийн загалмай дээр хийсэн ажил болон бидний амьдрал дахь Ариун Сүнсний ажлаар дамжуулан бид Түүний дүр төрхийг тусган харуулах боломжтой болсон.
- Ариун Сүнс бидэнд Бурханы ойлголтыг өгдөг. Энэ талаараа бидэнд Христийн оюун ухаан бий.
- Эзэний Сүнс бидэнд Бурханы мэдлэгийг өгөхөд түүнд нь дуулгавартай байхын хэрээр бид Бурханы дүр төрхийн дагуу өөрчлөгддөг.

Дүгнэлт

- Дүгнэлт тодорхойлолтыг уншиж өгөх юмуу эсвэл хичээлийг өөрийнхөө үгээр дүгнэ.

Ариун Сүнс бидний дотор олон зүйл хийдэг. Тэр бидний доторх Бурханы дүр төрхийг илчилдэг. Тэр Сүнсний үр жимсийг бидэнд төлөвшүүлдэг. Бидний үйлчлэлийг үр дүнтэй, хүчтэй байлгахын тулд Тэр бидэнд төрөлх болон ер бусын бэлэг авьяасуудыг өгдөг. Тэр биднийг Христтэй адил болгон өөрчилдэг. Бурханы бидэнд тушаасан бүхний хийх хүчтэй байлгахын тулд Ариун Сүнс бидний дотор, биднээр дамжуулан ажиллах хэрэгтэй!

Хэрэгжүүлэлт

Үлгэрлэх асуулт . . .

. . . ба байж болох хариу

- Дагалдагчдад хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг бодож олоход нь туслах хэрэгтэй.
- Дараагийн хичээлд орохын өмнө бид энэхүү сурсан хичээлээ хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ? Байж болох хариу нь:
 - Бидний дотор Сүнсний үр жимс, сүнслэг бэлгүүд, болон Христийн оюун ухааныг төлөвшүүлэхийг Ариун Сүнснээс гүйх хэрэгтэй. Дэвтэр дээрээ тэмдэглэл хөтлөөрэй.

- Ариун Сүнсний хүчээр удирдуулан энэ долоо хоногт хэн нэгэн хэрэгцээтэй хүнд туслаарай.
- Үйлс номыг уншин, эхэн үеийн итгэгчдээр дамжуулан Ариун Сүнсний хийсэн ажлуудыг хараарай. Хариу үйлдэл гарган, залбирч, Бичээсийг хэрэгжүүлэх алхам хийх хэрэгтэй.

Хувийн хариулт, шийдвэр

- Дагалдагчдад ойрын үед хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар бодож цаг гарга.
- Дараагийн хичээлд орохынх нь өмнө хэрэгжүүлэх нэг аргыг сонгуулж, дараах зүйлийг хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөн дээр нь бичүүл:
 - Юу хийх, хэзээ хийх
 - Хэнд хандсан байх (хөрш, найз, гэх мэт.)

Гүйлт хүсэлт

- Дагалдагчдыг хоёр гурваар нь жижиглэн хувааж нэг нэгнийхээ төлөө, ялангуяа хэрэгжүүлэх төлөвлөгөөнийхөө төлөө залбирахыг уриал.

Шилжих асуулт

- Шилжих асуултыг асуу. Гэхдээ хариулах, хэлэлцэх гэсний хэрэггүй. Ариун Сүнс бидний дотор ажилладгийг бид харлаа. Тэр биднийг сурган, тайвшруулж, засаж чиглүүлэн ариусгаж, бидний дотор Бурханы зан төлвийг төлөвшүүлж, Түүний дүр төрхийг тусган харуулж, Христийн ухаан, хүчийг бидэнд өгдөг ба үйлчлэлд бэлтгэдэг. Ариун Сүнс бидний дотор ажиллаж эхэлмэгц бид сүнсний ертөнцийн бодит байдлыг илүү мэдэрч эхэлдэг. Энэ нь нүдэнд үл үзэгдэх ертөнц юм. Бид, бидний Бурхан болон үл үзэгдэгч ертөнц гурвын холбоо хамаарал нь юу вэ?

Төгсгөл

- Хичээлийг залбирлаар өндөрлөнө. Гэхдээ үүнээс өмнө бүх зааврыг өгсөн байх хэрэгтэй.

Залбирал

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ:
Дараагийн хичээл эхлэхийн өмнө:

- Хичээл бүрийн хооронд үзүүлэх халамж зөвлөгөө
- Хичээл бүрийн хооронд үзсэнээ хэрэгжүүлэх туршлага


(Дагалдагчид хэрэгжүүлэлтээ дараагийнхичээл дээр хуваалцаад бэлэн байх ёстой.)

Хэрэгжүүлэх төлөвлөгөө

Шинэ Машин

- Эзэмшигч: (Сандлын ард талд зогсон машин түрж байгаа юм шиг жүжиглэнэ. Гараараа түлхэн, хөл нь гулссан байрлалтай байна. Хэсэг зогсоод алчуурааараа нүүрээ арчин хүчтэй амьсгална. Тэгээд дахиад “түлхэж” эхэлнэ.)
- Найз: (Хүрч ирээд машиныг нь сонирхсон янзтай тойрон алхана)
- Найз: Хөөе, юу болоод байгаа юм бэ?
- Эзэмшигч: Θө, нэг их сүртэй юм биш. (Амьсгаа нь их давчидсан байдалтай хэлээд дахин “түлхэж” эхэлнэ.)
- Найз: Чиний машин ч их гоё юм аа.
- Эзэмшигч: Баярлалаа. (Хүчтэй амьсгалан “түлхэнэ.”)
- Найз: Энэ чинийх юм уу?
- Эзэмшигч: Тийм ээ, минийх! (“Түлхэнгээ” хариулна.)
- Найз: Үнэхээр гоё юм байна.
- Эзэмшигч: Баярлалаа. (“Түлхэх” цылдлээ цргэлжслүүлнэ.)
- Найз: Чи яагаад түлхээд байгаа юм бэ?
- Эзэмшигч: Би цуглаандаа явах гэсэн юм (амьсгаадахаа болино). Тэгээд дараа нь хотын төв орж СҮҮРЬ ҮНДЭСийн бүлгийнхэнтэйгээ гэр оронгүй хүмүүст туслах гэж байна. (Хялайж, ядарсан байдалтай байна.)
- Найз: Θө, тийм үү, ямар гоё юм бэ! Чи тэгээд машинаа унаад яваач?
- Эзэмшигч: Хм! Юу гэнэ ээ? (Зогсож нүүрээ арчаад гайхсан байдалтай.)
- Найз: Чи машинаа худалдаж авахдаа түлхүүрийг нь аваагүй юм уу?
- Эзэмшигч: Θө, тийм. Чи энийг хэлээд байна уу? (Халааснаасаа түлхүүрээ гаргаж ирнэ.)
- Найз: Тийм ээ. Алив би чамд харуулъя. Нааш ир. (Машины эзнийг жолоочийн суудалд суулгахаар хаалгыг нээж өгнө.)
- Эзэмшигч: (Машин дотор ороод сууна.)
- Найз: (Хаалгыг нь хаагаад машины цонхоор харанггаа) Түлхүүрээ тийш нь (хуруугаараа заана) хийгээд эргүүл.
- Эзэмшигч: (Түлхүүрээ эргүүлээд сонсоно. Моторын дүү дуугаргана.) Үүүнинн, үүүнинн. Хөөе, энэ хүчийг нь сонс доо! Үүүнинн, үүүнинн. За баярлалаа! Энэ нь хамаагүй дээр юм байна. Чи хүргүүлэх үү?
- Найз: (Инээмсэглэн) Θө, зүгээр, зүгээр. Очоод уулзъя.
- Эзэмшигч: За. Үүүнинн, үүүнинн. Баяртай! (Баяртайгаар даллана.)
- Найз: Баяртай! (Эзэмшигчийн бахдалтай байгааг хараад баярлан гарaa даллана.)

“Илүү агуу ажил”



Зураг 10.1

СҮҮРЬ ҮНДЭС Үзүүл бүрэн Дагалдагч бэлтгэл: Бүрханы дүр төрх

Бурхан ба үл үзэгдэх ертөнц

ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Өмнөх хичээл дээр сурсан, хэрэгжүүлсэн зүйлсээ давтана.
- Тэнгэр элч, муу ёрын сүнс, Сатан зэрэг нь байдал үл үзэгдэх Сүнсний ертөнц байдгийг ойлгоно.
- Бурхан Сатанаас илүү хүчтэй бөгөөд бүх эрх мэдэл хүч чадал нь Түүнд байдгийг ухаарна.
- Есүс үхэл ба амилалтаараа Сатаныг ялан дийлснийг харна.
- Хууран мэхлэлт, уруу татлагаараа Сатан бидний доторх Бурханы дүр төрхийг үгүй хийх хүсэлтэй байдгийг болон Бурхан түүнээс нь биднийг хамгаалж сөрөн зогсох хүчийг өгдгийг олж мэднэ.

Залбирлаар эхлэх

- Хичээлээ эхлэхдээ нэг юм уу, хоёр дагалдагчаар залбируулах хэрэгтэй.

Залбираал

Тойм

Хичээлийн тойм

- Өмнөх хичээлийн гол санааг давтана.

Хэрэгжүүлэлтээс олж авсан туршлага

- Нэг юм уу, хоёр дагалдагчаар туршлага солилцуулж, ижил төстэй талуудыг нь дүгнүүлэх хэрэгтэй.

Дагалдуулагчийн ажиглалт

- Хэрэгжүүлэлтийнх нь талаар ажигласан, бодсон зүйлээ хуваалц.

Оршил

Дагуулах дасгал ажил

- Үншлага: “Үл үзэгдэгч ертөнц” (Хаадын дэд 6:8-22)

Бэлтгэл: Елишагийн тухай дараах хэсгийг дагалдагчдад эхлээд уншиж өг. Израильд дайн болж байсан. Эш үзүүлэгч Елиша хаанд

дайсны төлөвлөгөөг хэлж анхааруулж байсан тул тэдний төлөвлөгөө бүтэлгүйтсээр байв. Эцэст нь Елишаг барихаар морин тэрэгтэй арми шөнө нь ирж хотыг бүсэлсэн.

Үншилт: Бичээсийн хэсгийг хэд хэдэн хүнээр уншуулаарай. Хүн бүр хэсэг хэсгээр нь хувааж аван унших юм.

Судлахад туслах асуултууд

- Дарагал ажлыг ойлгоход нь туслахын тулд дагалдагчдаас асуулт асуу.
 - Дараа өглөө нь Елишаг гаражад юу болсон бэ?
 - Зарц нь юу харж, юу бодсон бэ? Елиша юу гэж тайлбарласан бэ?
 - Елишагийн зарц нь дараа нь юу харсан бэ?
 - Энэ хэсгээс харахад бид “Үл үзэгдэгч ертөнц” бодитоор оршин тогтнодог гэж хэлж болох уу?
 - Та үл үзэгдэгч ертөнц, тухайлбал тэнгэр элч, муу ёрын сүнснүүдийг хэзээ нэгэн цагт мэдэрч байсан уу? (Хичээлийн оршил болгон дагалдагчдаар хувийн түүхүүдийг нь хуваалцуулах хэрэгтэй.)
 - Эдгээр түүхээс харахад нүдэнд үзэгдэхгүй байгаа ч сүнслэг биетүүд бидний амьдралд чухал байр суурь өзэлдэг гэж хэлж болох уу?

Шилжилт

- Оршлоос хичээл уруугаа хөтлөх тодорхойлолт хий.

Бурхан бол сүнс бөгөөд сүнслэг ертөнцийг бүтээсэн. Бид ч гэсэн бүгд сүнстэй. Бид мэдсэн ч, мэдээгүй ч сүнслэг ертөнцтэй үргэлж холбоотой байдаг. Бурхан бидний доторх Өөрийнхөө дүр төрхийг Христээр дамжуулан сэргээх боломжтой болсон бөгөөд сэргээхийг хүсэж байгаа гэдгийг бид олж мэдсэн. Сайн мэдээ нь гэвэл үл үзэгдэгч ертөнцөд буй аливаа сүнслэг бүхнээс Бурхан хавьгүй илүү агуу билээ!

Судлал

Түлхүүр ишлэл

Бяцхан хүүхдүүг ээ, та нар Бурханыг бөгөөд
тэднийг дийлсэн. Үнэр нь та нартан дотор байзанаа
Тэр бол дэлхийг байчи наэнээс агуу.

1 Иохан 4:4

Судлах асуултууд

- Асуултуудаас ургуулан товч хэлцүүлэг хөтөл.
 - “Дэлхийд байгч нэгэн” гэдэг нь хэн бэ? (1 Иохан 4:3-ыг хар.)
 - “Та нарын дотор байгаа Нэгэн” гэдэг нь хэн бэ?
 - Бид хэнийг дийлсэн юм бэ? Яаж?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

- Дагалдагчдад судалгааны асуултыг ашиглан Библийг судлахыг зөвлө. Оролцоог нэмэгдүүлэх үүднээс гурав, дөрвөн хүнтэй бүлгүүдэд хуваах хэрэгтэй.

Бурхан ба Есүс – бүхнийг захирдаг

- Иохан 4:24 • Колоссай 1:16
- Колоссай 2:15 • 1 Петр 3:21б-22
- Иохан номын 4-р бүлэгт Бурханыг хэрхэн илэрхийлсэн бэ? Энэ нь Бурханы талаарх таны өмнөх ойлголттой хэр дүйцэж байна?
- Есүс хэр их зүйлийг бүтээсэн бэ? Үл үзэгдэх хүч, захирагч, эрх мэдэлтнүүдийг хэр олноор нь бүтээсэн бэ? Бурхан бузар муу сүнснүүдийг бүтээсэн болов уу?
- Тэрслүү хүч ба эрх мэдэлтнүүдийг Есүс хэрхэн ялан дийлсэн бэ?
- Амилсныхаа дараа Есүс тэнгэр өөд одсон. Бүх хүч чадал, тэнгэр элч, захирагчдын дээгүүр Түүнд ямар эрх мэдэл байгаа вэ?

Ариун тэнгэр элч нар

- Еврей 1:14
 - Бурханы ариун тэнгэр элч нарын нэг ажил нь юу вэ?
- Дуулал 103:20-21
 - Тэнгэр элч нарыг бид илгээдэг үү, Бурхан илгээдэг үү? Тэнгэр элч нар хэний хүсэлд захирагддаг вэ?
- Ййлс 5:18-20
 - Петрт юу тохиолдсон бэ? Тэнгэр элч нар хүнд үйлчлэхээр Бурханаас илгээгддэг өөр жишээг та санаж байна уу?

Сатан ба муюу сүнснүүд

- Лук 10:17-18
 - Дагалдагчид юу гэж хэлсэн бэ? Есүсийн хариу юут илэрхийлэв? (Исаиа 14:12-15-ыг үз.)
- Матай 25:41
 - Диавол болоод түүний дагалдагчдын мөнхийн хувь тавилан юу вэ?

Сатаны заль мэх – Ов заль ба уруу татлага

- 2 Коринт 11:3 • 1 Коринт 10:13
 - Сатан хүмүүсийг Христээс салгахаар хэрхэн уруу татдаг вэ?
 - Уруу татах нь нүгэл үү? Бурхан яагаад үүнийг зөвшөөрдөг вэ?
 - Сатан биднийг нүгэлд уруу татахдаа Бурхантай харилцах харилцааг маань яхыг хүсдэг вэ? Бидний доторх Бурханы дүр төрхийг тэр яах

хүсэлтэй вэ?

- Бурханы дүр төрх нь үнэн ба ариун байдал дээр тогтдог. Сатаны заль мэх ба уруу татлагын аргаас та юуг ажиглаж байна вэ?

Бурханы туссламж – Бидний доторх дүр төрхөө хамгаалах нь

- *Лук 4:1-14*

- Есүс Сатаны ямар гурван сорилтыг давсан бэ? Тэдгээрийг хүмүүст өнөөдөр тулгардаг сорилтуудтай харьцуулан тайлбарла.
- Есүс Сатаны уруу татлагыг ямар замаар эсэргүүцсэн бэ? Бид уруу татлагуудыг хэрхэн мөн адил даван туулах вэ?

- *Иаков 4:7*

- *1 Петр 5:8-9*

- Диаволыг эсэргүүцэхийн тулд бид юу хийх боломжтой вэ? Бид Бурханд захирагдмагц юу болдог вэ?
- Петр Сатаныг хэрхэн дүрсэлсэн бэ? Диаволыг эсэргүүцэхийн тулд бид өөр юу хийх ёстой вэ?
- Бурхангүйгээр бид диаволоос хүчтэй болов уу?

- *Ефес 6:11-17*

- Сурах бичиг дээрх Зураг 11.1-ийг хар.
- Хэдийгээр Сатан бидний доторх Бурханы дүр төрхийг устгахыг хүсдэг ч Бурхан түүнийг нь хамгаалахын тулд юу хийсэн бэ?
- Зөвт байдлын хуяг гэдэг нь юу вэ? Энэ нь биднийг хэрхэн хамгаалах вэ? Бидний дайсан хэн бэ?
- Үнэний бүс гэдэг нь юу вэ? Дайсантайгаа тулахад маань энэ нь бидэнд яаж туслах вэ? Итгэлийн бамбай нь юу вэ? Энэ нь муу нэгний сумыг хэрхэн унтраах вэ? Сүнсний сэлмийг та яаж ашиглах вэ?
- Өөр ямар зэвсэг дурдагдсан байна? Бид хэрхэн “өмсөх” вэ?
- Зэвсгүүдийг нь хараарай. Хууран мэхлэлт хийгээд сорилтоос бидний доторх Өөрийнхөө дүр төрхийг хамгаалах арга замыг Бурхан бидэнд өгсөн гэж хэлж болох уу?

Шүтээнд мөргөх явдал*

- *Илчлэлт 9:20*

- *Дэд хууль 32:16,17,21a*

- Бурхан биднийг Өөрийнх нь дүрд юмуу ямар нэгэн зүйлд мөргөхийг хүсэх үү?
- Хуурамч шүтээний цаана байгаа хүч нь юу вэ?
- Шүтээн шүтэх явдлаасаа гэмшиж, эргээгүй хүмүүст юу тохиолдох вэ?

Бататгал

- Магтаалын дуу: “Бидний Бурхан бол агуу Цайз”

Бэлтгэл: Хөгжимчдийг бэлдэх хэрэгтэй. Энэ хичээлийн төгсгөлд дууны үг нь бичигдсэн байгаа. Бүлгийн гишүүдэд хувилж өгөрэй. Эхлэхээсээ өмнө дууны үг бичигдсэн хуудасны доор буй тодорхойлолтуудыг нэг хараарай. (Мартин Льютер энэ дууны үгийг бараг 500 жилийн өмнө Германнд зохиосон бөгөөд зарим хуучны үгнүүд бий.)

*Тайлбар: Ямар нэгэн хүний гараар хийсэн шүтээн шүтэх явдал нь танай оронд газар авсан бол энэ сэдвийн дагуу бүлгээрээ ярилцан шүтээн шүтэх явдал бол мую ёрын сүнсэнд мөргөж байгаа хэрэг гэдгийг ойлгуулах хэрэгтэй.

Гол санаагаа давтах

- Хувилсан дууны үгнүүдээ тараах юмуу хичээлийн төгсгөлд буй дууны үгтэй хуудсыг харуул.
- Үгнүүдийг нь тайлбарлах хэрэгтэй. Дуулахдаа үгнүүдийг нь сайн анхаарахыг сануулаарай.
- Хэрвээ аяыг нь мэддэг бол бүлгээрээ дуулаарай. Харин мэдэхгүй бол үгийг нь хамтдаа чангаар унших хэрэгтэй.

Судлахад туслах асуултууд

- Дасгал ажлыг ойлгоход нь туслахын тулд дагалдагчдаас асуулт асуу.
 - ❑ Энэхүү дууны үгийг хараад танд юу бодогдов?
 - ❑ Бидний хичээлээс сурсан зүйл энэ дуун дээр байв уу?
 - ❑ 500 жилийн өмнө энэ дууг зохиогдсоноос хойш тулаанд өөрчлөлт орсон уу?

Цээжлэх ажил

- Хичээлийн хөтөлбөрт орсон цээжлэх ишлэлийн картыг ашиглан бүлгээрээ түлхүүр ишлэлүүдийг цээжлээрэй.

1 Иохан 4:4

Гол санаагаа давтах

- Хичээлээс ойлгох гол зүйлийг дагалдагчдаас өөрсдөөс нь асуу. Тэднийг зөв хариулсан эсэхийг нь харуулахын тулд дараах жагсаалттай товчхон тулгах хэрэгтэй.

Бурхан илүү хүчтэй

- Бидний дотор буй Бурхан нь дэлхийд буй Сатанаас илүү агуу.
- Бурхан Сатаныг захирах эрх мэдэлтэй. Сатанд зөвхөн Бурханы зөвшөөрөх эрх мэдэл л бий.
- Бид хүчтэйдээ бус Бурхан бидний дотор байгаа учир мууг ялан дийлдэг.
- Сatan, мую сүнснүүд болон тэнгэр элч нарын талаар зөв ойлголт бидэнд хэрэгтэй.
- Бурхан үзэгдэх, үл үзэгдэх – тэнгэр элч нар, хүч чадал, эрх мэдэл бүгдийг бүтээсэн. Эдгээр нь бүгд анх бүтээгдэхдээ ариун байсан. Гэсэн ч Сатан ба түүний дагалдагчид Бурханы эсрэг тэрсэлсэн.
- Сатанд бус харин Бурханд бүх хүч чадал нь оршдог. Сатанд зөвхөн Бурханаас зөвшөөрөгдсөн л эрх мэдэл бий.
- Есүс загалмай дээр цовдлогдон, үхлээс амилж, дээш одсноороо Сатаныг, гэм нүгэл ба үхлийг ялан дийлсэн. Тэнд Түүнд бүхнийг захирах эрх мэдэл бий.

Ариун тэнгэр элч нар

- Тэнгэр элч нарын нэг ажил нь итгэгчдэд үйлчлэх явдал билээ. Бурханы тушаалын дагуу тэнгэр элч нар илгээгддэг. Бид тэнгэр элч нарт тушаах, залбирах эсвэл тэдэнд мөргөх ёсгүй.
- Хүмүүст туслуулахаар, мэдээ хүргүүлэхээр тэнгэр элч нарыг Бурхан илгээж буй жишээ Библи дээр олон байдаг.
- Жишээлбэл Мария (Лук 1:19); хоньчид (Лук 2:13); Иосеф(Матай 1:24); элч нар (Үйлс 5:18-20); Филип (Үйлс 8:26); Корнел (Үйлс 10:22); Есүс (Лук 22:43); Паул (Үйлс 27:23); ба Иохан (Илчлэлт 1:1).

Сatan ба муу сүнснүүд

- Сatan ба муу сүнснүүдийг захирах эрх мэдэл Есүст бий.
- Сatan болон түүний муу сүнснүүд мөнхөд галтай нуурт тарчлах болно.
- Сatan болон түүний муу сүнснүүд Бурханы, мөн бидний дайсан болсон.

Сatanы заль мэх – ов заль ба уруу татлага

- Сatan бол Бурханы дайсан. Бидний доторх Бурханы дүр төрх нь үнэн ба ариун байдал дээр тогтдог. Бидний доторх Бурханы дүр төрхийг сэвтүүлэхийн тулд Сatan яг эсрэг зүйлийг нь буюу ов заль, уруу татлагыг ашигладаг.
- Хүмүүсийг Христээс салгахын тулд Сatan маш зальтай аргуудыг ашигладаг. Итгэгчид хуурамч сургаалаас болгоомжилж байх ёстой.
- Сatan итгэгчдийг боломжтой бүх талаар нь уруу татах гэж үздэг. Гэсэн ч Бурхан сорилтоос гарах арга замыг өгдөг. Бидний хэрээс хэтэрсэн хэмжээгээр Сatan биднийг соръж чадахгүй.
- Бид бузар мууг таньж мэдэн, эсэргүүцэж өхэлснээр Бурханы хамгаалалтын хуяг дуулгыг өмсдөг. Тэр биднийг үнэн, зөвт байдал, итгэл, амар тайван, аврал ба Сүнсний сэлмээр зэвсэглэдэг. Бурхан энэхүү хуяг дуулгаар хангасан ч “өмсөх” нь бидний хариуцлага.

Бурханы тусламж – бидний доторх дүр төрхөө хамгаалах нь

- Бидний доторх Бурханы дүр төрхийг Сatan устгахыг хүсэвч Бурхан түүний хорон санаанаас хамгаалах арга хэмжээг авсан. Сatanыг хэрхэн сөрөн зогсохыг Бурхан бидэнд тодорхой хэлдэг.
- Есүс Өөрийгөө соригдохыг зөвшөөрсөн. Энэ нь бидэнд хэд хэдэн зүйлийг заадаг: (1) Сорилт нь өөрөө нүгэл биш. Сорилт биднийг шалгадаг. (2) Бурхан зөвшөөрөөгүй л бол Сatan юу ч хийж чадахгүй. Бурханы зөвшөөрөлгүйгээр Сatan Есүсийг эсвэл биднийг соръж чадахгүй. (3) Бичээсээс иш татснаар Есүс Сatanыг эсэргүүцсэн. Бид соригдохдоо үнэн худлын ялгаа заагийг мэддэг байх ёстой. Үүнийг хийх цорын ганц арга зам бол Библиэ сайн мэдэх явдал билээ.
- Бид диаволаас чөлөөтэй байхын тулд түүнийг эсэргүүцэх хэрэгтэй. Бидэнд биеэ барьж, сонор сэрэмжтэй байхыг анхааруулсан. Сatan биднийг үргэлж соръж байдаг. Бид түүний зальтай аргуудаас сэргийлэх ёстой.
- ❑ Бид Сatanыг өөрсдийнхөө хүчээр дийлэхгүй. Бурханд захирагдан, итгэл дотроо бат зогсон, Бурханы үгийг судлан, итгэх үед бидэнд уруу татлагыг эсэргүүцэх хүч өгөгддөг.

Шүтээн шүтэх явдал

- Бурхан хэзээ ч биднийг Өөрийнх нь юмуу ямар нэгэн юмны дүрийг шүтээсэй гэж хүсдэггүй.
- Шүтээнүүдийн цаана нь муу сүнсний хүч байдаг. Хэрэв бид шүтээн шүтвэл муу сүнснүүдийг шүтэж байгаа хэрэг. Шүтээн нь бузар муугаас гадна мунхаг, хэрэгцээгүй ба хоосон. (Хичээл #1-ийг хар.)

Дүгнэлт

- Дүгнэлт тодорхойлолтыг уншиж өгөх юмуу эсвэл хичээлийг өөрийнхөө үгээр дүгнэ.

Бурхан бол сүнс. Бидэнд харагддаг материаллаг үзэгдэх өртөнцийг болон харагддаггүй сүнслэг өртөнцийг бүгдийг нь Бурхан бүтээсэн.

Түүнийг тэнгэр элч нарыг бүтээхэд тэд бүгд ариун байсан. Гэсэн ч зарим нь чөлөөт сонголтоо хийн тэрсэлж, нүгэл үйлдсэн. Тэдгээр унасан тэнгэр элч нарыг бид муу сүнснүүд гэдэг бөгөөд толгойлогчийг нь Сатан гэж нэрлэдэг.

Зөвхөн Бурхан л төгс хүч чадалтай бөгөөд хэмжээлшгүй эрх мэдэлтэй. Есүс загалмай дээр үхэн, улмаар үхлээс амилснаараа Сатан ба муу сүнснүүдийн хүчийг устгасан. Өнөөдөр Есүст сүнслэг бүхнийг захирах эрх чадал бий. Тэр бүхнээс илүү агуу. Бурхан бидэнд туслуулахаар тэнгэр элч нарыг илгээдэг ч тэд бол зарц биш.

Зөвхөн Бурхан л тэднийг хүслийнхээ дагуу илгээдэг. Бид тэдэнд мөргөж, залбирах ёсгүй. Бид зөвхөн Бурханд л мөргөж залбирах ёстой. Сатан ба түүний элч муу сүнснүүд бол бидний дайсан. Тэдний зорилго нь бүхий л сайн сайхныг сүйтгэх буюу бидний доторх Бурханы дүр төрхийг, Түүнтэй харилцах харилцааг маань гэмтээх явдал юм. Бурханы дүр төрх, мөн чанарт саад хийхийн тулд Сатан хууран мэхэлж, уруу татан янз бүрийн заль мэхийг ашигладаг.

Сатаны заль мэхийн эсрэг бат зогсон бидний доторх Бурханы дүр төрхийг хамгаалах аргыг Бурхан өгсөн. Ов заль, уруу татлагыг давахын тулд бид Бурханы бүрэн “хуяг”-ийг өмсөх боломжтой. Хэрэв бид Бурханд захирагдан, итгэл дотроо бат зогсон, зүрхэндээ Бурханы үгийг оруулбал Сатаны сорилтыг эсэргүүцэх болно.

Хэрэгжүүлэлт

Үлгэрлэх асуулт . . .

. . . ба байж болох хариу

- Дагалдагчдад хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг бодож олоход нь туслах хэрэгтэй.
 - ❑ Дараагийн хичээлд орохын өмнө бид энэхүү сурсан хичээлээ хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ? Байж болох хариу:
 - Хэрэв бид ов заль ба уруу татлагатай тэмцэлдэж байгаа бол бидний дотор байгаа Нэгэн нь дэлхийд байгч нэгнээс илүү хүчтэй гэдгийг санан Бурханд өөрсдийгөө захишуулах хэрэгтэй.
 - Хэрэв бид Сатан ба муу сүнснүүдээс айх юмуу Есүсийг илүү хүчтэй гэдэгт итгэж чадахгүй байгаа бол 1 Иохан 4:4-ийг эргэцүүлэн бодож ёстай. Амар тайвныг Бурханаас гуйх хэрэгтэй. Хамтдаа залбирахыг бусдаас гуйна.
 - Ов заль, уруу татлагын асуудалтай байгаа нэгний төлөө шаргуу залбирна. Хэрэв боломжтой бол Бурханд захирагдан муу нэгнийг эсэргүүцэхийг түүнд зөвлөнө.
 - Сатаанаас их айдаг нэгний төлөө тууштай залбрана. Муу нэгнийг захирах Есүсийн эрх мэдлийн талаар сурсан зүйлээ хуваалцана.
 - Сурах бичгийн арын хуудсанд буй нэмэлт ишлэлүүдийг унших, залбирах, Библийн хэсгээс эргэцүүлэх, түүнийгээ хэрэгжүүлэх алхам хийгээрэй.

Хувийн хариулт, шийдвэр

- Дагалдагчдад ойрын үед хичээлийг хувьдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар бодох цаг гарга.
- Дараагийн хичээлд орохынх нь өмнө хэрэгжүүлэх нэг аргыг сонгуулж, дараах зүйлийг хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөн дээр нь бичүүл:
 - Юу хийх, хэзээ хийх
 - Хэнд хандсан байх (хөрш, найз, гэх мэт.)

Гүйлт хүсэлт

- Дагалдагчдыг хоёр гурваар нь жижиглэн хувааж нэг нэгнийхээ төлөө, ялангуяа хэрэгжүүлэх төлөвлөгөөнийхөө төлөө залбирахыг уриал.

Дараагийн хичээлд бэлдэх нь

- Даалгавар: Сэтгэгдэл бичих дасгал ажил

Дасгал ажил: Сурах бичиг дээрх 12-р хичээлийг дагалдагчдад харуул (эсвэл хувилсан цааснуудаа тараа). Дагалдагчдад дараах даалгаврыг өгнө:

12-р хичээл бол СҮҮРЬ ҮНДЭС II номыг бүхэлд нь эргэн давтах дасгал

ажил юм. Хичээл бурийн талаарх сэтгэгдлээ дор хаяж нэг цаг гарган гэртээ бичээд дараагийн хичээл дээр авч ирээрэй.

Шилжих асуулт

- Шилжих асуултыг асуу. Гэхдээ хариулах, хэлэлцэх гэсний хэрэггүй.

Дараагийн хичээл дээр бид Бурханы талаар сурсан бүх зүйлээ эргэн нэг давтах болно – Түүний мөн чанар, Гурвал, Ариун Сүнс, Түүний захирдаг сүнслэг өртөнц ба Түүний дүр төрхийн дагуу бүтээгдэж, өөрчлөгднө гэдэг нь ямар болох талаар юм. Бид өөрсдийгөө Эзэний халамж, хамгаалалтанд даатгах болно. Эдгээр хичээлүүдээс танд юу хамгийн ихээр нөлөөлөв? Сэтгэгдлээ бичин дараагийн хичээл дээр авч ирээрэй.

Төгсгөл

- Хичээлийг залбирлаар өндөрлөнө. Гэхдээ үүнээс өмнө бүх зааврыг өгсөн байх хэрэгтэй.

НЭМЭЛТ ХИЧЭЭЛ: Дараагийн хичээл өхлэхийн өмнө:

- Хичээл бурийн хооронд үзүүлэх халамж зөвлөгөө
- Хичээл бурийн хооронд үзсэнээ хэрэгжүүлэх туршлага

(Дагалдагчид хэрэгжүүлэлтээ дараагийн хичээл дээр хуваалцаад бэлэн байх ёстой.)

Хэрэгжүүлэх төлөвлөгөө

Бидний Бурхан бол агуу Цайз Мартин Лютер (1529)

Бидний Бурхан бол хэзээ ч үл ганхах Хана, Цайз билээ;
Бидний туслагч Тэрээр үхлийн өвчний үерийг зогсоосон:
Эртний дайсан маань биднийг гашуудуулахыг өнөөдөр ч оролдоно;
Түүний хүч чадал, заль мэх нь харгис үзэн ядалтаас бүрдجээ
Дэлхийд түүнтэй зэрэгцэх нэгэн үгүй.

Хэрэв бид өөрсдийнхөө чадалд найдвал ялагдалд хүрнэ;
Бурханы сонгосон Нэгэн бидний талд байгаагүй бол:
Тэр нь хэн юм бол гэж та гайхаж байна уу? Тэр бол Христ Есүс;
Хүчит Эзэн бол Түүний үеийн үед орших нэр,
Тэр мөн тулаанд ялах болно.

Муу сүнсээр дүүрсэн энэ өртөнц биднийг сүрдүүлвээс,
Бурхан Өөрийн үнэнийг биднээр дамжуулж
ялалтад хүргэхийг амласан учраас бид айхгүй:
Харанхуйн Жонон харгис хэрцгий ч бид түүнээс айхгүй;
Түүний ялагдал нь гарцаагүй тул уур хилэнг нь бид тэсэх болно,
Нэг жижигхэн үг л түүнийг унагаах болно.

Тэр үг нь дэлхийн бүхий л
эрх мэдлээс дээгүүр ба тэдэнд бид үл мөргөнө;
Бидний талд буй Түүгээр дамжуулан Сүнс ба бэлгүүд нь биднийх:
Сайн сайхан бүхэн, цусан төрлийнхөн болон энэ амьдралаа ч алдъя;
Тэд биеийг нь алж чадах ч: Бурханы үнэн байсаар байх болно,
Түүний хаанчлал нь Мөнхийх билээ.

Цайз: Бат газар; хоргодох, тусlamж авах эх үүсвэр. (Дуулал 46:7)

Хана: Хамгаалалтын хана; довтолгоог хамгаалах хамгаалалт.


Үхлийн: Агуу их өршөөлгүй үзэн ядалтыг илэрхийлнэ; төгсгөл нь үхэл.

Өвчин: Гамшиг, хор хөнөөл, хорон муу.

Заль мэх: Хорон муугийн хууран мэхлэлт, атгаг санаа, ов мэх.

Хүчит Эзэн: Төгс хүчит Эзэн, түмэн цэргийн Эзэн (Ром 9:29 ба Иаков 5:4).

**Бидний дотор буй
Бурханы дүр төрхийг хамгаалах нь**



Зураг 11.1

Миний доторх Бурханы дүр төрх

ҮР ДҮН: Энэ хичээлээр дагалдагчид . . .

- Өмнөх хичээл дээр сурсан, хэрэгжүүлсэн зүйлсээ давтана.
- СУУРЬ ҮНДЭС II номын үндсэн санаануудыг давтана.
- Зарчмуудаа амьдралдаа хэрхэн сайн хэрэгжүүлж буйгаа үнэлцгээнэ.
- Бурханы дүр төрхийн дагуу осож, бусдад ивээл болоход урамшин зоригжино.

Залбирлаар эхлэх

- Хичээлээ эхлэхдээ нэг юм уу, хоёр дагалдагчаар залбируулах хэрэгтэй.

Залбирал

Тойм

Хичээлийн тойм

- Өмнөх хичээлийн гол санааг давтана.

Хэрэгжүүлэлтээс олж авсан туршлага

- Нэг юм уу, хоёр дагалдагчаар туршлага солилцуулж, ижил төстэй талуудыг нь дүгнүүлэх хэрэгтэй.

Дагалдуулагчийн ажиглалт

- Хэрэгжүүлэлтийнх нь талаар ажигласан, бодсон зүйлээ хуваалц.
- Энэ хичээл бол СУУРЬ ҮНДЭС II номын үндсэн санаануудыг давтах хичээл гэдгийт тайлбарлаарай. 12-р хичээлийн даалгаврыг 11-р хичээл дээр өгсөн учраас бүлгийнхэн сэтгэгдлээ бичээд ирсэн байх ёстой.

Оршил

Дагуулах дасгал ажил

- Бүлгийнхэнд сурах бичиг дээрх зураг 12.1-ийг харуулна.

Судлахад туслах асуултууд

- Дасгал ажлыг ойлгоход нь туслахын тулд дагалдагчдаас асуулт асуу.
 - Энэ зургийг та 2-р хичээл дээр харсан. Бурханы бүтээлийн аль хэсгийг

энэ нь төлөөлж байна вэ?

- Бурхан эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээхдээ ямар загварыг ашигласан бэ?
- Өөрсдийнхөө дотор буй Бурханы дүр төрхийг хөгжүүлэхийн тулд бид юу хийх боломжтой вэ?

Шилжилт

- Оршлоос хичээл уруугаа хөтлөх тодорхойлолт хий.

СҮҮРЬ ҮНДЭС II дээр бид Бурханы талаар сурсан. Хүн төрөлхтөн анх Түүний дүр төрхийн дагуу бүтээгдснийг бид олж мэдсэн. Гэм нүгэл бидний доторх Бурханы дүр төрхийг гэмтээсэн тул бид дахин сэргээгдэн өөрчлөгдөх шаардлагатай болсон. Энэхүү сүүлийн хичээлийн гол зорилго нь бид сурсан бүхнээ эргэн дүгнэж, тэдгээрийн үнэ цэнийг ойлгож мэдэхэд оршино.

Судлал

- Дөрвөөс зургаан хүнтэй бүлэг болж хуваагдаж сэтгэгдлээ хуваалцаарай.

#1 Бурханы дүр төрх

Эхлэл 1:27

Тэгээд Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж, Бурханы дүр төрхөөр эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээв.

- Бид Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн. Нэгэнт Бурханы дүр төрхийг агуулж байдгийнх нь хувьд хүн төрөлхтний үнэ цэнг ойлгох болсон тул энэ нь таны өөрийгөө болон бусдыг үзэх үзэлд хэрхэн нөлөөлж байна вэ?

Сэтгэгдэл _____

#2 Эхэнд Бурхан

Эхлэл 1:1

Эхэнд Бурхан тэнгэр газрыг бүтээжсээ.

- Бурхан бол бүхний агуу Бүтээгч. Тэр бидэнд бүтээлч чанарыг өгсөн нь гайхалтай. Түүгээр бид урлаг, яруу найраг, дуу хөгжим, бизнест төрөх шинэ санаа, үйлчлэл ба хувийн амьдралаа зохицуулдаг. Та ойрын үед ямар бүтээлч зүйл хийв? Бүтээлч чанар тань Бурханы дүр төрхийг тусган харуулдаг гэдгийг та мэдсэн үү?

Сэтгэгдэл _____

#3 Бурхан бүхнийг захирдаг

Матай 28:18

Есүс ойртон ирээд, тэдэнд “Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн” гэж айлдаа.

- Есүст бүх эрх мэдэл өгөгдсөн ба тэнгэр газар дээр оршигч бүхэн Түүний өмнө өвдөг сөгдөх болно. Тэрээр бүрэн эрх мэдэлтэй ч бидэнд Өөрт нь захирагдах, үгүйг сонгох чөлөөт сонголтыг өгсөн. СУУРЬ ҮНДЭС II номыг сурах явцдаа Есүсийн Хаанчлалд амьдралынхаа ямар нэг хэсгийг та захишуулсан уу? Юу болсон бэ?

Сэтгэгдэл _____

#4 Эцэгийн зүрх сэтгэл

Ром 8:15,16

Дахин айдас түргэх боолчлолын сүнсийг та нар хүлээн аваагүй, харин црчлэлийн Сүнсийг авсан билээ. Түүгээр бид “Аав! Эцэг минь!” гэж дууддаг. Биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг Сүнс Өөрөө бидний сунстэй хамт гэрчилдэг.

- Бурхан Өөрийн хүүхдүүд болох биднийг халамжилдаг. Түүний дүр төрхийг агуулж байдгийнхаа хувьд бид ч мөн адил бусдад халамж үзүүлэх хэрэгтэй. Сүүлийн хэдэн долоо хоногт та хэн нэгэнд Бурханы халамжийг үзүүлсэн үү? Яаж харуулсан бэ? Ирж буй долоо хоногуудад та хэрхэн харуулах вэ?

Сэтгэгдэл _____

#5 Бурхан уучилдаг

Ефес 4:32

Бурхан та нарыг Христ дотор уучилсны адил бие биенээ уучлан, нэг нэгнийгээ энэрэн уян зөвлөн сэтгэлээр ханд.

- Христ Есүсээр дамжин ирсэн Бурханы уучлагаас бид агуу ашиг

шиимийг нь хүртсэн. Биднийг хүмүүс яаж ч гомдоож байсан бид мөн уучлах ёстай. Таны эсрэг нүгэл үйлдсэн хүмүүсийг уучлах тал дээр та хэр төлөвшиж байгаагаа бодоорой.

Сэтгэгдэл _____

#6 Бурхан тэвчээртэй

2 Петр 3:9

Эзэн удаашралыг тооцдог зарим хүмүүсийн боддог шиг Өөрийнхөө амлалтад хойрго биш билээ. Харин ч Тэр хэнийг ч мөхцилэхийг хүсэлгүй, бүгдийг гэмшилд ирээсэй хэмээн хүсэн та наарт тэвчээртэй ханддаг.

- Бурханы тэвчээрийн үр дүнд бид аврагдсан. Тэвчээрийн үр жимс нь үнэхээр сайхан. Сүүлийн үед танд илүү тэвчээртэй болоход тань юу юу тус болсон бэ? Бурханы танаас хүсэж буй тэвчээрийг зарим талаараа та гаргаж чадахгүй байгаа хэвээрээ юу?

Сэтгэгдэл _____

#7 Бурхан бол ариун

1 Петр 1:15-16

Харин та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтун. Яагаад гэвэл “Би ариун учраас та нар ариун байгтун” гэж бичигдсэн юм.

- Бид Бурханаар ариусгагдсан. Мөн бид ариун байдал дотор өсөж байгаа. Энэ бол амьдралын турш үргэлжлэх үйл явц юм. Бурханд хүндэтгэлгүй зүйлсээс бид эргэж, Түүнийг алдаршуулдаг зүйл уруу хандах ёстай. Амьдралд тань Бурханы илүү ариун болгохыг хүсэж буй талбар байна уу? Танд тустай юуг та сурав?

Сэтгэгдэл _____

#8 Нэгдмэл байдал ба Гурвал

2 Коринт 13:14

Эзэн Есүс Христийн нигүүлсэл, Бурханы хайр, Ариун Сүнсний

нөхөрлөл та бүгдтэй хамт байх болтугай.

- Бурхан, Эзэн Есүс ба Ариун Сүнс төгс нэгдэлтэй. СҮҮРЬ ҮНДЭС II номыг сурснаар таны бусадтай харилцах харилцаа сайжирсан уу? Эсвэл илүү нэгдмэл болгохоор зэхэж буй харилцаагаа тодорхойлно уу.

Сэтгэгдэл _____

#9 Сүнсээр дүүрэн байх нь

Иохан 14:16,17а

“Би Эцэгээсээ гүйхад, Тэр та нарт өөр Туслагчийг өгнө. Тэр нь та нартай цурд хамт байна. Тэр бол үнэний Сүнс мөн.”

- Бид ганцаараа биш. Хэрэв бид гуйвал Бурхан бидэнд Ариун Сүнснийг өгнө гэдгээ амласан. Ариун Сүнс бол бүхий л үнэний холбоос ба тайтгаруулагч билээ. Ариун Сүнс мөн бидний нүглийг илчилж өгдөг. Ингэснээр бид гэмшиж, цэвэрлэгдэх хэрэгтэй. Ариун Сүнсээр дүүргэж өгөөч гэж та Бурханаас гүйсан уу? Хэрэв та хүсэж байвал Ариун Сүнс таныг үргэлж дүүргэн оршиж байхын төлөө болон та өөрөө үнэний амжилттай гэрчлэгч байхын төлөө бүлгийнхнээрээ залбируулаарай.

Сэтгэгдэл _____

#10 Сүнсний ажил

Лук 24:49

Би Эцэгийнхээ амласныг та нарт илгээнэ. Харин та нар дээрээс ирэх хүчийг өмстлөө энэ хотдоо үлд.

- Христитгэлийн амьдралд бусдыг ивээхийн тулд бид Ариун Сүнсний хүч чадалд найдах ёстой. Сүнсний үр жимсийг Ариун Сүнс бидний дотроос ургуулахын хэрээр бид Бурханы дүр төрхийг агуулдаг. Есүс Ариун Сүнсний хүчээр агуу ажлуудыг гүйцэтгэж байсан ба биднийг ч мөн адил ажлуудыг хийх болно гэдгийг амласан. Энэ талаараа ч бид мөн Бурханы дүр төрхийг агуулна. Ариун Сүнс биднийг Бурханы дүр төрхийн дагуу шинэчлэн өөрчилж байгаа гэдгийг Бичээс хэлдэг. Ариун Сүнсийн хамт алхахын хэрээр та хувьдаа юу сурав?

Сэтгэгдэл _____

#11 Бурхан ба үл үзэгдэх ертөнц

1 Иохан 4:4

Бяцхан хүүхдүүд ээ, та нар Бурханых бөгөөд тэднийг дийлсэн. Учир нь та нарын дотор байгаа Тэр бол дэлхийд байгч нэгнээс агуу.

- Бурхан бол сүнс бөгөөд Сатан хийгээд бүхий л сүнслэг биеийг захирдаг. Сатаны зорилго бол бидний доторх Бурханы дүр төрхийг буюу Түүний ажлыг сүйтгэх юм. Бурхан бидний дотор байж, бидэнд хүчийг өгдөг тул бид муу нэгнийг эсэргүүцэн бат зогсох болно. Ойрын үед уруу татлага, заль мэхийг гайхалтайгаар ялан дийлсэн тохиолдол танд байна уу? Товчхон хуваалцаарай.

Сэтгэгдэл _____

#12 Миний доторх Бурханы дүр төрх

- СҮҮРЬ ҮНДЭС II номноос танд хамгийн их хэрэгтэй байсан хоёр, гурван зүйлийг нэрлэнэ үү? Өдөр тутмын тань амьдралд туслах, Бурханы талаар ямар ойлголтыг та авав? Таны анх бүтээгдсэн хэв шинж болох Бурханы дүр төрхийн дагуу өөрчлөгдхөд танд юу тусалсан бэ?

Сэтгэгдэл _____

- Хичээл хоорондох хэрэгжүүлэлтийн явцад танд хамгийн их нөлөөлсөн хэрэгжүүлэлт юу байв? Аль хэрэгжүүлэлт тань бусдад илүү нөлөөлөв? Яагаад?

Сэтгэгдэл _____

Дүгнэлт

- Дүгнэлт тодорхойлолтыг уншиж өгөх юмуу эсвэл хичээлийг өөрийнхөө үзээр дүгнэ.

Бид Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн. Бурханы талаар сурах

бүрдээ бид өөрсдөө ямар байж болохыг олж мэддэг. Бид Ариун Сүнстэй хамтран ажиллахын хэрээр өдөр ирэх тусам Бурханы дүр төрхтэй адил болдог.

Хэрэгжүүлэлт

Хувийн хариулт, шийдвэр

- Бурханы дүр төрхийг амьдралаараа үргэлж тусган харуулж, бусдад Түүний хайрыг дамжуулдаг байхын төлөө Бурханаас гүйж, өөрсдийгөө зориулахыг дагалдагчдад уриалах хэрэгтэй.

Залбирал ба томилгоо

- Бүлгийнхнийг дагуулан хаалтын залбирал ба томилгоог хий. Өөрсдийгөө Эзэнд даатган залбирах хэрэгтэй. Өөрийнхөө дүр төрхийг улам илчилж, Ариун Сүнсээр дамжуулан биднийг шинэчлэн өөрчлөхийг Түүнээс гүйгаарай. Бие биенийхээ төлөө залбиран нэг нэгнээ Эзэний үйлчлэлд тослон томил.

Шилжих асуулт

- Шилжих асуултыг асуу. Гэхдээ хариулах, хэлэлцэх гэсний хэрэггүй.


Бид Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэнээ СУУРЬ ҮНДЭС II номноос олж мэдлээ. Бид Бурханы мен чанар, Гурвал, Ариун Сүнс ба Түүний захирдаг сүнслэг ертөнцийг сурч мэдсэн. Тэр бол бидний Бурхан, Эцэг, Эзэн, Аврагч ба Тайтгаруулагч билээ. Бид хэрхэн Бурханд захирагдаж, Түүний Үгэнд амтархан орж, Түүний дүр төрхийг харуулж амьдрах вэ?

Төгсгөл

- Хичээлийг залбирлаар өндөрлөнө. Гэхдээ үүнээс өмнө бүх зааврыг өгсөн байх хэрэгтэй.
- Хувийн судалгаа, чимээгүй цагаараа цээжлэх ишлэлийн картуудаа үргэлжлүүлэн ашиглаж байхыг дагалдагчдад уриал.
- Хэрэгжүүлэлт хэзээ ч дуусдаггүйг бүлгийнхэнд хэлж урамшуул!
- СУУРЬ ҮНДЭСийн загварыг өөрсдөө хичээл заахдаа чөлөөтэй ашиглах болохыг хэлээрэй.
- Бүлгээрээ цаашдын төлөвлөгөөгөө хэлэлц. СУУРЬ ҮНДЭС III номыг олохыг хичээгээрэй.
- Бусад дагалдагчдыг Бурханы дүр төрхийн дагуу амьдрахад уриалан урамшуулж байхыг зөвлөх хэрэгтэй.

Хэрэгжүүлэх төлөвлөгөө

Бидний доторх Бурханы дүр төрх



Зураг 12.1

СҮҮРЬ ҮНДЭС Үзүүл бүрэн Дагалдагч бэлтгэл: Бүрханы дүр төрх

Дагалгуулазийн хөтөч



-
- СҮҮРЬ ҮНДЭСийн тухай
 - Дагалдажи бэлтгэхийн сүүрь үндэс
-

СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийн тухай

*Христийн үйлчлэлд амьдралаа зориулж явваа ахан дүүст зориулсан
дагалдагч бэлтгэх цогц сургалт*

Дагалдагч бэлтгэлийн СУУРЬ ҮНДЭС

Дагалдагч бэлтгэлийн энэхүү хөтөлбөрийг СУУРЬ ҮНДЭС хэмээнэ. СУУРЬ ҮНДЭС гэдэг нь англиар “Христийн үйлчлэлд явж буй ах эгч, дүүс” хэмээх үгийн товчлол юм. Гэхдээ “СУУРЬ ҮНДЭС”ийн гол утга нь Есүсийн дагалдагч байхын “үндсэн” зарчмуудыг агуулж байгаадаа оршино. СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийн 1-р боть нь Хаан Есүс хэмээх гарчигтай. СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийн энэхүү 2-р боть нь Бурханы дүр төрх хэмээх гарчигтай. СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийн бусад материалуудын жагсаалт дотор талын Эхний нүүрэнд байгаа.

Бебэстрийн толь бичигт “дагалдагч” гэдгийг “өөр нэгний онол сургаалыг хүлээн авч, үүнийг бусдад тунхаглах ажилд тусалдаг хүн.” хэмээн тодорхойлжжээ. “Дагалдагч” ба “судлаач” хэмээх үгнүүд нь нэг язгууртай. Товчоор хэлбэл, дагалдагч нь өөр нэгний сургаалыг мэддэг, дагадаг мөн бусдыг ч бас тийм байгаасай хэмээн уриалдаг хүн юм.

Христитгэлт хүн бол Есүс Христийг дагагч эсвэл дагалдагч юм. Тиймээс Христ итгэлт дагалдагчийн хувьд хамгийн чухал нь:

- Есүстэй харилцах байдлаа сайжруулах мөн Түүний заасан зүйлийг ойлгож, суралцах
- Түүний сургаалуудад дуулгавартай байснаар Есүсийг дээдэлдэг амьдралтай байх
- Мөн бусдад Есүсийг таниулж, Түүнийг дагахыг уриалдаг байх, ингэхийн тулд Түүний сургаснаар амьдрах

Есүсийн дагалдагчийн хувьд Түүний сургаалыг мэдэж, хэрэгжүүлэх шаардлагатай нь тун тодорхой билээ. СУУРЬ ҮНДЭСийн 1 ботид өгүүлэгдсэнээр Есүсийг дагагчдын хувьд үндсэн дөрвөн гол тушаал байдаг:

- Бурханыг хайрла.
- Хөршөө хайрла.
- Бусад дагалдагчдаа хайрла.
- Дагалдагч бэлтгэ.

СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийн онцгой чанар

Хэдэн жилийн өмнө Сайн мэдээний дагуух дагалдагч бэлтгэлийн хөтөлбөрүүд нь итгэгч хүний Христтэй харилцах хувийн харилцааг маш чухал болохыг олж тогтоожээ. Аврал, баталгаа, нүглийн училлал, залбирал, Библии уншилт, магтаал хүндэтгэл, сайн мэдээ түгээлт зэрэг сэдвүүд хичээлд багтсан байгаа. (Эдгээр сэдвүүд нь Бурханыг хайрлаж, таньж мэдэн, Түүнд үйлчлэх

дагалдагчийн босоо хэмжээсийн талаар ч өгүүлсэн байгаа.) Сайн мэдээний дагуух дагалдагч бэлтгэлийн тэрхүү хөтөлбөрүүдийн хувьд итгэгчид Бурханы хайрын “хэрэгжилтийг” хөршүүдээ болон итгэгч нөхдөдөө “хүргэх” тал дээр учир дутагдалтай байсан хэмээн тэмдэглэгджээ. (Энэ нь дагалдагч бэлтгэлийн хэвтээ талыг агуулж байгаа юм.)

Олон улс үндэстэнд буй Сайн мэдээний Кристик болон Пентекост чуулгануудтай ажилладаг Харвествынхан бидний ажигласнаар, энэхүү тэнцвэргүй байдал нь шинэ итгэгчдэд халдвялахдаа дагалдагчийн босоо тал бүх христитгэлт хүнд хамаатай, харин хэвтээ тал нь өөрсдийн сонголтын хэрэг юм байна гэж үзэх хандлагыг бий болгодог байна. Үр дагаварт нь Библийг ойлгож, хэрэгжүүлэхдээ тэнцвэр алдагдуулдаг Есүсийн дагалдагчид бий болж байна. Хэрэв тэд бусдад сайн мэдээ түгээвэл бас л өөрсөдтэйгөө адил тэнцвэр алдагдуулдаг хүмүүсийг бий болгоно.

Теологийн хувьд чөлөөт үзэлтэй христитгэлт Чуулганууд нь ихэнхдээ дээр дурдсан байдлын яг эсрэгээр тэнцвэрийг алдагдуулсан байдаг. Тэдний дагалдагч бэлтгэлийн хөтөлбөрт Сайн мэдээ нийгэмд хэрхэн нөлөөлж буй (дагалдагч бэлтгэлийн хөндлөн хэмжээс) талаар илүү онцолсон байдаг хэрнээ харин Сүнсээр дахин төрж, өсөхөөр Бурхантай эвлэрч буй хувь хүний (Түүнтэй харилцах босоо хэмжээс) тухайд арай сулхан илэрхийлсэн байдаг.

Библийг тэнцвэртэй ойлгоход болон жинхэнэ дагалдагч бэлтгэхэд босоо ба хөндлөн хэмжээс аль аль нь хэрэгтэй. Дагалдагч бэлтгэх материал бүрдэхэд “бүтэн” дагалдагчид Библийг босоо ба хөндлөн хэмжээсээр нь тэнцвэржүүлэх болно. Энэхүү тэнцвэржилтийг л бид “цогц “ гэж хэлээд байгаа юм.

Христ итгэлийг хүлээн авахуйц бөгөөд сонирхол татахуйц болгохын тулд дагалдагч бэлтгэлийн олон хөтөлбөрт үүний үнэ цэнг бас л бүдэг тусгасан байдаг бол харин Өөрийг нь дагах хүмүүсийн хувьд энэ нь тэдний нэн тэргүүний зүйл байх учиртайг Есүс тодорхой болгосон.

СУУРЬ ҮНДЭС хөтөлбөр нь христитгэлийн амьдрал дахь босоо ба хөндлөн хэмжээсийн тухай болон дагалдагч байхын үнэ цэнгийн талаар дурдсан хэрэгцээт материал нь байхаар бичигдсэн. Энэхүү хөтөлбөр нь христитгэлт дагалдагчдыг хөгжүүлэх, ингэхдээ Библийг зөвхөн оюун ухааны хувьд ойлгодог байх төдийгүй мөн өөрсдийг нь суурьшуулсан ертөнцийн төлөөх Бурханы босоо ба хөндлөн хэмжээст хайрыг амьдралаараа хүндэлдэг хүмүүс байлгах зорилготой.

СУУРЬ ҮНДЭСийн уялдаа холбоо

- Дагалдагч бэлтгэлийн зорилго нь Христийн Эзэн хэмээх эрх мэдлийг нь амьдралынхаа бүхий л талбарт хүндэтгэдэг хүмүүсийг хөгжүүлэх явдал юм.

- Сайн мэдээ бол төгсгөл биш бөгөөд харин дагалдагч болж бэлтгэгдэх үйл явцын зөвхөн эхэн үе нь юм. Дагалдагч бэлтгэлгүй Сайн мэдээ нь библийн дагуу биш юм.
- Дагалдагч бэлтгэл нь Библийн утга агуулгыг зааж сургах болон үүний хэрэгжилтэд туслан халамжлахын аль али� дээр тулгуурладаг юм.
- Дагалдагч байхын үнэ цэн тодорхой мэдэгдэж, зөвшөөрөгдсөн байх учиртай.
- Дагалдагч бэлтгэлийн үйл явц нь төлөвшсөн христитгэлт хүнээр (“дагалдуулагчаар”) халамжуулдаг суралцаагчдын (“дагалдагч”) жижиг бүлгийн хүрээнд хамгийн сайн явагддаг).
- Хувьчилсан халамж нь дагалдагч бэлтгэлтэй холбоотой гэрийн сургалт, зайны сургалт гэх мэтийн хувийн бус шинжтэй аргуудыг бодвол удаан хугацааны, үр дүнтэй стратеги юм. Энэ нь мөн “анги танхим” аар зогсохгүй, амьдралын бодит нөхцөлд ч цаг гаргахыг шаарддаг.
- Дагалдагч бэлтгэх үйл ажил нь “зааж сургах”аас илүүгээр “тулж ажиллах” явдал юм. Дагалдуулагч нь хүссэн, хүсээгүй өөрийгөө хувилж байдаг. Ярьж хэлсэн бүхнийхээ дагуу байдаг дагалдуулагч л заалгасан зүйлээ ойлгож, хэрэгжүүлдэг дагалдагчийг хувилан гаргаж чадна.
- Дагалдагч бэлтгэлийн агуулга амьдрал өөрчлөх чадалтай Библи дээр суурилсан байх учиртай. (СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийн 1-р боть нь Есүсийн сургаал дээр тулгуурласан. СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийн 2-р боть нь Эхлэл номоос эхлэн Шинэ Гэрээг дуустал үргэлжилдэг сэдэв дээр тулгуурласан.)
- Христитгэлт дагалдагч бэлтгэл нь Библийг муйхраар хэрэгжүүлдэг байдлаас хавьгүй илүү. Бурхан итгэгчдийг хайр ба Ариун Сүнсээрээ дүүргэдэг бөгөөд Өөрийг нь дагах хүсэл эрмэлзэл, хүч чадлыг ийнхүү өгдөг.
- СУУРЬ ҮНДЭС хөтөлбөр нь дагалдагч бэлтгэлийн танилцуулга болох учиртай. Ямар ч юмны эхлэл бүрэн төгс байдаггүй шиг, энэхүү хөтөлбөр ч мөн тийм юм. Энэ нь халамжлагчийн цаашдын болон илүү дотносих харилцаанд тус дэм болох зорилготой.
- Чуулганыхаа гишүүдийг “бүтэн” гэрчлэгч байлгах хамгийн сайн арга нь тэднийг Христэд итгээд удаагүй байхаас нь эхлэн (босоо ба хөндлөн хэмжээст) бүрэн гүйцэд сургах явдал юм.
- Чуулгануудын хувьд гадагшаа хүрч ажиллахдаа тэнцвэртэй байхын тулд гишүүд нь өөрсдийнхөө амьдралд мөн ижил тэнцвэржилтийг тусган харуулах ёстой.

СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийг ашиглахтай холбоотой хам сэдэв

- СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийн 1-р боть нь анхандаа гадны буюу гуравдагч орнуудын том хотуудад буй Чуулган дахь шинэ итгэгчдийг дагалдуулах ахлагч, пасторуудад гарын авлага болох зориулалттай байв. СУУРЬ ҮНДЭС хөтөлбөр нь дэлхийн олон улс оронд орчуулагдан ашиглагдсанаар удалгүй анхны хараа зорилго маань улам өргөжин тэлсэн.
- Энэ нь зөвхөн шинэ итгэгчдэд ашиг тусаа өгөөд зогсохгүй, итгэлийнхээ хэрэгжилтийг цоо шинээр эхлэхийг хүсэж буй төлөвшсөн христитгэлт хүнд ч бас ашиглагдаж болох юм байна гэдэг нь тодорхой болсон.
- СУУРЬ ҮНДЭС хөтөлбөр нь таваас арван хүнтэй жижиг бүлэгт зориулагдсан хэдий ч, үүнээс бага эсвэл их бүлэгт ч ашиглаж болно. Ер нь бол таваас арван бэлэн хүн байхад л дагалдагч бэлтгэлийн үйл явц эхэлж болно. Дахиад таваас арван хүн нэмэгдвэл, тусад нь дагалдагч бэлтгэлийн шинэ бүлэг бий болгож болно.
- Бүлгийн уулзалтууд нь тухайн хичээлийнхээ хэрэгжилт болон агуулгын талаар чөлөөтэй харилцан ярилцахад тохирсон тав тухтай, дангаараа байж болохуйц газар явагдана. Чуулганы байр, гэр орон эсвэл цэцэрлэгт хүрээлэн гэх мэт газруудад байж болно.
- Дагалдагч бэлтгэлийн бүлгийн уулзалт ямар давтамжтай байх нь тухайн хүмүүсийн амьдралд шууд тохирохуйц байдаар шийдэгдэх ёстой. Цугларалт хоорондын зайд нь тухайн дагалдуулагч дараагийн хичээллээс өмнө дагалдагч бүртэйгээ дор хаяж нэг удаа хувьчлан уулзахад хангалттай хугацааг олгох учиртай. Ихэнх тохиолдолд долоо хоногт нэг удаа байхаар таардаг.
- СУУРЬ ҮНДЭС хөтөлбөр нь боловсрол, нийгмийн байдлаараа харилцан адилгүй олон хүнд ашиглагдаж хэрэглэгддэг. Хэдийгээр дагалдагч бэлтгэлд боловсрол зайлшгүй чухал биш ч дагалдагчийн хувьд наад захын уншиж ойлгох чадвар байвал илүү дээр. (Гэхдээ дагалдуулагчийн хувьд хэл бичгийн талаасаа найм эсвэл үүнээс дээш ангийн боловсролтой байх хэрэгтэй.)

Дагалдагч бэлтгэл ба судалгааны аргачлал

СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийн хичээлүүд нь насанд хүрэгчдэд зориулагдсан. Дагалдуулагчид нь уламжлалт, анги танхимын багш нар биш. Хэрэв лекцийн аргыг ашиглахаар байвал, маш бага байна гэсэн үг. Харин тухайн бүлгийг Бичээсийн талаарх хэлэлцүүлгээс дүгнэлт хийхэд нь тусалж, гол санааг нь дэмжиж өгөх жишээ дүрслэл, жүжигчилсэн тоглолт, дуу хөгжим зэрэг бусад туршлагаар нээлт хийх үйл явцад нь удирдан чиглүүлнэ гэсэн үг.

Библийг уншиж, (эсвэл сонсож) шинийг нээж олохоор асуултуудыг хэлэлцэх нь аливаа бүлэгт тохирсон гол суралцах арга юм. Асуултууд нь дагалдагчдыг Бичээсийн агуулга, санаа, хэрэгжилтийг амьдралдаа тусган авахаар дүгнэлт хийхэд нь түлхэц болох зорилготой. Хэдийгээр Библийн хэсэг тус бүрт

зориулсан тодорхой асуулт хариулт байгаа ч дагалдуулагчид хичээлээр заагдсан зарчмуудыг ойлгож хэрэгжүүлэхэд нь дагалдагчдадаа туслахаар ямар ч асуултыг тавьж болно.

Бүлгийн хичээл хоорондын суралцах гол хэв маяг нь хичээлээс сурсан хэрэгжүүлэлтийг гүйцэтгэхэд нь туслан халамжлах, мөн өгүүлэгдсэн санааг эргэцүүлэн бodoх цаг байна.

Дахин хэлэхэд, СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийн бүлгийг удирдах дагалдуулагчид лекц унших эсвэл түлхүү ярихаас аль болох зайлсхийх ёстай. Дагалдуулагчид нь эдгээрийг бусад газар үйлчлэлдээ өргөн ашигладаг байж болох ч, иймэржүү маягийн суралцах хэлбэрт эдгээр нь үр дүнтэй арга биш.

СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийн хичээл тус бүр дагалдагчдад дараагийн хичээлээс өмнө сурсан зүйлээ өөрийнхөөрөө хэрэгжүүлэх боломжийг өгч байх болно.

Хэрэв дагалдагчид нь тохиромжтой хэрэгжилтийг олоход хэцүү байвал дагалдуулагчид өөрсдөө тэдэнд санаа өгч болох, эсвэл тухайн хичээлд өгөгдсөн хэрэгжилтийг сануулж болох юм.

Нэмэлт хичээл нь энэ хөтөлбөрийн чухал хэсэг юм. Нэмэлт хичээл нь хоёр талтай:

- Холбогдох: Дагалдуулагч нь дагалдагч бүртэйгээ хичээл тус бүрийн хооронд адаглаад нэг удаа хувьчлан уулзаж, (1) өмнөх хичээлийн талаар, мөн бодсон зүйлийнх нь тухай дүгнэн ярилцах; (2) хэрэгжүүлэлтийнх нь тал дээр уриалж, санаа өгөх; (3) хэрэв шаардлагатай бол тухайн хэрэгжүүлэлтийг хэрхэн хийж болохыг хамтарч гүйцэтгэнээр харуулах. (Биечлэн уулзах нь хамгийн сайн. Ийм боломжгүй бол утсаар ярих, захиа илгээх эсвэл и-мэйл явуулах байдлаар санаа тавьж байгаагаа харуул.)
- Мэдэгдэх: Дагалдуулагчид бүлгийн дараагийн уулзалтын үеэр дагалдагчдаасаа өмнөх хичээлийн талаарх бодол, хувьдаа хэрхэн хэрэгжүүлсэн туршлагаа ярихад нь уриал. Дагалдуулагчийн дахин бататгах, чиглүүлэлт өгөх үе нь энэ юм. (Энэхүү цаг нь бас дагалдуулагч танд хичээлийн агуулга хэр зэрэг ойлгогдож, хэрэгжиж байгааг анзаарч ажиглан, үнэлж дүгнэх боломж олгоно.)

Дагалдуулагчид

Дагалдуулагчдын залбирч гуйх, өөрсдийнхөө амьдралд хэрэгжүүлэх ажил нь тухайн хичээлийг бэлдэж заахтай тэнцэх хэмжээний ач холбогдолтой.

- Зааж буй зүйлээ өөрсдөө хэрэгжүүлдэг байх нь дагалдуулагчдын хувьд хамгийн чухал нь. Мөн энэ нь хүчтэй нөлөө үзүүлнэ.
- Дагуулж буй хүмүүсийнхээ төлөө тууштай залбиран гуйх, Ариун Сүнсний хүчээр дагалдагч бэлтгэлийн үр жимс гарна гэдэгт найдвараа тавих нь дагалдуулагч хүний хувьд зайлшгүй шаардлагатай зүйл билээ.

Сайн дагалдагч бэлтгэлд халамжлах явдал тун чухал. Дагалдагчдынхаа амьдралд холбогдох оролцоход бэлэн дагалдуулагчид зөвхөн хичээлийн агуулга ба хэрэгжилтийн талаар хэлэлцэхээр уулздаг дагалдуулагчдаас хавьгүй илүү үр дүнд хүрнэ. Бүлгийн ердийн нэг хичээлийн цаана хоёроос доошгүй түвшин байдаг. Есүс дагалдагчдаа халамжлахдаа энэ хоёрын аль алийт нь ашиглаж байсан.

- Эхнийх нь үлгэрлэн үзүүлэх. Дагалдуулагчийн үлгэр жишээ дор хаяж хоёр замаар харагдана: (1) Дагалдуулагч хүн заадаг зүйлстэйгээ тохирсон амьдралын хэв маягтай байх (2) Хичээлээс сурсан зарчмуудаа амьдралд хэрэгжүүлж байгаагаа бусдад харуулж, тэднийг ч бас уриалдаг байх.
- Хоёрдугаар түвшин нь дагалдагчийн амьдралд анд нөхөр, урамшуулан дэмжигч байдлаар холбогдон оролцох. Анд нөхөд болохынхоо хувьд дагалдуулагчид дагалдагчидтайгаа хамт цаг өнгөрүүлж, тэдний гэр бүл, ажил төрөл, баяр баясгаланг илүү сайн мэддэг болох хэрэгтэй. Урамшуулан дэмжигч болохынхоо хувьд хичээл тус бүрийн хэрэгжилтүүдийг анзаарч ажиглах нь юм. Хэрэг болсон тохиолдолд тэд урам зориг, санал онол, тус дэм, заавар чиглүүлэлтийг өгөх учиртай.

Энэ бүхэнд цаг хугацаа шаардлагатай. Ням гарагийн сургалтын ангид эсвэл Библи судлалын бүлэгт хичээл заадаг хэв маягт хувьчилсан харилцаа байдаггүй бөгөөд энэ нь оюутан сурагчийг л бий болгохоос дагалдагч бэлтгэхгүй.

Дагалдагчид

СУУРЬ ҮНДЭС хөтөлбөр нь тухайн дагалдагчдыг Христийг дагахаар нэгэнт шийдчихсэн, Сайн мэдээний талаар үндсэн ойлголттой хэмээн тооцсон байгаа. Гэхдээ шаардлагатай тохиолдолд, СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийн эхний гурван хичээл нь Христ доторх шинэ амьдралын тухай ойлголтыг өгдөг.

Есүсийн дагалдагч байх гэдэг нь ямар утгатай болохыг нухацтай сонирхож буй ч, дагах шийдвэрээ хараахан гаргачаагүй байгаа хүмүүст дагалдагч бэлтгэлийн бүлгийн гишүүн болж болно гэдгийг хөтөлбөрийг бичигч нь уриалж байна. Тэдний энэхүү эрэлхийлэлд талархаж буйгаа мэдэгдэх нь дагалдуулагчдын хувьд чухал. Тэдэнд асуух боломж олго; тэдэнтэй хамт цаг өнгөрөө; Ариун Сүнс тэднийг тан руу хандуулна гэдэгт найд; тэднийг бүлгийнхээ өмнө ичгүүрт оруулж болохгүй.

Шинэ дагалдуулагчийг халамжлах нь

Дагалдагчдаа СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрөөс суралцаж, хэрэгжүүлж байх явцад нь тэднээс дагалдуулагч болж болох хүмүүсийг анзаарч хар. Тэдгээр дагалдагч нь сайн суралцагч, чадварлаг харилцагч гэдгээс хавьгүй илүү байх бөгөөд дагалдуулагчийн бүх шинж чанарыг сонгогдох гэж буй дагалдагч харуулах ёстой.

Үлгэрлэн үзүүлэх, туслан халамжлах болон нэмэлт хичээл нь шинэ дагалдуулагчдыг сурган бэлтгэхэд бас ашиглагдана:

- Дагалдуулагч нь эхлээд СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийг сурч хэрэгжүүлсэн хүнийг сонгох ёстой. Сурч буй дагалдуулагч нь өөрийн гэсэн СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийн хувьтай болж, тэмдгэлгээ хийж авна.
- Тэд хамтдаа Гол хичээл, Дагалдуулагчийн зааврыг үзэх бөгөөд дараагийн хичээлийг халамжлагч нь удирдан явуулна.
- Сурч буй дагалдуулагч нь сургагч дагалдуулагчаа нилээд хэдэн хичээлийг удирдан хөтөлж байх явцад нь ажиглана.
- Сурч буй дагалдуулагч дараагийн нэлээд хэдэн үндсэн болон нэмэлт хичээлийг удирдан хөтөлж байх явцад нь дагалдуулагч үүнийг ажиглан, дүгнэлт хийж, хэрэв шаардлагатай бол тусална. Өөр нэг бүлэг үүстэл тэд хамтарч ажиллана.
- Шинэ дагалдуулагч бүлгээ эхэлнэ. Харин халамжлан дагалдуулагч нь зөвлөгөө өгөх үүрэгтэй хэвээр үлдэнэ.
- Шинэ дагалдуулагч нь өөр нэг дагалдуулагчийг бэлдэж халамжлахаар энэ загвараар давтан үйлдэнэ.

Агуулга болон загварын талаарх төгсгөлийн тэмдэглэл

Өмнө дурдсанчлан СУУРЬ ҮНДЭС хөтөлбөр нь олон талаараа онцгой. Жишээ нь, хичээл бүрд дагалдагч бэлтгэлийн босоо ба хөндлөн аль аль талыг нь гаргаж ирэхээр зорьсноос гадна хичээлүүдийн хэв загвар нь насанд хүрсэн суралцагчдын зарчмууд дээр тулгуурласан болно. Жишээ нь, хамгийн эхний авралын талаарх хичээл дээр итгэгч хүн Бурхан хоёрын хоорондох босоо харилцааг онцлон дурдсан байгаа. Бас л өмнө хэлсэнчлэн энэ нь дагалдагчдыг бэлтгэх зорилготой.

- Тэд бэлдэж, заахын тулд дагалдуулагч нь хичээлийн иж бүрдлийг ашиглана.
- Бүлгийн уулзалтын үеэрх суралцах үйл явцыг сайжруулахын тулд дагалдуулагч нь СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийн арын хуудсанд буй Судалгааны зааврыг л ашиглах учиртай.
- Хэрэв дагалдагчдад уг номууд байхгүй бол дагалдуулагч нь Судалгааны заавар болон гол ишлэлийн картыг хувилж өгөх хэрэгтэй.

СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийг агуулга ба загварын хувьд онцгой болгодог бусад зүйлүүд:

- СУУРЬ ҮНДЭС хөтөлбөр нь аль нэг чуулганы теологийн эсвэл урсгал чиглэлийн ялгаатай байдалтай үүнийг холбох гээгүй болно. Дагалдуулагчид өөрсдөө хүсэх юм бол тэдгээр ялгаа заагийг нөхөж болно. Тэд бас чуулганыхаа теологийн ялгаа заагийг СУУРЬ ҮНДЭСийн дараагийн шатны хичээлээр эсвэл тухайн урсгал чиглэлийн гаргасан материал ашиглан илүү гүнзгий авч үзэж болно.
- СУУРЬ ҮНДЭС хөтөлбөр нь Библийг цаашид сурч, хэрэгжүүлэхэд нь

тус болох хэрэгсэл юм. Хичээлийн загварыг ашиглан нэмэлт сэдвүүдээр сургалт хийж болно хэмээн дагалдуулагчдад уриалсан байгаа.

- Хичээлийн сэдвийг өргөж өгөх эсвэл дүгнэн ярилцахад өдөөлт болохоор ашиглагдах зурагт хэв маяг юм. Хүсвэл дагалдуулагчид тэдгээр зургийг ашиглаж болно. Тэд тохирсон нэхцэл байдалдаа тааруулах үүднээс үг хэллэг, эд зүйл, хүмүүсийг нь өөрчилж болох ба ахуй соёлтой нь шууд холбогдох зургуудыг зурж өгөх орон нутгийн уран бүтээлчээр туслуулж болно.
- Энэ сургалт хөтөлбөрийг орчуулах, өөрийн болгох, ахуй соёлдоо тааруулан өөрчлөх, эсвэл бусад материалыг авахыг хүсвэл СУУРЬ ҮНДЭС хөтөлбөрийн 2-р ботийн өхний нүүрэнд буй Харвестийн хаягийг ашиглан бидэн хандана уу.

Харин бид бүгд бүтээлээгүй нүүрээр Эзэний алдрыг тусган харуулдаг. Сүнс болох Эзэн биднийг алдраас алдарт Өөртэйгөө ижил дүрээр өөрчилдөг билээ.

- Эли Паул

Сурал бичил



Дагалдагчидаг зориулав

- Сүрлал, хэрэгжүүлэвлэл, жиншил, эмчилэвэл
-

Судлал**Түлхүүр ишилэл**

Тэзээг Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр
хүнийг бүтээж, Бурханыа дүр төрхөөр эрэгтэй
эмэгтэй хүнийг бүтээв.

Эхлэл 1:27

Судлах асуултууд

- Бурхан хүнийг бүтээхдээ хэнийг загвар болгож ашиглав?
- Энэ нь хүн төрөлхтөнг чухал болгох уу? Яагаад?
- Эрэгтэй эмэгтэй хүн хоёул Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн үү?
- Эрэгтэй эмэгтэй хүний аль нь илүү үнэ цэнтэй вэ?

Христийн үйлчлэлд амьдралаа зориулж яваа ахан дүүст зориулсан дагалдагч бэлтгэх цогц сургалт**Бурханы дүр төрх болох Есүс**

- Колоссай 1:15 • Еерей 1:3

- Бурхан Эцэг хүн шиг үзэгдэх биетэй юу? Хүмүүс Бурханыг харах боломжтой юу, аль эсвэл Тэр сүнс үү?
- Есүс Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн үү, эсвэл Тэр Өөрөө Бурханы дүр төрх үү? Энэ хоёр нь ямар ялгаатай вэ?
- Еврей 1-р бүлгийн дагуу Есүс гэж хэн болох, Түүний юу хийдгийг тодорхойл.
- Эдгээр ишлэлүүд нь Есүсийг Бурханы дүр төрх мөн гэдгийг хэрхэн илэрхийлж байна?

Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн хүн төрөлхтөн

- Эхлэл 5:1-2 • Эхлэл 9:6

- Бурханы дүр төрхийн дагуу хэн бүтээгдсэн бэ?
- Бурхантай адил бүтээгдэнэ гэдэг нь юу гэсэн үг вэ? Хүн Бурхантай юугаараа адил вэ? Бид Бурханаас юугаараа ялгаатай вэ?
- Бидний амь амьдрал яагаад онцгой үнэ цэнтэй вэ? Бид бусад бүтээлээс юугаараа ялгаатай вэ? Хүн алсны хариуд яагаад хатуу шийтгэл оноодог вэ?

Хүн төрөлхтөн – Нүглээс болж гэмтсэн

• Эхлэл 3:1-6, 22-23 • Ром 1:28-31

- Бурханы эсрэг хүн төрөлхтний тэрслэл нь Эхлэл 3-р бүлэгт гардаг.
Үүний дараа хүний доторх Бурханы дүр төрх яасан бэ?
- Бурханы дүр төрхийн талаар мэдэх зүйлээ Ром номноос уншсан хэсэгтэйгээ харьцуулж үзээрэй. Бидний доторх Бурханы дүр төрхийг гэм нүгэл яадаг вэ?
- Хүмүүсийг бие биенээс нь юу салгадаг вэ?
- Бүх л нийгэм хүний амийг ямар нэгэн замаар үнэ цэнгүй болгодог.
Бидний амьдарч буй нийгэмд үүний ямар жишээ байна?
- Энэ нь чуулган дотор мөн болдог уу? Өөрийнхөө хариултыг тайлбарлаарай.

Хүн төрөлхтөн – Бурханы дүр төрхөөр сэргээгдсэн нь

• Ефес 1:22-21 • Колоссай 3:9-10
• 2 Коринт 3:18

- Бидний шинэ хүн нь Бурханы дүр төрхөөр хэрхэн бүтээгдсэн бэ?
- Үүнийг хийх ямар практик арга замууд байна?
- Бид хэрхэн өөрчлөгдсөн бэ? Бид хүний хичээл зүтгэлээр өөрсдийгөө Бурханы дүр төрхтэй нийцүүлэх боломжтой юу?

Хуурамч дүрсүүд*

• Ром 1:22-23 • Дуулал 135:15-18

- Хүмүүс ямар нэгэн дүрсэд мөргөхдөө өөрсдийгөө ухаантай гэж бодож болох юм. Харин Бурхан тэднийг юу гэж боддог бол?
- Дүрсэд мөргөх нь ялагаад муунхаг явдал гэж?
- Хэрэв бид хуурамч дүрсэд мөргөвөл бидэнд юу тохиолдох вэ?

Хуурамч дүрсэд мөргөдөг нийгэмд юу тохиолдох вэ?

*Нэмэлт: Танай нийгэмд хуурамч шүтээн том байр суурь эзэлдэг бол энэ хэсгийг сайтар судал.

- Бид жинхэнэ Бурханд мөргөхөд юу болдог вэ? Энэ нь бидний нийгмийг хэрхэн өөрчлөх боломжтой вэ?
- Бурханы дүр нь хүний бүтээсээ дүрүүдээс юугаараа өөр вэ?

Хэрэгжүүлэх төлөвлөгөө

“Би юу? Бурханы дүр төрхийн дагуу гэж үү?”



Зураг 1.1

СҮҮРЬ ҮНДЭС Үзүүл бүрэн Дагалдагч бэлтгэл: Бүрханы дүр төрх

Эхэнд Бурхан

Судлал

Түлхүүр ишлэл

Эхэнд Бурхан тэнзэр газриаг бүтээжээ.

Эхлэл 1:1

Судлах асуултууд

- Эхэнд гэсэн нь хэзээ вэ? Эхэнд хэн байв?
- Энэ цагаас өмнө өөр зүйл байсан уу? Юу бүтээгдсэн бэ?
- Хязгааргүй уудам огторгуйг Бурхан бүтээсэн гэж бодохоор ямар санагдаж байна? Энэ нь чиний хувьд юу гэсэн уг вэ?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

Бүтээгч

- *Исаиа 37:16*
- Бурхан хэр их юм бүтээсэн бэ?
- Бүтээгч Бурхан хэд байдаг вэ?

Бурхан алдартай

- *1 Коринт 8:5-6*
- *Колоссай 1:15-18*
- *Дуулал 101:30*
- 1 Коринт, Колоссай, Дуулал номуудад хэнийг Бүтээгч гэж хэлж байна вэ?
- Бурхан Эцэг, Есүс Христ, Ариун Сүнс гурвуулаа бүтээлийн ажилд оролцсон уу?

Хүн төрөлхтний үнэ цэнэ ба Бурханы хайр

- *Иеремиа 10:11-12*
- Бидний Бурхан бол жинхэнэ Бурхан гэдэгт бид хэрхэн бат итгэлтэй байх вэ?
- Бидний ахуй соёлд бүтээлийн талаарх өөр итгэл үнэмшил бий юу? Энэ бүхэн нь үнэн байж болох уу? Бусад “бурхад” тэгвэл яах болж байна вэ?
- *Илчилэлт 1:11*
- Зөвхөн Бурханд л бүх зүйл нь байх учиртай. Юу? Яагаад?
- *Дуулал 139:13-18*
- Энэ ишлэл нь бидэнд нэг амиийн үнэ цэнгийн талаар юу хэлж байна вэ?

СУУРЬ ҮНДЭС Цогц бүрэн Дагалдагч бэлтгэл: Бурханы дүр төрх


- ❑ Бурхан биднийг яах гэж бүтээсэн бэ? Та бид хоёрын талаар Тэр хэр зэрэг хувьчлан боддог вэ? Бурхан бидэнтэй ойр дотны харилцаатай байхыг хүсэж байгаа болов уу?

Хүн төрөлхтөн бол бүтээлч

- Египетээс гарсан нь 31:1-5
 - Египетээс гарсан нь 35:25-26
 - Энэ хоёр хэсэгт гарж буй хүмүүсийн онцгой чанарууд нь юу вэ?
 - Бид бүтээлч сэтгэлгээ, ур чадвар ба авьяасыг хаанаас авдаг вэ?
 - Бид бүтээлч сэтгэлгээгээ хэрхэн ашиглах ёстой вэ?



Бүтээл



Зураг 2.1



Зураг 2.2



Зураг 2.3



Зураг 2.4

Бурхан бүхнийг захирдаг

Судлал

Түлхүүр ишлэл

Есүс ойртон ирээд, тэдэнг “Тэнзэр газар дээрх бүх эрх мэдлийг Нагад өгсөн” зэж айлдасв.

Матай 28:18

Судлах асуултууд

- Есүсийн эрх мэдлийн хэмжээ нь хэр юм бэ?
- Хэн Есүст “тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг” өгсөн юм бэ?
- Есүс тэнгэрт хэний дээгүүр эрх мэдэлтэй вэ?
- Есүс газарт хэний дээгүүр эрх мэдэлтэй вэ?
- Иймэрхүү эрх мэдэлтэй хүнийг бид ямар хүн гэдэг вэ?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

Бурхан бол Хаан

- 1 Самуел 8:6-7

- Хүмүүс Самуелаас хаан шаардахаар очихдоо үнэндээ хэнийг эсэргүүцэж байсан бэ?
- Бурхан израильчууттай ямар харилцаатай байхыг хүсэж байсан бэ?
- Бурхан Өөрийнхөө хүмүүсийг хүчээр захирдаг уу?

Есүс бол Хаан

- Даниел 7:13-14

- Даниелын үзэгдэлд дурдагдсан “Эртний Нэгэн” нь хэн бэ?
- “Хүний Хүү шиг Нэгэн” гэсэн нь Есүс. Түүнд юу өгөгдсөн бэ? Хэн Түүнд мөргөв? Харж буй зүйлээ дүрсэл.

- Матай 19:28

- Есүс энд юуг дүрсэлсэн бэ? Сэнтий юуг төлөөлж байна вэ?

- Еврей 1:3,8

- 1 Самеулд бид Бурхан бол Хаан гэдгийг харсан. Даниел болон Матай номон дээр Есүс бол Хаан гэсэн. Энэ бүхнийг ойлгоход бидэнд Еврей ном хэрхэн тусалж байна?

- Еврей номын дагуу Есүс хэнтэй адил вэ? Тэр хаана сууж байна вэ? Бурхан Эцэг Есүсийг ямар нэрээр дуудаж байна вэ?


Бурханы мөн чанар

- *Иеремиа 23:21*
 - Энэ хэсгээс та нар юу харж байна? Бурханы мэдэхгүй нууц газар гэж бий юу? Яагаад үгүй гэж?
 - Бурхан тэнгэр газрыг хэрхэн “дүүргэн” оршдог вэ? Тэр нэг том хөлөө газарт, негеө том хөлөө тэнгэрт тавьдаг уу? Бид өөр гариг дээр очлоо гэхэд Бурхан тэнд ч бас байгаа юу?
 - Дэлхийн негеө талд залбирч буй хүний залбирлыг болон миний залбирлыг Бурхан зэрэг сонсож чадах уу?
- *Ром 1:20*
 - Бүтээлээс бид юуг харж чадах вэ? Хэн бүхнийг бүтээсэн бэ?
 - Дийлэнх нь манай наринаас ч том, тэр буман оддыг байршуулна гэдэг хэр зэрэг хүч шаардсан ажил бол?
 - Иймэрхүү хүч чадалтай нэгэнтэй та хэрхэн харилцах вэ?
- *Еерей 1:13*
 - Бурханы мэдлэгийн цар хүрээ ямар вэ? Тэр таны талаарх бүхнийг мэддэг үү? Бүх хүний талаар мэдэх үү?
 - Бурхан энэ бүхнийг яаж мэдээд байна вэ?
- Энэ хэсгээс бид Бурханы мөн чанарын талаар гурван зүйлийг олж мэднэ:
 - (1) Бурхан бүх газарт оршдог.
 - (2) Бурхан хэмжээлшгүй хүчтэй.
 - (3) Бурхан бүхнийг мэддэг.
 - Бурхан бүхнийг захирах чадалтай гэж та бодож байна уу?
 - Бүх газарт нэгэн зэрэг оршдог, хэмжээлшгүй хүч чадалтай, бүхнийг мэддэг Бурханд тайлagnана гэхээр танд ямар мэдрэмж төрж байна?
- Дээд эрх мэдэлт Бурханд хандах бидний хандлага
 - *Дуулал 139:1-10*
 - Бурханы талаарх энэ тодорхойлолтыг уншихад танд ямар сэтгэгдэл төрж байна? Бурханы талаарх таны бодолтой 6-р ишлэл хэр зэрэг тохирч байна?
 - Хэрэв та Бурхантай сэргөөцөлдсөн байгаад 7-р ишлэлийг уншвал ямар сэтгэгдэл төрөх байсан вэ? 10-р ишлэл бусад ишлэлүүдээ хэрхэн тэнцвэржүүлж байна вэ?
 - *Даниел 2:20-23*
 - Бурхан биднийг бүтээхдээ бүхнийг мэддэг, хэмжээлшгүй хүчтэй, хaa сайгүй оршигч болгон бүтээгдэгүй. Гэхдээ Бурхан үнэхээр их хэрэгцээтэй үед нь Даниелд мэргэн ухаан, хүч чадлыг өгсөн. Даниельны хариу үйлдлээс бид юу сурч болох вэ?
 - *Иаков 1:12*
 - Түүний дүр төрхийн дагуу бүтээгдсэн ч бидэнд дээд эрх мэдэл бий юу? Бид алдар магтаалыг авах зохистой юу? Бидэнд хэр хэмжээний эрх мэдэл байгаа вэ?

Хэрэгжүүлэх төлөвлөгөө

СҮҮРЬ ҮНДЭС Цогц бүрэн Дагалдагч бэлтгэл: Бурханы дүр төрх

Тэнгэр газар дээрх бүх эрх мэдэл
Матай 19:28 эсвэл Даниел 7:13-14-г дүрслэн зур.



Зураг 3.1

Судлал

Түлхүүр ишлэл

Дахин айдасыг хүргэх боомчлолын сүнсийг та нар
хүлээн аваагүй, харин үрчлэлийн Сүнсийг авсан билээ.

Түүгээр бид “Аав! Энэг минь!” гэж дуулдаг.

Биднийг Бурханы хүүхдүүг зэгэжийг Сүнс Өөрөө
бидний сүнсийг хамт гарчилдэг.

Ром 8:15,16

Судлах асуултууд

- ❑ Есүс болон дагалдагч нарынх нь ярьдаг байсан хэл бол Арамей хэл юм. Арамей хэлэн дээр Абба гэдэг үг нь “Эцэг” гэдэг үгийн хамгийн дотно хэлбэр юм. Эцэг гэдэг үгийг бид өөр ямар үгээр илэрхийлдэг вэ?
- ❑ Таны Эцэг бол Бурхан гээд төсөөл дөө. Энэ нь Түүнийг үзэх үзэлд тань хэрхэн нөлөөлж байна?
- ❑ Энэ ишлэл дээр хэлж буйгаар Сүнс бидэнд Эцэг уруу хандсан хүслийг өгдөг ба бид Түүнийг сэтгэлийнхээ угаас дууддаг гэж хэлж байна. Та ялангуяа Эцэг гэдэг талаас нь Түүнд хандаж байсан удаатай юу?
- ❑ Эцэг хүү хоёрын харилцаа дотно байхад юу юу шаардлагатай вэ? Хүүхдүүдээ Өөртэйгөө дотно харилцаатай байлгахын тулд Бурхан юу хийсэн бэ?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

Аавын хүүхдүүд

- 1 Иохан 3:1 • Ефес 1:1-5
- ❑ Хүүхдүүд эцгээсээ ямар эрх, завшааныг хүртдэг вэ? Бурхан бидэнд хайраа харуулахын тулд хийж чадах хамгийн агуу зүйл юу вэ?
- ❑ Аавтайгаа явж буй хүүхдүүдийг харахад танд юу ажиглагддаг вэ? Аав хүү хоёр адилхан харагддаг уу? Итгэгч биш хүмүүс биднийг хараад Бурханы талаар юу сурч болох вэ?
- ❑ Бурхан биднийг үрчлэн авахыг хэзээнээс төлөвлөж эхэлсэн бэ? Энэ нь танд юуг илэрхийлж байна? Энэ тухай бодоход таны сэтгэлд ямар байдлаар хүрч байна вэ? Шалтгаан нь юу вэ?

❑ Бурхан биднийг бүтээж, бидэнтэй харилцахыг хүссэн нь ямар зорилготой юм бол? Бурхан биднийг хайрынхаа улмаас үрчилж авахаар сонгосон гэдэг нь ямар учиртай юм болoo?

Эцэгийн халамж


- *Дэд хууль 1:31* • *Дуулал 68:5*
 - ❑ Израильчууд Мосгийн удирдлаган дор цөлд дөчин жилийг өнгрөөсөн. Дэд хууль номыг Мое бичсэн. Цөлд байхад нь Израильчуудыг халамжилж байсан Бурханы хайрыг Мое хэрхэн дүрслэсэн бэ?
 - ❑ Эцгээрээ халамжлуулж буй хүүхдийн сэтгэгдэлийг та яаж дүрслэх вэ? Бурхан биднийг хэрхэн “халамжилдаг” талаар таны бодол юу байна?
 - ❑ Дэлхий дээрх хамгийн эмзэг хүмүүс бол бэлэвсэн, эцэггүй, өнчин хүмүүс гэдгийг Дуулал номын 68-р бүлэг бидэнд сануулдаг. Бурхан Эцэг тэдэнд хэрхэн санаа тавьдаг бол?
 - ❑ Бид Бурханы өмнө чухалд тооцогдохын тулд алдартай, ухаантай эсвэл баян байх ёстой гэсэн санаа өмнөх ишлэлд харагдсан уу? Эндээс чи хувьдаа юу гэж дүгнэж байна?

Эцэгийн зүрх сэтгэлийг суулгах нь

- *Иаков 1:27*
 - ❑ Бурхан Эцэг маань бидэнд юу хий гэж хэлсэн бэ?
 - ❑ Бэлэвсэн, ганц бие эцэг, эхчүүд болон салсан хүмүүст ямар ямар асуудал тулгардаг вэ?
 - ❑ Итгэгч бид бүхэн бэлэвсэн эмэгтэйчүүд болон өнчин хүүхдүүдийг өмгөөлж, халамжилж, туслажын тулд хийж болох ямар ямар практик алхмууд байна?
- *Еерей 12:7-8*
 - ❑ Энэ ишлэл дээр хэлж буйгаар Эзэний сахилгажуулалт бидэнд сайн уу?
 - ❑ Бурхан яагаад биднийг сахилгажуулдаг юм бэ? Түүний зорилго нь юу вэ? Тэр яагаад зовлон зүдгүүрийг зөвшөөрнө вэ?
 - ❑ Хүмүүс Бурханы сахилгажуулалтад хандаж болох хандлагуудыг жагсаа. Бурханы бидэнд чиглэсэн зорилтыг гүйцэтгэхэд ямархуу хандлага шаардлагатай байна вэ?
 - ❑ Ихэнх хүүхэд аавыгаа хажуудаа байх үед давгүй сайн зантай байдаг уу? Бурхан үргэлж бидэнтэй хамт. Энэ нь бидний амьдралд ямар өөрчлөлтийг авчрах учиртай вэ?
 - ❑ Эцэг эхчүүд хүүхдүүдээ сахилгажуулах нь таны бодлоор зөв үү? Зүй зохистой сахилгажуулалт гэж юу вэ? Үүнийг хийх зөв хандлага нь юу вэ?

Хэрэгжүүлэх төлөвлөгөө

Бурханы хүүхдүүд



Зураг 4.1

Бурхан уучилдаг

Судлал

Түлхүүр ишлэл

Бурхан та нариаг Христ дотор үүчижсаны
ашиг бие биенээ үүчлан, нэг нэгнийгээ энэрэн
үяни зөөлөн сэмзэлээр ханг.

Ефрес 4:32

Судлах асуултууд

- Хэн эхэлж уучилсан бэ?
- Хэн бидний училалын загвар болсон бэ? Энэ нь бусдыг учлахад маань хэрхэн нөлөөлж байна?
- Биднийг училсан Христийн училалыг илэрхийлж болох ямар ямар үргүүд байгаа вэ?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

Бурхан уучилдаг

- *Мика 7:18-19*
- *1 Иохан 1:9*
- Бурхан Эцэг юуг чөлөөтэйгөөр хийдэг вэ? Тэр юунд баярладаг вэ?
- Дараахыг сонсоод чамд юу бодогдож байна: “бидний гэмийг хөл доор гишгэчнэ”, мөн “тэдний бүх нүглийг далайн гүн уруу хаяна”!
- Бид нүглээ улайвал Бурхан училна гэдгийг хэрхэн баттай мэдэх вэ?

Есүс училалыг үзүүлсэн

- *Лук 5:17-25*
- Энэ түүхэн дээр гарч буй өрчүүд Есүсээр найзыгаа эдгээлгэх ямар агуу зүйл хийсэн бэ?
- Нөхдийнх нь итгэлийг хараад Есүс саа өвчтэй хүнд эхлээд юу гэж хэлсэн бэ? Тэр хүний найзууд юу гэж бодож байсан бол?
- Есүс яагаад түүнийг эдгээхээсээ өмнө училсан бэ? Энэ нь хүмүүст Өөрийнх нь эрх мэдлийн талаар юут ойлгуулсан бэ?
- *Лук 23:34*
- Өөрийг нь ташуурдаж, зодож, өргөст титэм зүүлгэж, доромжилж, загалмайг нь үүрүүлж, загалмайд цовдолсон Ромын цэргүүдийг Есүс загалмай дээрээс хараад ямар хариу үйлдэл үзүүлсэн бэ?


- Ихэнх хүн яах байсан бол?
- Уйлс 7:59-60
 - Стефан ингэж хариулахыг хаанаас сурсан юм бол?
 - Стефан үүнийг өөрийнхөө хүчээр хийж чадах байсан гэж чи бодож байна уу?
 - Энэ жишээнээс бид юу сурч болох вэ?

Есүстэй адил уучлах

- Матай 18:21-22 • Матай 6:11-15
 - Бидний эсрэг нүгэл үйлдсэн хүнийг бид уучлахдаа хэр вэ? Тэдгээрийг бид тоолох ёстой юу?
 - Бидний хувьд гол төлөв ямар хамаа хүрээний хүмүүсийг уучлах шаардлага их гардаг вэ?
 - Уучлахгүй бол юу болдог вэ? Уучлах үгүй нь тухайн тохиолдлоос шалтгаалах уу?
- Ефес 4:29-32
 - 31-р ишлэл дээр дурдагдсан сөрөг чанаруудаас болж ямар ямар хамаа харилцаанд саад учирдаг вэ? Эдгээр нь ягаад Ариун Сүнсийг гомдоодог вэ?
 - Бидний түлхүүр ишлэл болох 32-р ишлэл дээр Паул үүнээс гарах замыг бичсэн. Бурхан биднийг Христ дотор ямар замаар уучилсан бэ? Тэгвэл бид бие биенээ хэрхэн уучлах ёстой вэ?
 - Уучлалгүй харилцаа яадаг вэ? Уучилдаггүй хүмүүст юу тохиолддог вэ?

**Хэрэгжүүлэх
төлөвлөгөө**

Уучлалың давтамж



Зураг 5.1

Судлал**Түлхүүр ишилэл**

Эзэн үдааширалыг тооцдог зарим хүмүүсийн бодлог шиг Өөрийнхөө амлалтад хойрго биши.
Харин и Тэр хэнийг и мөхүүлэхийг хүсэлзүй,
бүгдийг зэмшилд ирээсэй хэмээн хүсэн
та нарт тэвиээртэй ханддаз.

2 Петр 3:9

Судлах асуултууд

- ❑ Эзэний тэвчээр нь бидэнд ямар талаараа ашигтай вэ?
- ❑ Бурхан тэвчээр муутай байсан бол энэ ертөнц яах байсан бол?
- ❑ Петрийн сануулж буй амлалт гэсэн нь Есүсийн хоёр дахь ирэлт. Энэ ишлэлийн дагуу Есүс яагаад хараахан ирээгүй байна вэ?
- ❑ Есүсийн үхэл ба амилалтаас гучин жилийн дараа Петр тэрхүү захиагаа бичсэн. Хүмүүс Түүний хоёр дахь ирэлтийг хүлээж тэвчихгүй болж эхэлж байсан байна. Эзэний тэвчин хүлээдэгт та талархаж байна уу?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд**Бурхан тэвчээртэй**

- Ром 2:4 • 1 Тимот 1:16
- ❑ Ром 2:4 дээр Бурхан энэрэл, хүлээц, тэвчээрээр “баян” гэж хэлсэн. Энэ гурван чанар нь элбэг арвинаар зохицон хослохын учир юу вэ? Эдгээр нь биднийг гэмшилд уур хилэнгээс илүү хурдан хөтөлдөг юм болов уу? Тийм бол яагаад тэр вэ?
- ❑ Дамаск орох замдаа Христийг харахаасаа (Үйлс 9:1-20) өмнө Паул итгэгчдийг хяхан хавчиж байсныг санаарай. Паул яагаад мөнх амийг хүртэв? Энэ нь түүний нигүүлсэлийг ойлгох ойлголтод хэрхэн нөлөөлөв?

Бурханы дүр төрх ба тэвчээр

- Дуулал 37:7 • Сургаалт цгс 14:29
- ❑ Тэвчээр нь бидний доторх Бурханы дүр төрхийг хэрхэн тусган харуулдаг вэ?
- ❑ Зөвт бус хүмүүс амжилттай байгаад өөрсдөө амжилтгүй байх үед бид

ихэнхдээ хэрхэн ханддаг билээ?

Сургаалт үгс нь хүлээцтэй хүнийг түргэн зантай хүнтэй харьцуулдаг.

Хүлээцтэй хүнд юу байна вэ?

Хүнд нөхцөл байдалд түргэн зантай хүний гаргасан үйлдлүүд нь хожим ямар үр дагавар авчирдаг вэ? Хүлээцтэй хүний хандах үйлдлүүдийн хожмын үр дүн нь юу вэ?

Хэн нэгэн түргэн зан түргэн загнаасаас болон та гомдож байсан уу? Та хэн нэгнийг гомдоож байсан уу?

Хүн тэвчээргүй мөртлөө түргэн зангуй байж болох уу? Бид тэвчээргүй байдлаа өөр ямар ямар замаар харуулдаг вэ?

Өөрөө яг адил зүйлийг үйлчихээд бусдад тэвчээргүй хандах тохиолдол бидэнд байдаг уу? Яагаад ийм байна?

- Галат 6:9-10 • Ефес 4:1-3

Христэд итгэгчдийн үйл ажиллагагаа гал халуунаар эхэлсэн ч зогсох тохиолдол байдаг. Сайныг үйлдэхдээ хойрошихиос бид хэрхэн зайлсхийх вэ? Шууд үр дүн гарахгүй тохиолдолд бид заримдаа яадаг вэ?

Сүнсний нэгдмэл байдлыг хадгалахын тулд итгэгчдэд ямар ямар чанар хэрэгтэй вэ?

- Галат 5:22,25

Бид тэвчээр дотор хэрхэн өсдөг вэ? Өсөлтийн явцад бидний хийх зүйл болон Ариун Сүнсний хийх зүйл нь юу вэ?

Бататгах дасгал ажил

1-р хэсэг – Цэвэр ба цэвэр бус

Фарисайчуудад хандсан Есүсийн хариу: Марк 7:5-13

Дагалдагчдад хандсан Есүсийн хариу: Марк 7:14-19

2-р хэсэг – Дөрвөн мянган хүнийг хооллосон нь

Фарисайчуудад хандсан Есүсийн хариу: Марк 8:5-13

Дагалдагчдад хандсан Есүсийн хариу: Марк 8:14-21

Дараагийн хуудсан дээрх жижиг, том бүлэгт зориулсан асуултуудыг хараарай.

Жижиг бүлэгт зориулсан асуулт

Энэ хэсгийн хам сэдэв нь юу байв?

Есүс хэнд тэвчээртэй хандах шаардлага гарсан бэ?

Тэр юу хэлэв, юу хийв?

Бид Есүсээс юу сурал ёстой вэ?

Том бүлэгт зориулсан асуулт


Энэ дервөн жишээнээс та нар юуг ажиглав?

Хүмүүс буруу ойлголттой байх эсвэл санаатай эсэргүүцээд байхаар та нарт ямар санагддаг вэ?

Та нар Есүсээс юу сурав?

Хэрэгжүүлэх төлөвлөгөө

Бурхан үнэхээр тэвчээртэй юу?



Судлал**Түлхүүр ишлэл**

Харин та нартаг дууссан ариун Нэгэний адил оөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтуун.

Язгааг зэвэл “Би ариун үчраас та нар ариун байгтуун” зэж бинигдсэн юм.

1 Петр 1:15-16

Судлах асуултууд

- Бурхан биднийг ямар байлгахаар дуудсан бэ?
- Бурхан биднийг боломжгүй зүйлд дуудсан уу?
- Бид Бурхантай адил ариун байж чадах уу?
- Бид одоо байгаа байдалдаа сэтгэл ханах ёстай юу, эсвэл илүү ариун болохыг хүсэх ёстай юу?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд**Бурхан бол ариун**

- *Дуулал 89:7-8*
 - Энэ хэсгийг уншихад танд ямар мэдрэмж төрж байна вэ?
 - “Эмээдэс төрөм, сүрдэм агуу” Бурхан гэсэн нь ямар утгатай юм бол?
 - “Түмэн цэргийн Бурхан ЭЗЭН” гэдэг нэрийг сонсоход танд юу бодогдог вэ?
- *Исааи 5:16*
 - Бидний Эзэн хэрхэн өргөмжлөгдөх вэ?
 - Тэр ариун байдлаа хэрхэн харуулах вэ?
 - “Үнэн зөв” гэдэг угээр юуг илэрхийлж байна вэ?

Бурхан биднийг ариусгадаг

- *Филиппой 4:21-22*
 - Энэ захидал дээр итгэгч хүмүүсийг юу гэж нэрлэсэн бэ? Энэ нэр итгэгч хүн бүрд хамаатай юу эсвэл өндрөөр үнэлэгдсэн тодорхой бүлэг итгэгчдэд хамаатай юу? Энэ нь бидэнд юуг илэрхийлж байна вэ?
- *Колоссай 1:22-23*
 - Загалмай дээрх Христийн үхлээр дамжуулан Бурхан бидэнд ямар

онцгой зүйлийг хийж өгсөн бэ? Бурхан Эцэг биднийг яаж хардаг вэ?

- Христийн үхлээр гүйцэд илэрхийлэгдсэн Бурханы хайрын хариуд бид яах ёстой вэ?

- *Еврей 13:12*

- Бид хэрхэн ариусгагдсан бэ?

Ариун байдал доторх өсөлт

- *Ефес 1:4* • *Ефес 5:25-27*

- Бурхан ариун ард түмэнтэй байхыг хэзээнээс хүссэн бэ?
- Бурхан биднийг анхнаасаа төлөвлөгөөндөө оруулчихсан байсныг илэрхийл. Бид одоо тийм юм шиг харагдаж байна уу?
- Христ чуулганыг хэрхэн цэвэрлэдэг вэ? Үр дүн нь юу вэ?
- Ефес 5 дээр гарч буй “үг” нь юуг илэрхийлж байгаа вэ?
- Бурханы үгийг дагалгүйгээр дан ганц уншснаар бид ариусах боломжтой гэж та бодож байна уу?

Бурханы дүр төрх – Ариун байдал

- *Ром 12:1*

- Өөрсдийн биеэ амьд, ариун тахил болгон өргөнө гэсэн нь юу гэсэн үг вэ?
Бидний “өргөл” нь Бурханд таалагдахын тулд ямар байх ёстой вэ?
- Хэрэв бид ариун амьдралаар амьдрахгүй бол бидний өргөж буй магтаал, залбирал Бурханд таалагдах болов уу?

- *Ефес 5:3*


- Энэ ишлэлд Бурханы ариун хүмүүст зохимжгүй нүглүүдийг жагсаасан байгаа. “Садар самуун” гэдэг нь юу юуг хэлж байна вэ? “Аливаа бузар булаг, шунал” гэдэг нь юуг хэлж байна? Бурхан “багахан” нүглийг тооцдог болов уу?

- *2 Тимот 2:19-22*

- Бид “хүндэтгэлд зориулсан ариусгагдсан, Эзэндээ нийцсэн бөгөөд аливаа сайн үйлд бэлтгэгдсэн сав” байх ёстой гэж Паул бичсэн. Бид яаж ийм болох вэ? Та Эзэндээ нийцсэн, ариун багаж байхыг хүсэж байна уу?”
- “Ариун байдал” гэдгийг өөрийн үгээр тайлбарла. Ариун амьдралаар амьдарч байгаа эсэхээ яаж мэдэх вэ? Амьдралынхаа бүх талбарыг хэрхэн ариун байлгах вэ?

Хэрэгжүүлэх төлөвлөгөө

“Байсан, байгаа, хожим
ирэх төгс хүчтэй Эзэн Бурхан
ариун, ариун, ариун”




Зураг 7.1

“Та нарын Эзэн Бурхан
бол ариун Бурхан.”




Зураг 7.2

“Бид ариун болгуулсан.”



Зураг 7.3

“Надтай адил
ариун бай.”



Зураг 7.4

Судлал

Түлхүүр ишилэл

Эзэн Есүсийн низүүлсэл, Бурханы хайр,
Ариун Сүнсний нөхөрлөл та бүгдтэй
хамт байх болтугай.

2 Коринт 13:14

Судлах асуултууд

- Коринтын чуулганд хандсан элч Паулын энэхүү ерөөл нь юугаараа өвөрмөц байна вэ?
- Энд хэдэн Бие дурдагдаж байна? Тэд хэн бэ?
- Энэ ерөөлдөө Паул ягаад гурвууланг нь дурдсан юм бол?
- Гурвал Бурхантай харилцах харилцааг маань ямар үгээр илэрхийлэх вэ?
- Таны бодлоор нигүүлсдэг нь ганц Есүс үү? Бурхан Эцэг л зөвхөн хайлрадаг уу? Ариун Сүнс л нөхөрлөлийг бий болгодог уу?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

Бурханы Нэгдмэл шинж

- Дэд хууль 6:4
 - Израилийн энэхүү тунхаглалаас та юуг харж чадах вэ?
 - Энд хэдэн Бурхан байна вэ?
- Исаиа 44:6
 - Хэн “эхэн ба эцэс” вэ?
 - Энд хэдэн Бурхан гарч байна вэ?
- 1 Коринт 8:4
 - Харь үндэстнүүд шүтээнүүддээ тахил өргөхдөө үнэн бурхадад мөргөж байсан уу?
 - Энэ ишлэлд хэдэн Бурхан байна вэ?
 - Дээрх гурван ишлэлийн дүгнэлт нь юу вэ?

Хуучин Гэрээг судлах нь

- Эхлэл 1:26 • Исаиа 6:8
 - Энэ хоёр ишлэл дээр хэн ярьж байна вэ? Бурхан хэнд хандаж ярьж байна вэ?

- Ярианы сэдэв нь юу вэ?
- Энэ нь бидэнд юуг хэлж байна вэ?

Шинэ Гэрээг судлах нь


- *Матай 3:16-17*
 - Хэн баптисм хүртэж байна? Тэнгэрээс дуугарч буй нь Хэн бэ? Хэн тагтаа адил бууж ирэв? Хэдэн Бие дурдагдав?
- *Матай 28:19*
 - Шинэ итгэгчдэд Хэний нэрээр баптисм хүртээхийг тушаасан бэ? Хэдэн Бие дурдагдав?
- *Иохан 14:16-17*
 - Энэ хэсэгт Есүс Хэнд хандан залбирах гэж байна вэ? Тэр юуг гүйж байна вэ? Хэдэн Бие дурдагдав?

Нэгдэл ба гурвал - загвар


- *Иохан 17:20-21*
 - Есүс, Эцэг хоёрын хооронд ямар нэгэн таарамжгүй зүйл байна уу?
 - Есүсийн залбирлын дагуу ертөнцийг итгүүлэх хэмжээнд бид хэрхэн нэгдмэл байх вэ?
 - Итгэгчдийн дундах хайр, нэгдмэл чанарыг ажигласандаа итгэгч болсон хүмүүсийг та мэдэх үү?

**Хэрэгжүүлэх
төлөвлөгөө**

Нэгдмэл байдлын загвар



Зураг 8.1



Зураг 8.2

Сүнсээр дүүрэн байх нь

Судлал

Түлхүүр ишлэл

Би Энэгээсээ зүйхад, Тэр та нарт өөр
 Туслагчийг өгнө. Тэр та нартай уурд хамт байна –
 Тэр бол үнэний Сүнс.

Иохан 14:16,17а

Судлах асуултууд

- Хэн үүнийг хэлсэн бэ?
- Энэ ишлэлд Есүсийг оролцуулаад хэдэн Бие байна вэ?
- Есүс яагаад “өөр Туслагч”-ийг өгнө гэж амласан бэ?
- Ариун Сүнс ямар талаараа “Туслагч” вэ? “Туслагч” гэдэг үгийн оронд өөр ямар ямар үгийг хааяа ашигладаг вэ?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

Бүх үнэний Багш

- Иохан 14:26 • Уйлс 6:8-10
- Иохан Ариун Сүнсий нэгэн чухал үйлчлэлийг тайлбарласан. Тэр нь юу вэ? Та урьд нь үүнийг амсаж байсан уу? Есүсийн зааж байсан зүйлс яг хэрэгцээтэй цагт толгойд чинь орж ирээд л!
- Ариун Сүнс нь “үнэний Сүнс” гэж нэрлэгддэг. Чуулганд Сүнс үнэнийг, “эрүүл сургаал”-ыг хэрхэн заадаг вэ? Сайн номлол, эрүүл сургаалаар дутахад Чуулганд юу тохиолддог вэ?
- Стефаны үйлчлэлд гайхамшигт тэмдгүүд байсан. Мөн түүнийг ярьж байхад хүмүүс бараг эсэргүүцэж чаддаггүй байсан. Яагаад тэр вэ?

Хүлээн зөвшөөрөх, гэмээ илчлэх, дуулгавартай, цэвэр ариун байх

- Иохан 16:7-8 • 1 Иохан 1:9
- Үнэний Сүнс нь Есүсийн зааж байсан үнэнтэй холбоотой. Хувийн амьдралд маань Сүнс хэрхэн үнэнийг заадаг вэ?
- Хэрэв бид нүгэлтэй гэдгээ мэдвэл яах ёстой вэ? Биднийг дуулгавартай дагасны хариуд Бурхан яадаг вэ?
- Иохан 14:15-16 • 1 Коринт 6:19-20
- Ариун Сүнс, дуулгавартай байдал хоёрын хамаарал нь юу вэ? Иохан

14-ийн 15, 16-р ишлэл ямар холбоотой вэ?

- Ариун Сүнсний орших “сүм” гэдэг нь юу вэ? Бидний хувьд энэ сүмийг арчлахад хийх шаардлагатай зүйлс нь юу вэ?

Ариун Сүнсээр дүүрэн байх

• *Үйлс 1:3-8*

- Амилсныхаа дараа Есүс дөч хоногийн турш дагалдагчидтайгаа хамт байсан ба тэдний нүдний өмнө тэнгэрт одсон (Үйлс 1:9-11). Үр дүнтэй гэрчлэгчид байхын тулд эдгээр дагалдагчид хаанаас хүчийг авах вэ?

• *Үйлс 6:3-7*

- Эхэн үеийн чуулган үйлчлэгч болохыг хүссэн хүнд ямар шалгуурыг тавьдаг байсан бэ? “Сүнсээр дүүрэн” үйлчлэлийнх нь үр дүн нь юу байв?

• *Үйлс 11:24*


- Энэ ишлэл дээр Барнабыг итгэл ба Ариун Сүнсээр дүүрэн байсан гэж байна. Үр ашиг нь юу байв?

• *Ефес 5:18*

- Энэ ишлэл нь Грек хэлэн дээрээ дараахыг илэрхийлж буй тушаал юм: “Үргэлжлүүлэн Сүнсээр дүүрсээр бай.” Бид яаж байнга Сүнсээр дүүрэн байх вэ?

**Хэрэгжүүлэх
төлөвлөгөө**

Ариусгагдсан ба дүүрсэн



Зураг 9.1

Судлал

Түлхүүр ишлэл

“Би Эцэгийнхээ амласнааг та нарт илзээнэ.

Харин та нар дээрээс ирэх хүчийг өмснэлээ
энэ хотдоо үлг.”

Лук 24:49

Судлах асуултууд

- Эцэг өөдөөгөө одохын өмнө Есүсийн хэлсэн зүйлүүдийн нэг нь энэ юм.
Эцэгийн амлалт юу байв?
- Дагалдагчдыг Иерусалимд үлдэж, Ариун Сүнсийг хүлээхийг Есүс яагаад захив? Шууд хүмүүст сайн мэдээг тунхаглаад эхлэхийг яагаад тушаасангүй вэ?
- Дагалдагчид нь “хүчийг өмсөх” тухай хэлэхдээ Есүс юуг ойлгуулах гэсэн юм бол?
- Дагалдагчдын үйлчлэлд Бурханы хүч яагаад хэрэгтэй юм бол? Бурханы тушаасан зүйлүүдийг хийхэд бидэнд ч бас Бурханы хүч хэрэгтэй юу?
Бид өөрсдийнхөө чадалд найдвал юу болох вэ?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

Түүний чанараар тоноглогдох

- Ром 5:5 • Галат 5:22-23
- Бидэнд Бурханы хайрыг хүртэх боломжийг юу өгсөн бэ?
- Бид яаж итгэгч хүний мөн чанаруудыг хүлээн авдаг вэ? Энэхүү чанарууд нь бидний доторх Бурханы дүр төрхийг хэрхэн харуулдаг вэ?
- Ариун Сүнсний тусlamжгүйгээр бид Бурхантай адил болж чадах уу?
- Эдгээр чанарууд нь зөвхөн зарим нэг итгэгчдэд зориулагдсан уу – эсвэл бүх итгэгчид үү?

Түүний үйлчлэлийн төлөө хүчирхэгжих нь

- Иохан 14:12-17
- Есүс ямар ямар ажил хийсэн бэ?
- Бид хэрхэн агуу ажлыг хийх вэ? Есүс үүнийг хэрхэн тайлбарласан бэ?
- Ром 12:6-8 • 1 Коринт 12:4-11
- Эдгээр ишлэлд итгэгчдэд өгсөн Ариун Сүнсний бэлгүүдийн тухай

бичигдсэн байдаг. Нэг хүнд энэ бүх бэлэг авьяас нь байх боломжтой болов уу? Зөвшөөрсөн эсвэл үгүйсгэснийхээ шалтгааныг хэлнэ үү?


- Ариун Сүнсний өөр өөр бэлгүүдтэй хэсэг бүлэг итгэгчид нэгдэн илүү томоор Бурханы дүр төрхийг чуулганд болон ертөнцөд хэрхэн харуулах боломжтой вэ?
- Бусдын сайны төлөө Ариун Сүнс таны дотор хөгжүүлээсэй гэж хүсэж буй ямар нэгэн бэлэг авьяас байна уу?

Түүний дүр төрхийн дагуу өөрчлөгдэх нь

- 2 Коринт 3:18
 - 1 Коринт 2:10-12,16
- Бид хэнээр дамжуулан хэрхэн өөрчлөгдж байна вэ?
 - Христ уруу хараагаа чиглүүлэхд бидний дотор юу болох вэ?
 - Сүнс бидэнд яаж тусалдаг вэ? Яагаад?
 - Бурханы ойлголтуудыг бид хэрхэн ухаарах вэ?
 - Ариун Сүнсээр дамжуулан Эзэний хүслийг мэдэх нь бидний доторх Христийн дүр төрхийг хэрхэн төлөвшүүлэх вэ?

**Хэрэгжүүлэх
төлөвлөгөө**

“Илүү агуу ажил”



Зураг 10.1

Бурхан ба үл үзэгдэгч ертөнц

Судлал

Түлхүүр ишлэл

Бяцхан хүүхдүүг ээ, та нар Бурханыг бөгөөд
тэднийг дийлсэн. Үчир нь та нарын дотор байгаа
Тэр бол дэлхийг байчи нэгнээс агуу.

1 Иохан 4:4

Судлах асуултууд

- “Дэлхийд байгч нэгэн” гэдэг нь хэн бэ? (1 Иохан 4:3-ыг хар.)
- “Та нарын дотор байгаа Нэгэн” гэдэг нь хэн бэ?
- Бид хэнийг дийлсэн юм бэ? Яаж?

Туслах ишлэлүүд ба судлах асуултууд

Бурхан ба Есүс – бүхнийг захирдаг

- Иохан 4:24
- Колоссай 1:16
- Колоссай 2:15
- 1 Петр 3:21б-22
- Иохан номын 4-р бүлэгт Бурханыг хэрхэн илэрхийлсэн бэ? Энэ нь Бурханы талаарх таны өмнөх ойлголттой хэр дүйцэж байна?
- Есүс хэр их зүйлийг бүтээсэн бэ? Ул үзэгдэх хүч, захирагч, эрх мэдэлтнүүдийг хэр олноор нь бүтээсэн бэ? Бурхан бузар муу сүнснүүдийг бүтээсэн болов уу?
- Тэрслүү хүч ба эрх мэдэлтнүүдийг Есүс хэрхэн ялан дийлсэн бэ?
- Амилсныхаа дараа Есүс тэнгэр өөд одсон. Бүх хүч чадал, тэнгэр элч, захирагчдын дээгүүр Түүнд ямар эрх мэдэл байгаа вэ?

Ариун тэнгэр элч нар

- Еврей 1:14
- Бурханы ариун тэнгэр элч нарын нэг ажил нь юу вэ?
- Дуулал 103:20-21
- Тэнгэр элч нарыг бид илгээдэг үү, Бурхан илгээдэг үү? Тэнгэр элч нар хэний хүсэлд захирагддаг вэ?
- Ййлс 5:18-20
- Петрт юу тохиолдсон бэ? Тэнгэр элч нар хүнд үйлчлэхээр Бурханаас илгээгддэг өөр жишээг та санаж байна уу?

Сатан ба муу сүнснүүд

- *Лук 10:17-18*
 - Дагалдагчид юу гэж хэлсэн бэ? Есүсийн хариу юуг илэрхийлэв? (Исаиа 14:12-15-ыг үз.)
- *Матай 25:41*
 - Диавол болоод түүний дагалдагчдын мөнхийн хувь тавилан юу вэ?

Сатаны заль мэх – Ов заль ба уруу татлага

- *2 Коринт 11:3* • *1 Коринт 10:13*
 - Сатан хүмүүсийг Христээс салгахаар хэрхэн уруу татдаг вэ?
 - Уруу татах нь нүгэл үү? Бурхан яагаад үүнийг зөвшөөрдөг вэ?
 - Сатан биднийг нүгэлд уруу татахдаа Бурхантай харилцах харилцааг маань яахыг хүсдэг вэ? Бидний доторх Бурханы дүр төрхийг тэр яах хүсэлтэй вэ?
 - Бурханы дүр төрх нь үнэн ба ариун байдал дээр тогтдог. Сатаны заль мэх ба уруу татлагын аргаас та юуг ажиглаж байна вэ?

Бурханы тусламж – Бидний доторх дүр төрхөө хамгаалах нь

- *Лук 4:1-14*
 - Есүс Сатаны ямар гурван сорилтыг давсан бэ? Тэдгээрийг хүмүүст өнөөдөр тулгардаг сорилтуудтай харьцуулан тайлбарла.
 - Есүс Сатаны уруу татлагыг ямар замаар эсэргүүцсэн бэ? Бид уруу татлагуудыг хэрхэн мөн адил даван туулах вэ?
- *Иаков 4:7* • *1 Петр 5:8-9*
 - Диаволыг эсэргүүцэхийн тулд бид юу хийх боломжтой вэ? Бид Бурханд захирагдмагц юу болдог вэ?
 - Петр Сатаныг хэрхэн дүрсэлсэн бэ? Диаволыг эсэргүүцэхийн тулд бид өөр юу хийх ёстой вэ?
 - Бурхангүйгээр бид диаволоос хүчтэй болов уу?
- *Ефес 6:11-17*
 - Сурах бичиг дээрх Зураг 11.1-ийг хар.
 - Хэдийгээр Сатан бидний доторх Бурханы дүр төрхийг устгахыг хүсдэг ч Бурхан түүнийг нь хамгаалахын тулд юу хийсэн бэ?
 - Зөвт байдлын хуяг гэдэг нь юу вэ? Энэ нь биднийг хэрхэн хамгаалах вэ? Бидний дайсан хэн бэ?
 - Үнэний бүс гэдэг нь юу вэ? Дайсантайгаа тулахад маань энэ нь бидэнд яаж туслах вэ? Итгэлийн бамбай нь юу вэ? Энэ нь муу нэгний сумыг хэрхэн унтраах вэ? Сүнсний сэлмийг та яаж ашиглах вэ?
 - Зэвсгүүдийг нь хараарай. Хууран мэхлэлт хийгээд сорилтоос бидний доторх Өөрийнхөө дүр төрхийг хамгаалах арга замыг Бурхан бидэнд өгсөн гэж хэлж болох уу?


Шүтээнд мөргөх явдал (Сонголттой хэсэг)

- *Илчлэлт 9:20* • *Дэд хууль 32:16,17,21a*
 - Бурхан биднийг Өөрийнх нь дүрд юмуу ямар нэгэн зүйлд мөргөхийг хүсэх үү?

- ❑ Хуурамч шүтээний цаана байгаа хүч нь юу вэ?
 - ❑ Шүтээн шүтэх явдлаасаа гэмшиж, эргээгүй хүмүүст юу тохиолдох вэ?

Хэрэгжүүлэх төлөвлөгөө

**Бидний дотор буй
Бурханы дүр төрхийг хамгаалах нь**



Зураг 11.1

Судлал

#1 Бурханы дүр төрх

Эхлэл 1:27

Тэгээд Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж, Бурханы дүр төрхөөр эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээв.

- Бид Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн. Нэгэнт Бурханы дүр төрхийг агуулж байдгийнх нь хувьд хүн төрөлхтний үнэ цэng ойлгох болсон тул энэ нь таны өөрийгөө болон бусдыг үзэх үзэлд хэрхэн нөлөөлж байна вэ?

Сэтгэгдэл

#2 Эхэнд Бурхан

Эхлэл 1:1

Эхэнд Бурхан тэнгэр газрыг бүтээжсээ.

- Бурхан бол бүхний агуу Бүтээгч. Тэр бидэнд бүтээлч чанарыг ёгсөн нь гайхалтай. Түүгээр бид урлаг, яруу найраг, дуу хөгжим, бизнест төрөх шинэ санаа, үйлчлэл ба хувийн амьдралаа зохицуулдаг. Та ойрын үед ямар бүтээлч зүйл хийв? Бүтээлч чанар тань Бурханы дүр төрхийг тусган харуулдаг гэдгийг та мэдсэн үү?

Сэтгэгдэл

#3 Бурхан бүхнийг захирдаг

Матай 28:18

Есүс ойртон ирээд, тэдэнд “Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн” гэж айлдав.

- Есүст бүх эрх мэдэл өгөгдсөн ба тэнгэр газар дээр оршигч бүхэн Түүний өмнө өвдөг сөгдөх болно. Тэрээр бүрэн эрх мэдэлтэй ч бидэнд Өөрт нь захирагдах, угүйг сонгах чөлөөт сонголтыг өгсөн. СҮҮРЬ ҮНДЭС II номыг сурх явцдаа Есүсийн Хаанчлалд амьдралынхаа ямар нэг хэсгийг та захируулсан уу? Юу болсон бэ?

Сэтгэгдэл _____

#4 Эцэгийн зүрх сэтгэл

Ром 8:15,16

Дахин айдаст хүргэх боолчлолын сүнсийг та нар хүлээн аваагүй, харин црилэлийн Сүнсийг авсан билээ. Түүгээр бид “Аав! Эцэг минь!” гэж дууддаг. Биднийг Бурханы хүчхдүүд гэдгийг Сүнс Өөрөө бидний сүнистэй хамт гэрчилдэг.

- Бурхан Өөрийн хүүхдүүд болох биднийг халамжилдаг. Түүний дүр төрхийг агуулж байдгийнхаа хувьд бид ч мөн адил бусдад халамж үзүүлэх хэрэгтэй. Сүүлийн хэдэн долоо хоногт та хэн нэгэнд Бурханы халамжийг үзүүлсэн үү? Яаж харуулсан бэ? Ирж буй долоо хоногуудад та хэрхэн харуулах вэ?

Сэтгэгдэл _____

#5 Бурхан уучилдаг

Ефес 4:32

Бурхан та нарыг Христ дотор уучилсны адил бие биенээ уучлан, нэг

нэгнийгээ энэрэн уян зөвлөн сэтгэлээр ханд.

- Христ Есүсээр дамжин ирсэн Бурханы уучлалаас бид агуу ашиг шимийг нь хүртсэн. Биднийг хүмүүс яаж ч гомдоож байсан бид мөн уучлах ёстой. Таны эсрэг нүгэл үйлдсэн хүмүүсийг уучлах тал дээр та хэр төлөвшиж байгаагаа бодоорой.

Сэтгэгдэл

#6 Бурхан тэвчээртэй

2 Петр 3:9

Эзэн удаашралыг тооцдог зарим хүмүүсийн боддог шиг Өөрийнхөө амлалтад хойрго биш билээ. Харин ч Тэр хэнийг ч мөхүүлэхийг хүсэлгүй, бүгдийг гэмшилд ирээсэй хэмээн хүсэн та нарт тэвчээртэй ханддаг.

- Бурханы тэвчээрийн үр дүнд бид аврагдсан. Тэвчээрийн үр жимс нь үнэхээр сайхан. Сүүлийн үед танд илүү тэвчээртэй болоход тань юу юу тус болсон бэ? Бурханы танаас хүсэж буй тэвчээрийг зарим талаараа та гаргаж чадахгүй байгаа хэвээрээ юу?

Сэтгэгдэл

#7 Бурхан бол ариун

1 Петр 1:15-16

Харин та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтуун. Яагаад гэвэл “Би ариун учраас та нар ариун байгтуун” гэж бичигдсэн юм.

- Бид Бурханаар ариусгагдсан. Мөн бид ариун байдал дотор өсөж байгаа. Энэ бол амьдралын турш үргэлжлэх үйл явц юм. Бурханд хүндэтгэлгүй зүйлсээс бид эргэж, Түүнийг алдаршуулдаг зүйл уруу хандах ёстой. Амьдралд тань Бурханы илүү ариун болгожыг хүсэж буй талбар байна уу? Танд тустай юут та сурав?

Сэтгэгдэл _____

#8 Нэгдмэл байдал ба Гурвал

2 Коринт 13:14

Эзэн Есүс Христийн нигүүлсэл, Бурханы хайр, Ариун Сүнсний нөхөрлөл та бүгдтэй хамт байх болтугай.

- Бурхан, Эзэн Есүс ба Ариун Сүнс төгс нэгдэлтэй. СУУРЬ ҮНДЭС II номыг сурснаар таны бусадтай харилцах харилцаа сайжирсан уу? Эсвэл илүү нэгдмэл болгохоор зэхэж буй харилцаагаа тодорхойлно уу.

Сэтгэгдэл _____

#9 Сүнсээр дүүрэн байх нь

Иохан 14:16,17а

“Би Эцэгээсээ гүйхад, Тэр та нарт өөр Туслагчийг өгнө. Тэр нь та нартай цүрд хамт байна. Тэр бол үнэний Сүнс мөн.”

- Бид ганцаараа биш. Хэрэв бид гүйвал Бурхан бидэнд Ариун Сүнснийг өгнө гэдгээ амласан. Ариун Сүнс бол бүхий л үнэний холбоос ба тайтгаруулагч билээ. Ариун Сүнс мөн бидний нүглийг илчилж өгдөг. Ингэснээр бид гэмшиж, цэвэрлэгдэх хэрэгтэй. Ариун Сүнсээр дүүргэж өгөөч гэж та Бурханаас гүйсан уу? Хэрэв та хүсэж байвал Ариун Сүнс таныг үргэлж дүүргэн оршиж байхын төлөө болон та өөрөө үнэний амжилттай гэрчлэгч байхын төлөө бүлгийнхнээрээ залбируулаарай.

Сэтгэгдэл _____

Лук 24:49

Би Эцэгийнхээ амласныг та нарт илгээнэ. Харин та нар дээрээс ирэх хүчийг өмстлөө энэ хотдоо үлд.

- Христитгэлийн амьдралд бусдыг ивээхийн тулд бид Ариун Сүнсний хүч чадалд найдах ёстой. Сүнсний үр жимсийг Ариун Сүнс бидний дотроос ургуулахын хэрээр бид Бурханы дүр төрхийг агуулдаг. Есүс Ариун Сүнсний хүчээр агуу ажлуудыг гүйцэтгэж байсан ба биднийг ч мөн адил ажлуудыг хийх болно гэдгийг амласан. Энэ талаараа ч бид мөн Бурханы дүр төрхийг агуулна. Ариун Сүнс биднийг Бурханы дүр төрхийн дагуу шинэчлэн өөрчилж байгаа гэдгийг Бичээс хэлдэг. Ариун Сүнс тэй хамт алхахын хэрээр та хувьдаа юу сурав?

Сэтгэгдэл

#11 Бурхан ба үл үзэгдэх ертөнц

1 Иохан 4:4

Бяцхан хүчхдүүд ээ, та нар Бурханых бөгөөд тэднийг дийлсэн. Учир нь та нарын дотор байгаа Тэр бол дэлхийд байгч нэгнээс агуу.

- Бурхан бол сүнс бөгөөд Сатан хийгээд бүхий л сүнслэг биеийг захирдаг. Сатаны зорилго бол бидний доторх Бурханы дүр төрхийг буюу Түүний ажлыг сүйтгэх юм. Бурхан бидний дотор байж, бидэнд хүчийг өгдөг тул бид муу нэгнийг эсэргүүцэн бат зогсох болно. Ойрын үед уруу татлага, заль мэхийг гайхалтайгаар ялан дийлсэн тохиолдол танд байна уу? Товчхон хуваалцаарай.

Сэтгэгдэл

#12 Миний доторх Бурханы дүр төрх

- СУУРЬ ҮНДЭС II номноос танд хамгийн их хэрэгтэй байсан хоёр,

СҮҮРЬ ҮНДЭС Цогц бүрэн Дагалдагч бэлтгэл: Бурханы дүр төрх


гурван зүйлийг нэрлэнэ үү? Өдөр тутмын тань амьдралд туслах, Бурханы талаар ямар ойлголтыг та авав? Таны анх бүтээгдсэн хэв шинж болох Бурханы дүр төрхийн дагуу өөрчлөгдхөд танд юу тусалсан бэ?

Сэтгэгдэл _____

- Хичээл хоорондох хэрэгжүүлэлтийн явцад танд хамгийн их нөлөөлсөн хэрэгжүүлэлт юу байв? Аль хэрэгжүүлэлт тань бусдад илүү нөлөөлөв? Яагаад?

Сэтгэгдэл _____

Бидний доторх Бурханы дүр төрх



Зураг 12.1

Цээжлэх ийнлавд

Тэзээг Бүрхан Өөрийнхөө дүр төрхөөр
хүнийг бүтээж, Бүрханыг дүр төрхөөр
эрэzmэй эмэzmэй хүнийг бүтээв.

Эхлэл 1:27

Эхэнг Бүрхан тэнзэр газрыг бүтээжээ.

Эхлэл 1:1

Есүс ойртон ирээг, тэдэнг
“Тэнзэр газар дээрх бүх эрх мэдлийг
Нагаг өгсөн” зэж айлдав.

Матай 28:18

Дахин айдасыг хүргэх боолилолын
сүнсийг та нар хүлээн аваагүй, харин
үрилэлийн Сүнсийг авсан билээ.

Түүзээр бид “Аав! Энэг минь!”
зэж дүүggaz. Биднийг Бурханыг хүүхдүүг
зэгээнийг Сүнс Θөрөө бидний
сүнсмэй хамт зэрчилдээз.

Ром 8:15,16

Бурхан та нартаг

Христ дотор үүчиilstныг адил бие биеэ
үүчлан, нэг нээтийзээ энэрэн үян зөвлөн
сэмзэвлээр ханг.

Ефрес 4:32

Эзэн үдаашралыг тооцдог зарим
хүмүүсийн боддог шиз Θөрийнхөө
амлалтаг хойрго биш билээ. Харин и
Тэр хэнийг и мөхүүлэхийг хүсэлгүй,
бүгдийг зэмшилд ирээсэй хэмээн хүсэн
та нарт тэвчээртэй хангдаг.

2 Петр 3:9

Харин та нартаг дүүдсэн Ариун Нэгэний
агул өөрсдийн бүх л зан байдалдаа бас
ариун байзмуун. Яагаад зэвэл “Би ариун
чираас та нар ариун байзмуун” зэж
бичиждсэн юм.

1 Петр 1:15-16

Эзэн Есүс Христийн тизүүлсэл,
Бурханы хайр, Ариун Сүнсний нөхөрлөл
та бүгдмэй хамт байх болтугай.

2 Коринт 13:14

“Би Энэзээсээ зүйхаг,
Тэр та нарт өөр Түслэгийг өгнө.
Тэр нь та нартай үүрд хамт байна.
Тэр бол үнэний Сүнс мөн.”

Иохан 14:16,17а

“Би Энэзийнхээ амластыг та нарт илзээнэ. Харин та нар дээрээс ирэх хүнийг өмсглөө энэ хомдоо үлд.”

Лук 24:49

Бяцхан хүүхдүүг ээ, та нар Бүрханыг бөгөөд тэднийг дийлсэн.

Үчир нь та нартын дотор байгаа Тэр бол дэлхийд байж нээнээс агуул.

1 Кохан 4:4

Нэмэлт ишлэлүүд

Нэмэлт судалгаа, эргэцүүлэл, залбиral ба хэрэгжүүлэлтэд зориулав.

Хичээл 1: Бурханы дүр төрх

2 Коринт 4:4	Эхлэл 1:26	Иаков 3:9
Ром 8:29	1 Коринт 15:49	1 Иохан 3:1-3

Хичээл 2: Эхэнд Бурхан

Иохан 1:1-3	Иеремиа	1:5 Эхлэл 1:1-3
-------------	---------	-----------------

Хичээл 3: Бурхан бүхнийг захирдаг

Дуулал 147:5	Сургаалт үгс 15:3	Марк 1:15
Шастирын дээд 29:11-13 1	Тимот 6:15,161	Тимот 1:17

Хичээл 4: Эцэгийн зүрх сэтгэл

Иохан 16:27	Иохан 20:17	Галат 4:6,7
Еврей 2:10-11	Ефес 6:4	Колоссай 3:21

Хичээл 5: Бурханы уучилдаг

Марк 11:25	Колоссай 3:13	Лук 17:3-4
Матай 5:39-48	Лук 6:27-36	1 Петр 2:21-23
1 Петр 3:9-12 Эхлэл 50:15-21		Ром 12:19,20

Хичээл 6: Бурхан тэвчээртэй

Ром 8:24-25	1 Коринт 13:4-7	Сургаалт үгс 19:11
2 Петр 3:8-15	Колоссай 3:12-13	Иаков 1:2-4

Хичээл 7: Бурхан бол ариун

Иохан 17:17	Ром 15:15-16	Еврей 12:14
Ром 14:17	1 Тесалоник 4:3-8	1 Коринт 1:30

Хичээл 8: Нэгдмэл байдал ба Гурвал

Эхлэл 11:7	Иохан 1:1	Филиппой 2:5-6
Эхлэл 1:1-2	Үйлс 5:3-4	Лук 1:35

Хичээл 9: Сүнсээр дүүрэн байх нь

Үйлс 2:38	Лук 11:13	Иохан 3:6-8
Иохан 7:37-39	1 Коринт 12:13	Үйлс 10:44-46

Хичээл 11: Бурхан ба үл үзэгдэх ертөнц

2 Петр 2:1-4	Илчлэлт 12:7-9	Үйлс 10:1-6
Үйлс 12:6-11	Еврей 1:3-14	Ефес 1:19-21

